Н.Гэндэнжамцын нэрэмжит
Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонт
Нэгдсэн үндэстний байгууллагын шагналт
**ЭХ, ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ**

Статистик мэдээлэлзүйн тасаг

# ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЗҮҮЛЭЛТ 2025

Улаанбаатар хот

**Тайлан бичсэн**

| | |
|---|---|
| **Хянасан:** | Ж.Отгонбаатар<br>ЭХЭМҮТ-ийн Захирал, АУ-ны доктор,<br>Клиникийн профессор |
| **Эх бэлтгэсэн:** | Г.Гантуяа<br>Статистик мэдээлэлзүйн тасгийн эрхлэгч<br>М.Баялаг<br>Тандалт судалгааны албаны дарга<br>А.Оюунчимэг<br>Статистик мэдээлэлзүйн тасгийн их эмч<br>Т.Гантуяа<br>Тандалт судалгааны албаны их эмч<br>П.Орхонтуул<br>Тандалт судалгааны албаны ажилтан<br>Б.Хишигжаргал<br>Тандалт судалгааны албаны их эмч<br>Б.Нямбадам<br>Тандалт судалгааны албаны их эмч<br>О.Анударь<br>Тандалт судалгааны албаны их эмч<br>Д.Хонгорзул<br>ЭХЭМҮТ-ийн эдийн засагч<br>Д.Батдэлгэр<br>ЭМД-ын нягтлан бодогч<br>Т.Мөнхтуул<br>ЭМД-ын их эмч<br>Г.Цэрэндулам<br>ЭМД-ын их эмч |
| **График дизайнер:** | Б.Бүрэнжаргал<br>Тандалт судалгааны албаны ажилтан |
| **Статистикч-операторч:** | Б.Хандаа<br>Ч.Эрдэнэчимэг<br>Ш.Ризагүл<br>Б.Гантөмөр<br>Т.Риза |

# АГУУЛГА


**АГУУЛГА** 3

**ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ** 4

**ЗУРГИЙН ЖАГСААЛТ** 6

**ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР** 9

**ӨМНӨХ ҮГ** 11

**1. ЭХ ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** 12

**2. ЭХЭМҮТ-ИЙН 2025 ОНЫ ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ** 14

2.1. Үндсэн үзүүлэлт 14

2.2. Эхийн ноцтой хүндрэл, эхийн эндэгдэл, 2021-2025 он, ЭХЭМҮТ 22

**3. ТӨРӨЛХИЙН ХӨГЖЛИЙН ГАЖИГ, МОНГОЛ УЛС, ЭХЭМҮТ** 29

**4. ЭХЭМҮТ-ИЙН ЭХ БАРИХ ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ** 31

4.1. Хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээ 31

4.2. Эх барих эмэгтэйчүүдийн амбулаторийн тусламж үйлчилгээ 39

**5. ЭХЭМҮТ-ИЙН ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ** 42

5.1. Хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээ 42

5.2. Хүүхдийн дотрын төрөлжсөн мэргэжлийн тусламж үйлчилгээ 46

5.3. Хүүхдийн төрөлжсөн мэс заслын тусламж үйлчилгээ 51

5.4. Хүүхдийн амбулаторийн тусламж үйлчилгээ 57

**6. ЭРЧИМТ ЭМЧИЛГЭЭНИЙ ТАСГУУДЫН ОРНЫ ҮЗҮҮЛЭЛТ, ЭХЭМҮТ, 2021-2025 ОН** 62

**7. ЭХЭМҮТ-ИЙН ӨДРИЙН ЭМЧИЛГЭЭ, ӨДРИЙН МЭС ЗАСАЛ, ДАВТАН ХАГАЛГАА, АЛСЫН ДУУДЛАГЫН ТОВЧООН, 2025 ОН** 65

Өдрийн эмчилгээ 65

Өдрийн мэс засал 65

Давтан хагалгаа 65

Дурангийн мэс засал 65

ЭХЭМҮТ-ийн төрөлжсөн мэргэжлийн тусламжийн дуудлагын үйлчилгээ 66

Хүүхдийн эмнэлгийн Мэдээгүйжүүлэг хагалгааны нэгдсэн тасаг 66

**8. ӨСВӨР ҮЕИЙН КЛИНИКИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ** 68

**9. ЭХЭМҮТ-ийн 2025 ОНЫ САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН** 71

# ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ


| | | |
|---|---|---|
| Хүснэгт 1. | ЭХЭМҮТ-д хэвтэн эмчлүүлэгчид, хот, хөдөө, 2021-2025 он | 16 |
| Хүснэгт 2. | Өвчлөлийн бүтэц, стационарт хэвтэн эмчлүүлэгчид, ЭХЭМҮТ, 2021-2025 он | 18 |
| Хүснэгт 3. | Перинатал, нярайн эндэгдлийн түвшин, ЭХЭМҮТ, 2021-2025 он | 21 |
| Хүснэгт 4. | Нас баралтын зонхилох шалтгаан, ЭХЭМҮТ, 2021-2025 он | 22 |
| Хүснэгт 5. | Төрөлт, эхийн амь насанд заналхийлсэн хүндрэл, хүндрэлийн харьцаа, ЭХЭМҮТ, 2021-2025 он | 23 |
| Хүснэгт 6. | Амьд төрөлт, эхийн амь насанд заналхийлсэн хүндрэл, хүндрэлийн харьцаа, Монгол Улс, аймгийн дүн | 23 |
| Хүснэгт 7. | Амьд төрөлт, эхийн амь насанд заналхийлсэн хүндрэл, хүндрэлийн харьцаа, Улаанбаатар хот, ЭХЭМҮТ | 24 |
| Хүснэгт 8. | Ноцтой хүндрэл, эрхтэн тогтолцооны үйл ажиллагааны алдагдал, ЭХЭМҮТ, 2021-2025 он | 25 |
| Хүснэгт 9. | Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв - Эрүүл мэндийн үндсэн үзүүлэлт, 2024-2025 он | 26 |
| Хүснэгт 10. | ЭХЭМҮТ-д хэвтэн эмчлүүлээд гарсан өвчтөн, аймаг, дүүргээр, 2025 он | 27 |
| Хүснэгт 11. | Төрөлхийн хөгжлийн гажигтай бүртгэгдсэн нярай, ӨОУА-10, ЭХЭМҮТ, 2021-2025 он | 29 |
| Хүснэгт 12. | Төрөлхийн хөгжлийн гажигтай төрсөн нярай, ӨОУА-10, ЭХЭМҮТ, 2021-2025 он | 30 |
| Хүснэгт 13. | Өвчлөлийн бүтэц, стационарт хэвтэн эмчлүүлэгчид, ЭХЭМҮТ, ЭБЭЭ, 2021-2025 он | 36 |
| Хүснэгт 14. | ЭХЭМҮТ-ийн Эх барих эмэгтэйчүүдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний үзүүлэлт, 2025 он | 37 |
| Хүснэгт 15. | ЭХЭМҮТ-ийн төрөлтийн мэдээлэл, 2025 он | 38 |
| Хүснэгт 16. | ЭХЭМҮТ, Нөхөн үржихүйн зөвлөх поликлиникийн тусламж үйлчилгээний үзүүлэлт, 2025 он | 40 |
| Хүснэгт 17. | Өвчлөлийн бүтэц, стационарт хэвтэн эмчлүүлэгчид, ХЭ, ЭХЭМҮТ, 2021-2025 он | 44 |
| Хүснэгт 18. | Нас баралтын үзүүлэлт, ХЭ, ЭХЭМҮТ, 2021-2025 он | 45 |
| Хүснэгт 19. | Нас баралтын зонхилох шалтгаан, ХЭ, ЭХЭМҮТ, 2021-2025 он | 45 |
| Хүснэгт 20. | Өвчлөлийн бүтэц, стационарт хэвтэн эмчлүүлэгчид, ЭХЭМҮТ-ийн хүүхдийн дотрын төрөлжсөн мэргэжлийн тусламж үйлчилгээ, 2021-2025 он | 48 |
| Хүснэгт 21. | Нас баралт, хүүхдийн дотрын төрөлжсөн мэргэжлийн тусламж үйлчилгээ, ЭХЭМҮТ, 2021-2025 он | 48 |
| Хүснэгт 22. | Нас баралт, хүүхдийн дотрын төрөлжсөн мэргэжлийн тусламж үйлчилгээ, ӨОУА-10, 2021-2025 он | 49 |
| Хүснэгт 23. | Хүүхдийн дотрын төрөлжсөн мэргэжлийн тусламж үйлчилгээний үзүүлэлт, ЭХЭМҮТ, 2025 он | 50 |

Хүснэгт 24. Өвчлөлийн бүтэц, хэвтэн эмчлүүлэгчид, хүүхдийн мэс заслын тусламж үйлчилгээ, ЭХЭМҮТ, 2021-2025 он 53
Хүснэгт 25. Нас баралт, хүүхдийн мэс заслын тасгууд, ЭХЭМҮТ, 2021-2025 он 55
Хүснэгт 26. Хүүхдийн төрөлжсөн мэс заслын тусламж үйлчилгээний үзүүлэлт, ЭХЭМҮТ, 2025 он 56
Хүснэгт 27. Хүүхдийн зөвлөх поликлиникийн тусламж үйлчилгээний үзүүлэлт, ЭХЭМҮТ, 2025 он 60
Хүснэгт 28. Эрчимт эмчилгээний тасгуудын нас баралт, тоо, хувиар, ЭХЭМҮТ, 2021-2025 он 64
Хүснэгт 29. Мэс заслын тоо, төрөлжсөн мэс заслын тасгаар, ЭХЭМҮТ, 2025 он 65
Хүснэгт 30. Дурангийн мэс засал, төрөлжсөн мэс заслын тасгаар, ЭХЭМҮТ, 2025 он 66
Хүснэгт 31. ЭХЭМҮТ-ийн төрөлжсөн мэргэжлийн тусламжийн дуудлагын үйлчилгээ, 2025 он 66
Хүснэгт 32. Өсвөр үеийн клиникээр үйлчлүүлэгсэд, ЭХЭМҮТ, 2025 он 68
Хүснэгт 33. Эмнэлгийн тусламж үйлчилгээ, насны бүлэг, хүйсээр, Өсвөр үеийн клиник, 2021-2025 он 68
Хүснэгт 34. Эмнэлгийн тусламж үйлчилгээ, өвчлөлийн бүтцээр, Өсвөр үеийн клиник, 2021-2025 он 69
Хүснэгт 35. Өсвөр насны охидын жирэмслэлт, насны бүлэг, ЭХЭМҮТ, 2021-2025 он 69
Хүснэгт 36. Хүүхэд, өсвөр насны хүчирхийлэлд өртсөн байдал, ЭХЭМҮТ, 2021-2025 он 69
Хүснэгт 37. Батлагдсан санхүүжилт, ЭХЭМҮТ, 2021-2025 он 71
Хүснэгт 38. Хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээний санхүүжилт, тасгаар, ЭХЭМҮТ, 2025 он 73
Хүснэгт 39. Өдрийн эмчилгээний санхүүжилт, ЭХЭМҮТ, 2025 он 73
Хүснэгт 40. Амбулаторийн санхүүжилт, ЭХЭМҮТ, 2024-2025 он 74
Хүснэгт 41. Яаралтай тусламж, ЭХЭМҮТ, 2025 он 76
Хүснэгт 42. Гемодиализийн санхүүжилт, ЭХЭМҮТ, 2025 он 76
Хүснэгт 43. Телемедицины санхүүжилт, ЭХЭМҮТ, 2025 он 76
Хүснэгт 44. Алсын дуудлагын санхүүжилт, ЭХЭМҮТ, 2025 он 76
Хүснэгт 45. Сэргээн засах эмчилгээний санхүүжилт, ЭХЭМҮТ, 2025 он 76
Хүснэгт 46. Төлбөрийг төр хариуцан амбулаториор олгох эмийн санхүүжилт, ЭХЭМҮТ, 2025 он 77

# ЗУРГИЙН ЖАГСААЛТ


Зураг 1. Төсөвт ор, ЭХЭМҮТ, 2025 он ... 14
Зураг 2. Орны үзүүлэлт, ЭХЭМҮТ, 2021-2025 он ... 14
Зураг 3. Ор хоногийн төлөвлөгөөний биелэлтийн хувь, ЭХЭМҮТ, 2021-2025 он ... 14
Зураг 4. Хэвтэн эмчлүүлэгчид (тоо, хувиар), ЭХЭМҮТ, 2021-2025 он ... 15
Зураг 5. ЭХЭМҮТ-д хэвтэн, эдгэрч гарсан өвчтөн, аймгаар (бодит тоо, хувиар), 2025 он ... 15
Зураг 6. ЭХЭМҮТ-д хэвтэн эмчлүүлэгчид, орон нутгаар, 2021-2025 он... 16
Зураг 7. Улаанбаатар хотын хэвтэн эмчлүүлэгчид, хувиар, ЭХЭМҮТ, 2021-2025 он... 17
Зураг 8. Хүүхдийн эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчид, насаар, ЭХЭМҮТ, 2021-2025 он ... 17
Зураг 9. Хүүхдийн эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчдэд тав хүртэлх, нялхас, нярай хүүхдийн эзлэх хувь, ЭХЭМҮТ, 2021-2025 он ... 18
Зураг 10. Тав хүртэлх насны хүүхдийн өвчлөлийн бүтэц, ЭХЭМҮТ, 2025 он... 19
Зураг 11. Амаржсан эх (тоо, хувиар), ЭХЭМҮТ, 2021-2025 он ... 19
Зураг 12. Амбулаторийн үзлэг, ЭХЭМҮТ, 2021-2025 он ... 20
Зураг 13. Амбулаторийн үзлэгийн төрөл, ЭХЭМҮТ, 2025 он... 20
Зураг 14. Мэс заслын үзүүлэлт, ЭХЭМҮТ, 2021-2025 он ... 20
Зураг 15. Нас баралтын үзүүлэлт, ЭХЭМҮТ, 2021-2025 он ... 21
Зураг 16. Задлан шинжилгээний үзүүлэлт, ЭХЭМҮТ, 2021-2025 он ... 21
Зураг 17. Эхийн эндэгдлийн харьцаа, Монгол Улс, ЭХЭМҮТ, 2021-2025 он... 24
Зураг 18. Эхийн ноцтой хүндрэлийн харьцаа, Монгол Улс, ЭХЭМҮТ, 2021-2025 он... 24
Зураг 19. Умайн үйл ажиллагааны алдагдал, ЭХЭМҮТ, 2021-2025 он... 25
Зураг 20. ТХГ-ийн тэргүүлэх шалтгаан, хувиар, ЭХЭМҮТ, 2021-2025 он ... 30
Зураг 21. Төсөвт ор, ЭБЭЭ, ЭХЭМҮТ, 2025 он ... 31
Зураг 22. Хэвтэн эмчлүүлэгчид, ЭБЭЭ, ЭХЭМҮТ, 2021-2025 он... 31
Зураг 23. Орны үзүүлэлтүүд, ЭБЭЭ, ЭХЭМҮТ, 2021-2025 он... 32
Зураг 24. Ор хоногийн төлөвлөгөөний биелэлтийн хувь, ЭБЭЭ, ЭХЭМҮТ, 2021-2025 он ... 32
Зураг 25. Улаанбаатар хотоос хэвтэн эмчлүүлэгчид, ЭБЭЭ, ЭХЭМҮТ, 2025 он ... 32
Зураг 26. ЭХЭМҮТ-ийн ЭБЭЭ-т хэвтэн эдгэрч гарагсад, аймгаар (тоо, хувь), 2025 он ... 33
Зураг 27. Төрсөн эх, насны бүлэг, ЭБЭЭ, ЭХЭМҮТ, 2025 он... 33
Зураг 28. Төрөлтийн төгсгөлийн хэлбэр, ЭБЭЭ, ЭХЭМҮТ, 2025 он ... 33
Зураг 29. Үр хөндөлт, ЭБЭЭ, ЭХЭМҮТ, 2025 он... 34
Зураг 30. Үр хөндөлт, насны бүлгээр, ЭБЭЭ, ЭХЭМҮТ, 2025 он... 34
Зураг 31. Амьд төрсөн нярай, ЭБЭЭ, ЭХЭМҮТ, 2025 он ... 34
Зураг 32. Жирэмсэн, төрөх, төрсний дараах үеийн хүндрэл, ЭБЭЭ, ЭХЭМҮТ, 2025 он... 35

Зураг 33. Хагалгааны бүтэц, ЭБЭЭ, ЭХЭМҮТ, 2025 он ........ 35
Зураг 34. Амьгүй төрөлтийн түвшин, ЭБЭЭ, ЭХЭМҮТ, 2021-2025 он ........ 35
Зураг 35. Задлан шинжилгээний үзүүлэлт, ЭБЭЭ, ЭХЭМҮТ, 2021-2025 он ........ 36
Зураг 36. Амбулаториор үйлчлүүлэгсэд, ЭБЭЭ, ЭХЭМҮТ, 2021-2025 он ........ 39
Зураг 37. Амбулаторийн үзлэгийн төрөл, ЭБЭЭ, ЭХЭМҮТ, 2025 он ........ 39
Зураг 38. Сэргээн засах эмчилгээний тасгийн үзлэг, ЭБЭЭ, ЭХЭМҮТ, 2025 он ........ 39
Зураг 39. ХЭ-ийн төсөвт ор, ЭХЭМҮТ, 2025 он ........ 42
Зураг 40. ХЭ-т хэвтэн эмчлүүлэгчид, ЭХЭМҮТ, 2021-2025 он ........ 42
Зураг 41. ХЭ-ийн орны үзүүлэлтүүд, ЭХЭМҮТ, 2021-2025 он ........ 42
Зураг 42. ХЭ-ийн ор хоногийн төлөвлөгөөний биелэлтийн хувь, ЭХЭМҮТ, 2021-2025 он ........ 43
Зураг 43. ХЭ-т Улаанбаатар хотоос хэвтэн эмчлүүлэгчид, ЭХЭМҮТ, 2025 он ........ 43
Зураг 44. ХЭ-ийн өвчлөлийн бүтэц, насны бүлэг, хүйсээр, ЭХЭМҮТ, 2025 он ........ 43
Зураг 45. ЭХЭМҮТ-ийн ХЭ-т хэвтэн эдгэрч гарагсад, аймгаар (бодит тоо, хувиар), 2025 он ........ 44
Зураг 46. Задлан шинжилгээний үзүүлэлт, ХЭ, ЭХЭМҮТ, 2021-2025 он ........ 45
Зураг 47. Төсөвт ор, ХЭ, дотрын тасгууд, ЭХЭМҮТ, 2025 он ........ 46
Зураг 48. Хэвтэн эмчлүүлэгчид, ХЭ, дотрын тасгууд, ЭХЭМҮТ, 2021-2025 он ........ 46
Зураг 49. Хэвтэн эмчлүүлэгчид, Улаанбаатар хот, ХЭ, дотрын тасгууд, ЭХЭМҮТ, 2025 он ........ 47
Зураг 50. Орны үзүүлэлт, ХЭ, дотрын тасгууд, ЭХЭМҮТ, 2021-2025 он ........ 47
Зураг 51. Задлан шинжилгээний үзүүлэлт, ХЭ, дотрын тасгууд, ЭХЭМҮТ, 2021-2025 он ........ 48
Зураг 52. Төсөвт ор, ХЭ, мэс заслын тасгууд, ЭХЭМҮТ, 2025 он ........ 51
Зураг 53. Хэвтэн эмчлүүлэгчид, ХЭ, мэс заслын тасгууд, ЭХЭМҮТ, 2021-2025 он ........ 51
Зураг 54. Орны үзүүлэлт, ХЭ, мэс заслын тасгууд, ЭХЭМҮТ, 2021-2025 он ........ 52
Зураг 55. Улаанбаатар хотын хэвтэн эмчлүүлэгчид, ХЭ, мэс заслын тасгууд, ЭХЭМҮТ, 2025 он ........ 52
Зураг 56. Мэс засал, ХЭ, мэс заслын тасгууд, ЭХЭМҮТ, 2025 он ........ 53
Зураг 57. Хагалгааны бүтэц, ХЭ, мэс заслын тасгууд, ЭХЭМҮТ, 2025 он ........ 54
Зураг 58. Задлан шинжилгээний үзүүлэлт, ХЭ, мэс заслын тасгууд, ЭХЭМҮТ, 2021-2025 он ........ 54
Зураг 59. Хүүхдийн амбулаториор үйлчлүүлэгсэд, ЭХЭМҮТ, 2021-2025 он ........ 57
Зураг 60. Хүүхдийн амбулаторийн үзлэгийн төрөл, ЭХЭМҮТ, 2025 он ........ 57
Зураг 61. Хүүхдийн сэргээн засах эмчилгээний тасгийн үйлчилгээ, ЭХЭМҮТ, 2025 он ........ 57
Зураг 62. Хүүхдийн амбулаторийн кабинетуудын ачаалал, ЭХЭМҮТ, 2025 он ........ 58
Зураг 63. Хүүхдийн оношилгооны кабинетуудын үзлэг, ЭХЭМҮТ, 2025 он ........ 58
Зураг 64. Хүүхдийн чанд авиан оношилгооны кабинетын үйлчилгээ, ЭХЭМҮТ, 2025 он ........ 59
Зураг 65. Лабораторийн шинжилгээний төрөл, хувиар, ЭХЭМҮТ, 2025 он ........ 59

Зураг 66. Хэвтэн эмчлүүлэгчид, эрчимт эмчилгээний тасгаар, ЭХЭМҮТ, 2021-2025 он ........ 62
Зураг 67. Ашигласан ор хоног, эрчимт эмчилгээний тасгаар, ЭХЭМҮТ, 2021-2025 он ........ 62
Зураг 68. Дундаж ор хоног, эрчимт эмчилгээний тасгаар, ЭХЭМҮТ, 2021-2025 он ........ 63
Зураг 69. Орны эргэлт, эрчимт эмчилгээний тасгаар, ЭХЭМҮТ, 2021-2025 он.. 63
Зураг 70. Ор хоногийн төлөвлөгөөний биелэлтийн хувь, эрчимт эмчилгээний тасгаар, ЭХЭМҮТ, 2021-2025 он........ 64
Зураг 71. Яаралтай тусламж үйлчилгээ, ЭХЭМҮТ, 2025 он ........ 67
Зураг 72. Хүүхдийн эмнэлгийн Яаралтай тусламжийн тасаг, ЭХЭМҮТ, 2021-2025 он ........ 67
Зураг 73. Эрүүл мэндийн даатгалын сангаас авсан санхүүжилт, ЭХЭМҮТ, 2021-2025 он ........ 71
Зураг 74. ЭМД-ын санхүүжилтийн бүтэц, хувиар, ЭХЭМҮТ, 2025 он........ 72
Зураг 75. Хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээний санхүүжилт, ЭХЭМҮТ, 2021-2025 он........ 72
Зураг 76. Өдрийн эмчилгээний санхүүжилт, ЭХЭМҮТ, 2021-2025 он ........ 73
Зураг 77. Хорт хавдрын химийн өдрийн эмчилгээ, ЭХЭМҮТ, 2021-2025 он....... 74
Зураг 78. Амбулаторийн санхүүжилт, ЭХЭМҮТ, 2021 - 2025 он........ 74
Зураг 79. Амбулаторийн өндөр өртөгтэй оношилгоо, шинжилгээ, ЭХЭМҮТ, 2021-2025 он ........ 75
Зураг 80. Яаралтай тусламжийн санхүүжилт, ЭХЭМҮТ, 2021-2025 он........ 75
Зураг 81. Телемидицины санхүүжилт, ЭХЭМҮТ, 2021-2025 он........ 76
Зураг 82. Сэргээн засах тусламж, үйлчилгээний санхүүжилт, ЭХЭМҮТ, 2021-2025 он ........ 76
Зураг 83. Цалин хөлс, нэмэгдэл урамшуулал, ЭХЭМҮТ, 2025 он (мян.төг) ....... 78
Зураг 84. Нийгмийн даатгалын шимтгэл, ЭХЭМҮТ, 2025 он (мян.төг)........ 78
Зураг 85. Тогтмол зардал, ЭХЭМҮТ, 2025 он (мян.төг) ........ 78
Зураг 86. Хангамж бараа материалын зардал, ЭХЭМҮТ, 2025 он (мян.төг)...... 79
Зураг 87. Норматив зардал, ЭХЭМҮТ, 2025 он (мян.төг) ........ 79
Зураг 88. Эд хогшил урсгал засвар, ЭХЭМҮТ, 2025 он (мян.төг)........ 79
Зураг 89. Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал, ЭХЭМҮТ, 2025 он (мян.төг)........ 80

# ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

| | |
|---|---|
| АУЗЛ | Анагаахын удамзүйн лаборатори |
| АХБ | Азийн хөгжлийн банк |
| АЭЭСТ | Амьсгалын эрхтний эмгэг судлалын тасаг |
| БГД | Баянгол дүүрэг |
| БЗД | Баянзүрх дүүрэг |
| БДШЭСТ | Бөөр, дотоод шүүрлийн эмгэг судлалын тасаг |
| БМЗТ | Бөөрний мэс заслын тасаг |
| ДТСТ | Дутуу тээлт судлалын тасаг |
| ЕМЗТ | Ерөнхий мэс заслын тасаг |
| ЗАН | Зайн анагаахын нэгж |
| ЗСХЭЭСТ | Зүрх судас, холбогч эдийн эмгэг судлалын тасаг |
| КТГ | Компьютер томограф |
| МЭСТ | Мэдрэлийн эмгэг судлалын тасаг |
| МХНТ | Мэдээгүйжүүлэг хагалгааны нэгдсэн тасаг |
| МЗЭЭТ | Мэс заслын эрчимт эмчилгээний тасаг |
| НДҮЗ | Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл |
| НҮЗП | Нөхөн үржихүйн зөвлөх поликлиник |
| НҮБ | Нэгдсэн үндэстний байгууллага |
| НМЗТ | Нүдний мэс заслын тасаг |
| НЛТ | Нэгдсэн лабораторийн тасаг |
| ННТ | Нярайн нэгдсэн тасаг |
| НСТ | Нярай судлалын тасаг |
| НЭСТ | Нярайн эмгэг судлалын тасаг |
| НЭЭТ | Нярайн эрчимт эмчилгээний тасаг |
| ӨОУА | Өвчний олон улсын ангилал |
| ӨҮК | Өсвөр үеийн клиник |
| ПГУ | Полимеразын гинжин урвал |
| СМТ | Статистик мэдээлэлзүйн тасаг |
| СХД | Сонгинохайрхан дүүрэг |
| СБД | Сүхбаатар дүүрэг |
| СЗЭТ | Сэргээн засах эмчилгээний тасаг |
| ТХГ | Төрөлхийн хөгжлийн гажиг |
| ТТ | Төрөх тасаг |
| ТДТ | Төрсний дараах тасаг |
| ХАС | Хүн амын сан |
| ХБЭЭСТ | Хоол боловсруулах эрхтний эмгэг судлалын тасаг |

| | |
|---|---|
| ХЗП | Хүүхдийн зөвлөх поликлиник |
| ХНТ | Хагалгааны нэгдсэн тасаг |
| ХУД | Хан-Уул дүүрэг |
| ХХК | Хариуцлагатай хувьцаат компани |
| ХЭ | Хүүхдийн эмнэлэг |
| ХЭЭТ | Хүүхдийн эрчимт эмчилгээний тасаг |
| ЦЦБ | Цус, цусан бүтээгдэхүүн |
| ЦЭХСТ | Цусны эмгэг, хавдар судлалын тасаг |
| ЧД | Чингэлтэй дүүрэг |
| ЧХХМЗТ | Чих, хамар, хоолойн мэс заслын тасаг |
| ЭБЭЭ | Эх барих эмэгтэйчүүдийн эмнэлэг |
| ЭЖСТ | Эрсдэлтэй жирэмсэн судлалын тасаг |
| ЭМД | Эрүүл мэндийн даатгал |
| ЭМДҮЗ | Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл |
| ЭМДС | Эрүүл мэндийн даатгалын сан |
| ЭМДЕГ | Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар |
| ЭМЯ | Эрүүл мэндийн яам |
| ЭМС | Эрүүл мэндийн сайд |
| ЭНМЗТ | Эрүү нүүрний мэс заслын тасаг |
| ЭХЭМҮТ | Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв |
| ЭЭТ | Эрчимт эмчилгээний тасаг |
| ЭЭСТ | Эмэгтэйчүүдийн эмгэг судлалын тасаг |
| ЯТТ | Яаралтай тусламжийн тасаг |

# ӨМНӨХ ҮГ

Эрүүл мэнд нь хувь хүний амьдралын чанар төдийгүй гэр бүл, нийгмийн хөгжилд чухал нөлөөтэй үнэт баялаг билээ.

Монгол Улсын эрүүл мэндийн тухай хуульд “Эрүүл мэнд” гэж хүн өвчин эмгэггүй, бие бялдар, оюун санаа, нийгмийн амьдралын хувьд сайн сайхан байхыг хэлнэ хэмээн тодорхойлсон байдаг. Эрүүл мэндийн байдлыг тогтмол хянах, шаардлагатай мэдээллийг нэг дор цэгцтэй хадгалах нь өвчнөөс урьдчилан сэргийлэх, оношилгоо, эмчилгээний үр дүнг сайжруулах үндэс болдог.

Эрүүл мэндийн статистик нь эх, хүүхдийн өвчлөл, эндэгдэл, түүний шалтгаан, төрөлт, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийн талаарх мэдээллийг багтаадаг ба эх, хүүхдийн эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлого, хөтөлбөр, үйл ажиллагааг боловсруулах, түүний хэрэгжилтийг үнэлж, дүгнэхэд чухал ач холбогдолтой.

Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв (ЭХЭМҮТ)-ийн албан ёсны статистик мэдээнд үндэслэн “Эрүүл мэндийн үзүүлэлт 2025” эмхэтгэлийг боловсруулж, олон улсын аргачлалд нийцүүлэн тооцоолол хийж та бүхний мэргэн оюунд толилуулж байна. Энэхүү эмхэтгэлийг гаргаснаар бодлого боловсруулагчид, шийдвэр гаргагчид, эмч, мэргэжилтнүүд төдийгүй мэдээлэл хэрэглэгчдийг нотолгоонд тулгуурласан, цаг үеэ олсон, чанартай мэдээллээр хангах боломж бүрдэж байгаа билээ.

ЭХЭМҮТ-ийн хамт олон бид цаашид ч үр өгөөжтэй, ил тод, хариуцлагатай, нотолгоонд суурилсан үйл ажиллагааг хөгжүүлэн ажиллах болно.

Эрхэм хэрэглэгч та энэхүү эмхэтгэлийн нүүр хуудаст байрлах QR кодыг уншуулан, цахим хэлбэрээр татан авах, эсвэл холбоосыг цахим шууданд илгээх боломжтой.

ЭХЭМҮТ-ийн Статистик мэдээлэлзүйн тасгаас боловсруулсан энэхүү эмхэтгэл, бусад статистик мэдээлэлтэй холбоотой санал, шүүмж, алдаа, дутагдлыг хүлээн авахад бид үргэлж нээлттэй байх болно.

**"ЭРҮҮЛ ЭХ, ХҮҮХЭД - ЭХ ОРНЫ ЭРХЭМ БАЯЛАГ"**

**ЭХЭМҮТ-ийн Захирал**
**АУ-ны доктор**
**Клиникийн профессор**
**Ж.ОТГОНБААТАР**

# 1. ЭХ ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНААС






























# 2. ЭХЭМҮТ-ИЙН 2025 ОНЫ ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ

## 2.1. Үндсэн үзүүлэлт

Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв (ЭХЭМҮТ)-ийн хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээг авч үзвэл 2025 онд 221433 ор ашиглан, 34580 эх, эмэгтэйчүүд, хүүхэд хэвтэн эмчлүүлжээ. 2025 онд ЭХЭМҮТ нь 680 төсөвт ортой ажилласан ба нийт төсөвт орны 37.6%-ийг Эх барих эмэгтэйчүүдийн эмнэлэг (ЭБЭЭ), 62.4%-ийг Хүүхдийн эмнэлэг (ХЭ), үүний 64.4%-ийг хүүхдийн дотрын тасгууд, 35.6%-ийг хүүхдийн мэс заслын тасгууд эзэлж байна.




**Зураг 1. Төсөвт ор, ЭХЭМҮТ, 2025 он**

2025 онд ЭХЭМҮТ-ийн орны фонд ашиглалт 325.6, орны эргэлт 50.9, дундаж ор хоног 6.4, ор хоногийн төлөвлөгөөний биелэлтийн хувь 2025 онд 98.7% байна.




**Зураг 2. Орны үзүүлэлт, ЭХЭМҮТ, 2021-2025 он**




**Зураг 3. Ор хоногийн төлөвлөгөөний биелэлтийн хувь, ЭХЭМҮТ, 2021-2025 он**

2025 онд ЭХЭМҮТ-д 34580 хүн хэвтэн эмчлүүлснээс орон нутгаас ирж үйлчлүүлэгчид 38.5%-ийг эзэлж байна.




Зураг 4. Хэвтэн эмчлүүлэгчид (тоо, хувиар), ЭХЭМҮТ, 2021-2025 он

2025 онд орон нутгаас хэвтэн эдгэрч гарагсдын 9.5% (n=1248) Төв, 7.5% (n=991) Сэлэнгэ, 7.4% (n=980) Хөвсгөл, 6.8% (n=901) Архангай, 6.8% (n=889) Дархан-Уул, 5.9% (n=780) Өвөрхангай аймгаас тус тус ирж үйлчлүүлсэн байв.




Зураг 5. ЭХЭМҮТ-д хэвтэн, эдгэрч гарсан өвчтөн, аймгаар (бодит тоо, хувиар), 2025 он

**Хүснэгт 1. ЭХЭМҮТ-д хэвтэн эмчлүүлэгчид, хот, хөдөө, 2021-2025 он**

| Аймаг, хот | 2021 n (%) | 2022 n (%) | 2023 n (%) | 2024 n (%) | 2025 n (%) |
|---|---|---|---|---|---|
| Төв | 1391 12.4 | 1731 11.8 | 1417 10.5 | 1321 9.8 | 1248 9.5 |
| Сэлэнгэ | 861 7.7 | 1079 7.3 | 947 7.0 | 972 7.2 | 991 7.5 |
| Хөвсгөл | 796 7.1 | 928 6.3 | 953 7.1 | 903 6.7 | 980 7.4 |
| Архангай | 877 7.8 | 1142 7.8 | 1017 7.6 | 975 7.3 | 901 6.8 |
| Дархан-Уул | 722 6.4 | 821 5.6 | 784 5.8 | 761 5.7 | 889 6.8 |
| Өвөрхангай | 629 5.6 | 933 6.4 | 833 6.2 | 868 6.5 | 780 5.9 |
| Хэнтий | 554 4.9 | 738 5.0 | 686 5.1 | 692 5.1 | 652 5.0 |
| Өмнөговь | 451 4.0 | 545 3.7 | 486 3.6 | 568 4.2 | 641 4.9 |
| Баянхонгор | 483 4.3 | 620 4.2 | 566 4.2 | 637 4.7 | 638 4.8 |
| Завхан | 484 4.3 | 636 4.3 | 615 4.6 | 592 4.4 | 579 4.4 |
| Баянөлгий | 333 3.0 | 568 3.9 | 472 3.5 | 523 3.9 | 565 4.3 |
| Орхон | 496 4.4 | 649 4.4 | 614 4.6 | 609 4.5 | 530 4.0 |
| Увс | 413 3.7 | 558 3.8 | 526 3.9 | 584 4.3 | 523 4.0 |
| Дорноговь | 459 4.1 | 576 3.9 | 586 4.4 | 538 4.0 | 522 4.0 |
| Булган | 425 3.8 | 626 4.3 | 525 3.9 | 512 3.8 | 500 3.8 |
| Ховд | 379 3.4 | 523 3.6 | 503 3.7 | 558 4.2 | 463 3.5 |
| Сүхбаатар | 351 3.1 | 499 3.4 | 412 3.1 | 461 3.4 | 432 3.3 |
| Дорнод | 408 3.6 | 547 3.7 | 517 3.8 | 479 3.6 | 424 3.2 |
| Дундговь | 259 2.3 | 381 2.6 | 416 3.1 | 351 2.6 | 389 3.0 |
| Говь-Алтай | 311 2.8 | 370 2.5 | 387 2.9 | 358 2.7 | 367 2.8 |
| Говьсүмбэр | 154 1.4 | 213 1.5 | 181 1.3 | 175 1.3 | 141 1.1 |
| **Аймгийн дүн** | **11236 35.4** | **14683 40.7** | **13443 40.8** | **13437 39.6** | **13155 38.3** |
| **Улаанбаатар** | **20501 64.6** | **21431 59.3** | **19529 59.2** | **20483 60.4** | **21155 61.7** |
| **Бүгд** | **31737 100.0** | **36114 100.0** | **32972 100.0** | **33920 100.0** | **34310 100.0** |




**Зураг 6. ЭХЭМҮТ-д хэвтэн эмчлүүлэгчид, орон нутгаар, 2021-2025 он**

2025 онд ЭХЭМҮТ-д Улаанбаатар хотоос хэвтэн эмчлүүлэгчдийг харьяа дүүргээр нь авч үзвэл Сонгинохайрхан 27.7% (n=5864), Баянзүрх 21.9% (n=4626), Баянгол 18.0% (n=3798) ээлж байлаа. 2025 онд Сонгинохайрхан дүүргийн үйлчлүүлэгсдийн эзлэх хувь 2024 оноос буурчээ.




Зураг 7. Улаанбаатар хотын хэвтэн эмчлүүлэгчид, хувиар, ЭХЭМҮТ, 2021-2025 он

ЭХЭМҮТ-ийн Хүүхдийн эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчдийн 39.9%-ийг тав хүртэлх насны хүүхэд ээлж байгаа ба тав хүртэлх насны хүүхдийн эзлэх хувь жил тутам буурч 5 ба түүнээс дээш насны хүүхдийн эзлэх хувь өссөн.




Зураг 8. Хүүхдийн эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчид, насаар, ЭХЭМҮТ, 2021-2025 он

Зургаас харахад 2021 онд Хүүхдийн эмнэлэгт хэвтэн эмчлүүлээд гарсан тав хүртэлх насны хүүхдийн 48.6%-ийг нэг хүртэлх насны хүүхэд ээлж байсан бол 2025 онд 46.6%-ийг ээлж байна. 2021 онд Хүүхдийн эмнэлэгт тав хүртэлх насны хэвтэн эмчлүүлж гарсан хүүхдийн 19.2%-ийг нярай хүүхэд ээлж байсан бол 2025 онд 27.5% болж өссөн байна.




**Зураг 9. Хүүхдийн эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчдэд тав хүртэлх, нялхас, нярай хүүхдийн эзлэх хувь, ЭХЭМҮТ, 2021-2025 он**

**Хүснэгт 2. Өвчлөлийн бүтэц, стационарт хэвтэн эмчлүүлэгчид, ЭХЭМҮТ, 2021-2025 он**

| Өвчний бүлэг ӨОУА-10 | 2021 | 2022 | 2023 | 2024 | 2025 |
|---|---|---|---|---|---|
| | n (%) | n (%) | n (%) | n (%) | n (%) |
| Халдварт ба шимэгчит зарим өвчин | 42<br>0.1 | 76<br>0.2 | 51<br>0.2 | 83<br>0.2 | 84<br>0.2 |
| Хавдар | 1243<br>3.9 | 1689<br>4.7 | 1826<br>5.5 | 1859<br>5.5 | 2035<br>5.9 |
| Цус, цус төлжүүлэх эрхтний өвчин ба дархлааны механизм хамарсан зарим эмгэг | 373<br>1.2 | 455<br>1.3 | 494<br>1.5 | 494<br>1.5 | 476<br>1.4 |
| Дотоод шүүрэл, тэжээлийн ба бодисын солилцооны өвчнүүд | 153<br>0.5 | 260<br>0.7 | 219<br>0.7 | 184<br>0.5 | 218<br>0.6 |
| Сэтгэцийн ба зан төрхийн эмгэг | 27<br>0.1 | 32<br>0.1 | 13<br>0.04 | 21<br>0.1 | 8<br>0.0 |
| Мэдрэлийн тогтолцооны өвчнүүд | 1094<br>3.4 | 1423<br>3.9 | 1399<br>4.2 | 1389<br>4.1 | 1362<br>4.0 |
| Нүд ба түүний дайврын өвчнүүд | 971<br>3.1 | 1250<br>3.5 | 1216<br>3.7 | 1208<br>3.6 | 1184<br>3.5 |
| Чих ба хөхлөг сэртэнгийн өвчнүүд | 560<br>1.8 | 779<br>2.2 | 755<br>2.3 | 769<br>2.3 | 631<br>1.8 |
| Зүрх судасны тогтолцооны өвчин | 120<br>0.4 | 130<br>0.4 | 220<br>0.7 | 189<br>0.6 | 264<br>0.8 |
| **Амьсгалын тогтолцооны өвчин** | 1408<br>4.4 | 2847<br>7.9 | 3131<br>9.5 | 3162<br>9.3 | **3513**<br>**10.2** |
| **Хоол боловсруулах тогтолцооны өвчин** | 3199<br>10.1 | 3322<br>9.2 | 3240<br>9.8 | 3316<br>9.8 | **3135**<br>**9.1** |
| Арьс ба арьсан доорх эслэгийн өвчин | 781<br>2.5 | 1730<br>4.8 | 960<br>2.9 | 868<br>2.6 | 778<br>2.3 |
| Яс булчингийн тогтолцоо ба холбох эдийн өвчин | 463<br>1.5 | 586<br>1.6 | 609<br>1.8 | 573<br>1.7 | 427<br>1.2 |
| **Шээс бэлгийн тогтолцооны эмгэг** | 1642<br>5.2 | 2451<br>6.8 | 1854<br>5.6 | 2105<br>6.2 | **2209**<br>**6.4** |
| **Жирэмсэн, төрөлт ба төрсний дараах үе** | 14930<br>47.0 | 14739<br>40.8 | 13088<br>39.7 | 13752<br>40.5 | **14133**<br>**41.2** |
| Перинатал үед үүссэн зарим эмгэг | 1178<br>3.7 | 1521<br>4.2 | 1512<br>4.6 | 1378<br>4.1 | 1437<br>4.2 |
| Төрөлх гажиг, гаж хөгжил ба хромосомын эмгэг | 1343<br>4.2 | 1602<br>4.4 | 1501<br>4.6 | 1565<br>4.6 | 1383<br>4.0 |
| Гэмтэл, хордлого ба гадны шалтгаант бусад тодорхой эмгэг | 625<br>2.0 | 860<br>2.4 | 884<br>2.7 | 1005<br>3.0 | 1029<br>3.0 |
| Шалтгаан нь тодорхойгүй шинэ өвчний урьдчилсан ангилал /U00-U49/ | 1585<br>5.0 | 362<br>1.0 | | 0.0 | 4<br>0.0 |
| **БҮГД** | **31737**<br>**100.0** | **36114**<br>**100.0** | **32972**<br>**100.0** | **33920**<br>**100.0** | **34310**<br>**100.0** |

2021-2025 онд ЭХЭМҮТ-д хэвтэн, эдгэрч гарагсдын өвчлөлийн бүтцийг өвчний олон улсын ангилал (ӨОУА-10)-р ангилахад, өвчлөлийн шалтгаанд жирэмсэн, төрөлт ба төрсний дараах үе, амьсгалын тогтолцооны өвчин, хоол боловсруулах тогтолцооны өвчин, шээс бэлгийн тогтолцооны эмгэг зонхилж байна. 2025 онд ЭХЭМҮТ-д хэвтэн эмчлүүлсэн 5 хүртэлх насны хүүхдийн өвчлөлийн зонхилох шалтгаанд 25.3% (n=2010) нярайн эмгэг, 25.6% (n=1521) амьсгалын тогтолцооны өвчин, 16.7% (n=992) хоол боловсруулах тогтолцооны өвчин, 9.6% (n=573) төрөлхийн гажиг, гаж хөгжил ба хромосомын эмгэг орж байна. Нярайн эмгэгийн зонхилох шалтгаанд тархины хүчилтөрөгчийн дутал, нярайн шарлалт илүүтэй тохиолджээ.




**Зураг 10. Тав хүртэлх насны хүүхдийн өвчлөлийн бүтэц, ЭХЭМҮТ, 2025 он**

2025 онд ЭХЭМҮТ-д нийт 8136 эх амаржиж, нийт төрөлтөд орон нутгаас ирж үйлчлүүлэгсдийн эзлэх хувь 47.3 байна.




**Зураг 11. Амаржсан эх (тоо, хувиар), ЭХЭМҮТ, 2021-2025 он**

ЭХЭМҮТ-ийн амбулаториор 2025 онд 310464 эх, хүүхэд, эмэгтэйчүүд ирж үзүүлсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 1.6%-иар буурсан. 2025 онд ЭХЭМҮТ-ийн амбулаториор үйлчлүүлсэн эх, хүүхдийн 29.5% (n=91730) хөдөө орон нутгаас ирж үйлчлүүлжээ.




**Зураг 12. Амбулаторийн үзлэг, ЭХЭМҮТ, 2021-2025 он**




**Зураг 13. Амбулаторийн үзлэгийн төрөл, ЭХЭМҮТ, 2025 он**

Зургаас харахад ЭХЭМҮТ-ийн 2025 оны амбулаторийн үзлэгийн 85.3% (n=264723) өвчний учир, 14.2% (n=44157) идэвхтэй хяналт, 0.5% (n=1584) урьдчилан сэргийлэх үзлэг эзэлж байна.




**Зураг 14. Мэс заслын үзүүлэлт, ЭХЭМҮТ, 2021-2025 он**

2025 онд ЭХЭМҮТ-д хэвлийн хөндийн ба төрөлжсөн нарийн мэргэжлийн нийт 11816 эх, хүүхдэд мэс заслын хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээ үзүүлжээ. 2025 онд нийт хийгдсэн хагалгааны 68.5% (n=8089) Хүүхдийн эмнэлэгт, 31.5% (n=3727) Эх барих эмэгтэйчүүдийн эмнэлэгт хийгджээ. ЭХЭМҮТ-ийн нас баралтын эзлэх хувь 2025 онд 1.1 (n=369), хоног болоогүй нас баралтын эзлэх хувь 5.4 байна.




Зураг 15. Нас баралтын үзүүлэлт, ЭХЭМҮТ, 2021-2025 он




Зураг 16. Задлан шинжилгээний үзүүлэлт, ЭХЭМҮТ, 2021-2025 он

2025 онд ЭХЭМҮТ-ийн задлан шинжилгээний хувь 62.1% байгаа нь өнгөрсөн оноос 12.1 пунктээр буурсан ба 2025 онд задлан шинжилгээний 96.1%-д онош тохирсон байна. ЭХЭМҮТ-д 2025 онд амьд төрөлт 8378, нярайн эндэгдэл 168 (ЭХЭМҮТ-д төрөөд, тус төвд эндсэн), нярайн эндэгдлийн түвшин 20.1, перинатал эндэгдлийн түвшин 22.5 байгаа ба нярайн эндэгдлийн түвшин өнгөрсөн оноос 1.8 пункт, перинатал эндэгдлийн түвшин 1.1 пунктээр тус тус өссөн.

Хүснэгт 3. Перинатал, нярайн эндэгдлийн түвшин, ЭХЭМҮТ, 2021-2025 он

| Үзүүлэлт | 2021 | 2022 | 2023 | 2024 | 2025 |
|---|---|---|---|---|---|
| Перинатал эндэгдэл (амьд, амьгүй төрсөн 1000 хүүхдэд) | 26.9 | 23.7 | 26.1 | 21.4 | 22.5 |
| Нярайн эндэгдэл (амьд төрсөн 1000 хүүхдэд) | 20.7 | 17.8 | 19.4 | 18.3 | 20.1 |

2025 онд ЭХЭМҮТ-ийн нярайн (n=184, ЭХЭМҮТ болон бусад амаржих газарт төрөөд ЭХЭМҮТ-д эндсэн) эндэгдлийн шалтгааны 29.9% (n=55) тархины хүчилтөрөгчийн дутмагшил, 27.7% (n=51) амьсгал гачаал эзэлж байна. Нярайн эрт үеийн (n=133) эндэгдлийн шалтгааны 37.6% (n=50) амьсгал гачаал, 21.1% (n=28) тархины хүчилтөрөгчийн дутмагшил, 14.3% (n=19) төрөлх гажиг, гаж хөгжил ба хромосомын эмгэг зонхилон тохиолджээ.

**Хүснэгт 4. Нас баралтын зонхилох шалтгаан, ЭХЭМҮТ, 2021-2025 он**

| Өвчний бүлэг ӨОУА-10 | 2021 n (%) | 2022 n (%) | 2023 n (%) | 2024 n (%) | 2025 n (%) |
|---|---|---|---|---|---|
| I бүлэг. Халдварт ба шимэгчит зарим өвчин | 14<br>3.6 | 10<br>2.6 | 8<br>2.1 | 10<br>2.7 | 7<br>1.9 |
| II бүлэг. Хавдар | 28<br>7.2 | 25<br>6.5 | 33<br>8.6 | 39<br>10.7 | 40<br>10.8 |
| III бүлэг. Цус, цус төлжүүлэх эрхтний өвчин ба дархлааны механизм хамарсан зарим эмгэг | 3<br>0.8 | 3<br>0.8 | | 2<br>0.5 | 4<br>1.1 |
| IV бүлэг. Дотоод шүүрэл, тэжээлийн ба бодисын солилцооны өвчнүүд | 3<br>0.8 | 1<br>0.3 | 2<br>0.5 | 3<br>0.8 | 3<br>0.8 |
| VI бүлэг. Мэдрэлийн тогтолцооны өвчнүүд | 14<br>3.6 | 21<br>5.4 | 26<br>6.8 | 19<br>5.2 | 14<br>3.8 |
| IX бүлэг. Зүрх судасны тогтолцооны өвчин | 14<br>3.6 | 6<br>1.6 | 6<br>1.6 | 4<br>1.1 | 6<br>1.6 |
| X бүлэг. Амьсгалын тогтолцооны өвчин | 7<br>1.8 | 9<br>2.3 | 10<br>2.6 | 9<br>2.5 | 7<br>1.9 |
| XI бүлэг. Хоол боловсруулах тогтолцооныөвчин | 7<br>1.8 | 7<br>1.8 | 8<br>2.1 | 15<br>4.1 | 10<br>2.7 |
| XII бүлэг. Арьс ба арьсан доорх эслэгийн өвчин | | 1<br>0.3 | | | |
| XIII бүлэг. Яс булчингийн тогтолцоо ба холбох эдийн өвчин | | 6<br>1.6 | 2<br>0.5 | 1<br>0.3 | 4<br>1.1 |
| XIV бүлэг. Шээс бэлгийн тогтолцооны эмгэг | 2<br>0.5 | | 3<br>0.8 | 3<br>0.8 | 2<br>0.5 |
| XV бүлэг. Жирэмсэн, төрөлт ба төрсний дараах үе | 14<br>3.6 | 3<br>0.8 | 3<br>0.8 | 2<br>0.5 | |
| **XVI бүлэг. Перинатал үед үүссэн зарим эмгэг** | 205<br>52.4 | 187<br>48.3 | **183**<br>**47.5** | **176**<br>**48.2** | 184<br>49.9 |
| **XVII бүлэг. Төрөлх гажиг, гаж хөгжил ба хромосомын эмгэг** | 72<br>18.4 | 106<br>27.4 | **99**<br>**25.7** | 79<br>21.6 | 79<br>21.4 |
| XX бүлэг. Өвчлөл ба нас баралтын гадны шалтгаан | 2<br>0.5 | 1<br>0.3 | 2<br>0.5 | 3<br>0.8 | 9<br>2.4 |
| XXII бүлэг. Шалтгаан нь тодорхойгүй шинэ өвчний урьдчилсан ангилал /U00-U49/ | 6<br>1.5 | 1<br>0.3 | | | |
| **Бүгд** | **391**<br>**100.0** | **387**<br>**100.0** | **385**<br>**100.0** | **365**<br>**100.0** | **369**<br>**100.0** |

## 2.2. Эхийн ноцтой хүндрэл, эхийн эндэгдэл, 2021-2025 он, ЭХЭМҮТ

Эхийн ноцтой хүндрэлийн үзүүлэлт нь эхэд үзүүлж буй эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарыг илтгэх гол үзүүлэлт болдог төдийгүй шинээр эмчилгээ үйлчилгээний удирдамж, стандарт боловсруулах үндэс болдог.

Монгол Улсад 2025 онд жирэмсэн, төрөх, төрсний дараах үеийн ноцтой хүндрэлээр 158 эх хүндэрч, 17 эх эндэж, эхийн амь насанд заналхийлсэн хүндрэлийн харьцаа 2.6 байгаа ба эхийн амь насанд заналхийлсэн хүндрэлтэй (n=158) эхийн 89.2% (n=141)-ийг аварчээ.

ЭХЭМҮТ-д 2025 онд 8136 эх амаржиж, 8378 хүүхэд амьд төрсөн ба амаржсан эх өмнөх оноос 6.4% (n=553), амьд төрөлт 5.4% (n=478)-иар буурсан ба эхийн эндэгдлийн тохиолдол гараагүй байв (Хүснэгт 5).

**Хүснэгт 5. Төрөлт, эхийн амь насанд заналхийлсэн хүндрэл, хүндрэлийн харьцаа, ЭХЭМҮТ, 2021-2025 он**

| Сонгосон үзүүлэлт | 2021 | 2022 | 2023 | 2024 | 2025 |
|---|---|---|---|---|---|
| Амаржсан эх | 10495 | 9405 | 8362 | 8689 | 8136 |
| Амьд төрсөн нярай | 10623 | 9556 | 8471 | 8856 | 8378 |
| Эхийн ноцтой хүндрэл (ЭНХ) | 46 | 51 | 68 | 63 | 53 |
| Эхийн ноцтой хүндрэлийн харьцаа | 4.3 | 5.3 | 8.0 | 7.1 | 6.3 |
| Эхийн эндэгдэл (ЭЭ) | 14 | 3 | 3 | 2 | 0 |
| Эхийн эндэгдлийн харьцаа | 131.8 | 31.4 | 35.4 | 22.6 | 0 |
| Эхийн амь насанд заналхийлсэн хүндрэл* | 60 | 54 | 71 | 65 | 53 |
| Эхийн амь насанд заналхийлсэн хүндрэлийн харьцаа | 5.6 | 5.7 | 8.4 | 7.3 | 6.3 |

***Эхийн амь насанд заналхийлсэн хүндрэл нь эндсэн эх болон амь нас аврагдсан эхийн нийлбэрээр илэрхийлэгдэнэ.**

ЭХЭМҮТ-д эхийн амь насанд заналхийлсэн хүндрэлийн харьцаа, эхийн ноцтой хүндрэлийн харьцаа 2021-2025 онд улс, хот, аймгийн дунджаас өндөр байгаа нь нэг талаас эхийн ноцтой хүндрэлийг шалгуур үзүүлэлтээр үнэлэх, тохиолдол бүрт дүгнэлт хийх замаар эхийн эрүүл мэндийг сайжруулахад чиглэгдсэн арга хэмжээний хэрэгжилт сайн байгааг нөгөө талаас тус төвд бусад орон нутаг, амаржих газраас ноцтой хүндрэлийн тохиолдол шилжин ирж эмчлүүлдэгтэй холбоотой. ЭХЭМҮТ-д 2025 онд эхийн ноцтой хүндрэлийн харьцаа 6.3, эхийн амь насанд заналхийлсэн хүндрэлийн харьцаа 6.3, өөрөөр хэлбэл, 1000 амьд төрөлтөд амь насанд заналхийлсэн хүндрэлтэй 6 эх үйлчлүүлж амь нас нь аврагджээ. ЭХЭМҮТ-д 2025 онд бүртгэгдсэн эхийн ноцтой хүндрэлийн (n=53) тохиолдлын 60.4% (n=32) умайн үйл ажиллагааны, 28.3% (n=15) зүрх судасны үйл ажиллагааны, 9.4% (n=5) бүлэгнэлтийн үйл ажиллагааны, 1.9% (n=1) элэгний үйл ажиллагааны алдагдалтай байлаа.

**Хүснэгт 6. Амьд төрөлт, эхийн амь насанд заналхийлсэн хүндрэл, хүндрэлийн харьцаа, Монгол Улс, аймгийн дүн**

| Сонгосон үзүүлэлт | Улсын дүн | | | | | Аймгийн дүн | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2021 | 2022 | 2023 | 2024 | 2025 | 2021 | 2022 | 2023 | 2024 | 2025 |
| Амьд төрөлт | **71659** | **65586** | **64306** | **57756** | **54137** | **35243** | **30389** | **30008** | **26336** | **24466** |
| Эхийн амь насанд заналхийлсэн хүндрэл (ЭАНЗХ)* | 229 | 212 | 232 | 198 | **158** | 90 | 84 | 71 | 62 | 53 |
| Эхийн амь насанд заналхийлсэн хүндрэлийн харьцаа | 3.2 | 3.2 | 3.6 | 3.4 | 2.9 | 2.6 | 2.8 | 2.4 | 2.4 | 2.2 |
| Эндсэн эх (ЭЭ) | 68 | 23 | 17 | 13 | 17 | 25 | 13 | 4 | 6 | 7 |
| Эхийн эндэгдлийн харьцаа | 94.9 | 35.1 | 26.4 | 22.5 | 31.4 | 70.9 | 42.8 | 13.3 | 22.8 | 28.6 |
| Эхийн ноцтой хүндрэл (ЭНХ) | 161 | 189 | 215 | 185 | 141 | 65 | 71 | 67 | 56 | 46 |
| Эхийн ноцтой хүндрэлийн харьцаа | 2.2 | 2.9 | 3.3 | 3.2 | 2.6 | 1.8 | 2.3 | 2.2 | 2.1 | 1.9 |

Хүснэгт 7. Амьд төрөлт, эхийн амь насанд заналхийлсэн хүндрэл, хүндрэлийн харьцаа, Улаанбаатар хот, ЭХЭМҮТ

| Сонгосон үзүүлэлт | Улаанбаатар | | | | | ЭХЭМҮТ | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2021 | 2022 | 2023 | 2024 | 2025 | 2021 | 2022 | 2023 | 2024 | 2025 |
| Амьд төрөлт | **36416** | **35197** | **34298** | **31420** | **29671** | **10623** | **9556** | **8471** | **8856** | **8378** |
| Эхийн амь насанд заналхийлсэн хүндрэл (ЭАНЗХ)* | 139 | 128 | 161 | 136 | 105 | 60 | 54 | 71 | 65 | 53 |
| Эхийн амь насанд заналхийлсэн хүндрэлийн харьцаа | 3.8 | 3.6 | 4.7 | 4.3 | 3.5 | 5.6 | 5.7 | 8.4 | 7.3 | 6.3 |
| Эндсэн эх (ЭЭ) | 43 | 10 | 13 | 7 | 10 | 14 | 3 | 3 | 2 | 0 |
| Эхийн эндэгдлийн харьцаа | 118.1 | 28.4 | 37.9 | 22.3 | 33.7 | 131.8 | 31.4 | 35.4 | 22.6 | 0 |
| Эхийн ноцтой хүндрэл (ЭНХ) | 96 | 118 | 148 | 129 | 95 | 46 | 51 | 68 | 63 | 53 |
| Эхийн ноцтой хүндрэлийн харьцаа | 2.6 | 3.4 | 4.3 | 4.1 | 3.2 | 4.3 | 5.3 | 8.0 | 7.1 | 6.3 |




Зураг 17. Эхийн эндэгдлийн харьцаа, Монгол Улс, ЭХЭМҮТ, 2021-2025 он




Зураг 18. Эхийн ноцтой хүндрэлийн харьцаа, Монгол Улс, ЭХЭМҮТ, 2021-2025 он

**Хүснэгт 8. Ноцтой хүндрэл, эрхтэн тогтолцооны үйл ажиллагааны алдагдал, ЭХЭМҮТ, 2021-2025 он**

| ЭРХТЭН ТОГТОЛЦООНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АЛДАГДАЛ | 2021<br>(n=46) | 2022<br>(n=51) | 2023<br>(n=68) | 2024<br>(n=63) | 2025<br>(n=53) |
|---|---|---|---|---|---|
| Умайн үйл ажиллагааны алдагдал | 36<br>78.3 | 41<br>80.4 | 35<br>51.5 | 40<br>63.5 | 32<br>60.4 |
| Зүрх судасны үйл ажиллагааны алдагдал | 4<br>8.7 | 6<br>11.8 | 21<br>30.9 | 13<br>20.6 | 15<br>28.3 |
| Бүлэгнэлтийн алдагдал | | 3<br>5.9 | 10<br>14.7 | 8<br>12.7 | 5<br>9.4 |
| Бөөрний үйл ажиллагааны алдагдал | | 1<br>2.0 | 1<br>1.5 | 1<br>1.6 | |
| Амьсгалын эрхтэн тогтолцооны үйл ажиллагааны алдагдал | | | 1<br>1.5 | | |
| Мэдрэлийн үйл ажиллагааны алдагдал | 1<br>2.2 | | | | |
| Элэгний үйл ажиллагааны алдагдал | 5<br>10.9 | | | 1<br>1.6 | 1<br>1.9 |
| **Бүгд** | **46<br>100.0** | **51<br>100.0** | **68<br>100.0** | **63<br>100.0** | **53<br>100.0** |




**Зураг 19. Умайн үйл ажиллагааны алдагдал, ЭХЭМҮТ, 2021-2025 он**

ЭХЭМҮТ-өөс 2025 онд эхийн ноцтой хүндрэлд умайн үйл ажиллагааны алдагдлаар бүртгэгдсэн (n=32) эхийн 81.3% (n=26) цус алдалтын, 18.8% (n=6) халдварын шалтгаантай байна.

**Дүгнэлт:**

- ✓ ЭХЭМҮТ-д 2025 онд 8136 эх амаржиж, 8378 хүүхэд амьд төрсөн ба амаржсан эх өмнөх оноос 6.4% (n=553), амьд төрөлт 5.4% (n=478)-иар тус тус буурсан байна.
- ✓ 2025 онд ЭХЭМҮТ-д эхийн эндэгдлийн тохиолдол гараагүй байна.
- ✓ Эхийн ноцтой хүндрэлийн харьцаа, мөн эхийн амь насанд заналхийлсэн хүндрэлийн харьцаа 6.3 байна.
- ✓ Эхийн ноцтой хүндрэлийн тохиолдлын тоо 2021 оны мөн үеэс 7 тохиолдлоор нэмэгдсэн ба эхийн амь насыг аварч чадсан байна.
- ✓ Эхийн ноцтой хүндрэлд умайн үйл ажиллагааны алдагдал давамгайлж байна.

### Хүснэгт 9. Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв - Эрүүл мэндийн үндсэн үзүүлэлт, 2024-2025 он

| Он | Эмнэлэг тасаг | Төсөвт ор | Тайлангийн хугацаанд | | | | | | | | | | | | | | | Хэвтэн эмчлүүлсэн хүний тоо | Чанарын үзүүлэлт | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Шинээр нэмж хэвтсэн өвчтөн | Гарсан, шилжсэн | | Нас барсан | | | | | | | | | | | | | Орны эргэлт | Дундаж ор хоног | Орны ээлхүүн | Ор хоногийн төлөвлөгөө | Ашигласан ор хоног | Үүнээс хөдөөний | Ор хоногийн төлөвлөгөөний биелэлтийн хувь |
| | | | | Бүгд | Орон нутгийн | Бүгд | | Үүнээс | | Орон нутгаас | | | | Задлан шинжилгээ хийсэн | | Онош тохирсон | | | | | | | | | |
| | | | | | | | | Хоног болоогүй | | Бүгд | | Хоног болоогүй | | | | | | | | | | | | | |
| | | | | | | тоо | % | тоо | % | тоо | % | тоо | % | тоо | % | тоо | % | | | | | | | | |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 | 13 | 14 | 15 | 16 | 17 | 18 | 19 | 20 | 21 | 22 | 23 | 24 | 25 | 26 |
| 2024 он | Дотрын тасгууд | 273 | 8972 | 8705 | 2785 | 222 | 2.5 | 10 | 4.5 | 103 | 46.4 | 2 | 1.9 | 161 | 72.5 | 158 | 98.1 | 8950 | 32.8 | 10.7 | 351.1 | 90090 | 95842 | 35997 | 106.4 |
| | Мэс заслын тасгууд | 151 | 9887 | 9904 | 3111 | 6 | 0.1 | 1 | 16.7 | 4 | 66.7 | | | 6 | 100.0 | 3 | 50.0 | 9899 | 65.6 | 5.4 | 355.2 | 49830 | 53634 | 17446 | 107.6 |
| | **Хүүхдийн эмнэлэг** | **424** | **18859** | **18609** | **5896** | **228** | **1.2** | **11** | **4.8** | **107** | **46.9** | **2** | **1.9** | **167** | **73.2** | **161** | **96.4** | **18848** | **44.5** | **7.9** | **352.5** | **139920** | **149476** | **53443** | **106.8** |
| | **ЭБЭЭмнэлэг** | **256** | **15340** | **15311** | **7541** | **137** | **0.9** | **1** | **0.7** | **52** | **38.0** | **15** | **28.8** | **104** | **75.9** | **97** | **93.3** | **15394** | **60.1** | **4.71** | **283.4** | **84480** | **72560** | **35090** | **85.9** |
| | **Төвийн дүн** | **680** | **34199** | **33920** | **13437** | **365** | **1.1** | **12** | **3.3** | **159** | **43.6** | **17** | **10.7** | **271** | **74.2** | **258** | **95.2** | **34242** | **50.4** | **6.5** | **326.5** | **224400** | **222036** | **88533** | **98.9** |
| 2025 он | Дотрын тасгууд | 273 | 9032 | 8773 | 2805 | 201 | 2.2 | 19 | 9.5 | 93 | 46.3 | 2 | 2.2 | 118 | 58.7 | 111 | 94.1 | 9003 | 33 | 10.2 | 334.9 | 90090 | 91436 | 39778 | 101.5 |
| | Мэс заслын тасгууд | 151 | 9465 | 9529 | 2945 | 16 | 0.2 | 1 | 6.3 | 9 | 56.3 | | | 12 | 75.0 | 11 | 91.7 | 9505 | 62.9 | 5.3 | 335.8 | 49830 | 50709 | 16332 | 101.8 |
| | **Хүүхдийн эмнэлэг** | **424** | **18497** | **18302** | **5750** | **217** | **1.2** | **20** | **9.2** | **102** | **47.0** | **2** | **2.0** | **130** | **59.9** | **122** | **93.8** | **18508** | **43.7** | **7.7** | **335.2** | **139920** | **142145** | **56110** | **101.6** |
| | **ЭБЭЭмнэлэг** | **256** | **15983** | **16008** | **7403** | **152** | **0.9** | | | **68** | **44.7** | **21** | **30.9** | **99** | **65.1** | **97** | **98.0** | **16072** | **62.8** | **4.93** | **309.7** | **84480** | **79288** | **36867** | **93.9** |
| | **Төвийн дүн** | **680** | **34480** | **34310** | **13153** | **369** | **1.1** | **20** | **5.4** | **170** | **46.1** | **16** | **9.4** | **229** | **62.1** | **219** | **95.6** | **34580** | **50.9** | **6.4** | **325.6** | **224400** | **221433** | **92977** | **98.7** |

### Хүснэгт 10. ЭХЭМҮТ-д хэвтэн эмчлүүлээд гарсан өвчтөн, аймаг, дүүргээр, 2025 он

| Сонгосон үзүүлэлт | | Хот | | | | | | | | | | Хөдөө | | | | | | | | | | | | | | | | | | | | | | Нийт |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | БГД | БЗД | СХД | СБД | ХУД | ЧД | Налайх | Багануур | Багахангай | Бүгд | Архангай | Баян-Өлгий | Баянхонгор | Булган | Говь-Алтай | Дорноговь | Дорнод | Дундговь | Завхан | Өвөрхангай | Өмнөговь | Сүхбаатар | Сэлэнгэ | Төв | Увс | Ховд | Хөвсгөл | Хэнтий | Дархан | Орхон | Говьсүмбэр | Бүгд | |
| | | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 | 13 | 14 | 15 | 16 | 17 | 18 | 19 | 20 | 21 | | |
| Хүүхдийн дотрын тасгууд | тоо | 1043 | 1474 | 1304 | 484 | 863 | 597 | 122 | 69 | 12 | **5968** | 152 | 142 | 158 | 109 | 58 | 107 | 103 | 84 | 109 | 184 | 123 | 117 | 192 | 276 | 97 | 115 | 224 | 130 | 139 | 154 | 32 | **2805** | **8773** |
| | хувь | 17.5 | 24.7 | 21.8 | 8.1 | 14.5 | 10.0 | 2.0 | 1.2 | 0.2 | **68.0** | 5.4 | 5.1 | 5.6 | 3.9 | 2.1 | 3.8 | 3.7 | 3.0 | 3.9 | 6.6 | 4.4 | 4.2 | 6.8 | 9.8 | 3.5 | 4.1 | 8.0 | 4.6 | 5.0 | 5.5 | 1.1 | **32.0** | **100.0** |
| Хүүхдийн мэс заслын тасгууд | тоо | 1157 | 1588 | 1467 | 656 | 879 | 596 | 144 | 81 | 14 | **6582** | 176 | 144 | 112 | 115 | 60 | 121 | 100 | 86 | 128 | 164 | 138 | 105 | 216 | 276 | 102 | 107 | 221 | 164 | 234 | 136 | 42 | **2947** | **9529** |
| | хувь | 17.6 | 24.1 | 22.3 | 10.0 | 13.4 | 9.1 | 2.2 | 1.2 | 0.2 | **69.1** | 6.0 | 4.9 | 3.8 | 3.9 | 2.0 | 4.1 | 3.4 | 2.9 | 4.3 | 5.6 | 4.7 | 3.6 | 7.3 | 9.4 | 3.5 | 3.6 | 7.5 | 5.6 | 7.9 | 4.6 | 1.4 | **30.9** | **100.0** |
| **Хүүхдийн эмнэлэг** | тоо | 2200 | 3062 | 2771 | 1140 | 1742 | 1193 | 266 | 150 | 26 | **12550** | 328 | 286 | 270 | 224 | 118 | 228 | 203 | 170 | 237 | 348 | 261 | 222 | 408 | 552 | 199 | 222 | 445 | 294 | 373 | 290 | 74 | **5752** | **18302** |
| | хувь | 17.5 | 24.4 | 22.1 | 9.1 | 13.9 | 9.5 | 2.1 | 1.2 | 0.2 | **68.6** | 5.7 | 5.0 | 4.7 | 3.9 | 2.1 | 4.0 | 3.5 | 3.0 | 4.1 | 6.1 | 4.5 | 3.9 | 7.1 | 9.6 | 3.5 | 3.9 | 7.7 | 5.1 | 6.5 | 5.0 | 1.3 | **31.4** | **100.0** |
| **Эх барих эмэгтэйчүүдийн эмнэлэг** | тоо | 1598 | 1564 | 3093 | 600 | 976 | 519 | 155 | 89 | 11 | **8605** | 573 | 279 | 368 | 276 | 249 | 294 | 221 | 219 | 342 | 432 | 380 | 210 | 583 | 696 | 324 | 241 | 535 | 358 | 516 | 240 | 67 | **7403** | **16008** |
| | хувь | 18.6 | 18.2 | 35.9 | 7.0 | 11.3 | 6.0 | 1.8 | 1 | 0.1 | **53.8** | 7.7 | 3.8 | 5.0 | 3.7 | 3.4 | 4.0 | 3.0 | 3.0 | 4.6 | 5.8 | 5.1 | 2.8 | 7.9 | 9.4 | 4.4 | 3.3 | 7.2 | 4.8 | 7.0 | 3.2 | 0.9 | **46.2** | **100.0** |
| **ЭХЭМҮТ** | тоо | **3798** | **4626** | **5864** | **1740** | **2718** | **1712** | **421** | **239** | **37** | **21155** | **901** | **565** | **638** | **500** | **367** | **522** | **424** | **389** | **579** | **780** | **641** | **432** | **991** | **1248** | **523** | **463** | **980** | **652** | **889** | **530** | **141** | **13155** | **34310** |
| | хувь | **18.0** | **21.9** | **27.7** | **8.2** | **12.8** | **8.1** | **2.0** | **1.1** | **0.2** | **61.7** | **6.8** | **4.3** | **4.8** | **3.8** | **2.8** | **4.0** | **3.2** | **3.0** | **4.4** | **5.9** | **4.9** | **3.3** | **7.5** | **9.5** | **4.0** | **3.5** | **7.4** | **5.0** | **6.8** | **4.0** | **1.1** | **38.3** | **100.0** |

**ДҮГНЭЛТ**

- ✓ ЭХЭМҮТ 2016 оноос өмнө 665 төсөвт ортой үйл ажиллагаагаа явуулж байсан бол 2016 оноос эхлэн шинээр 15 ор нэмэгдэн өргөжиж, 2025 онд 680 ортой ажилласан.
- ✓ 2025 оны ЭХЭМҮТ-ийн нэг оронд дунджаар хэвтэн эмчлүүлсэн өвчтний дундаж тоо буюу орны эргэлт 50.9, нэг өвчтнийг эмнэлэгт хэвтүүлэн эмчилсэн дундаж ор хоног 6.4, нэг орыг ашигласан дундаж хоногийн тоо ба орны фонд ашиглалт 325.6, ор хоногийн төлөвлөгөөний биелэлтийн хувь 98.7 байна.
- ✓ 2025 онд ЭХЭМҮТ-ийн хэвтэн эмчлүүлэгчид өнгөрсөн оны мөн үеэс 1.0 пунктээр өссөн.
- ✓ ЭХЭМҮТ-д 2025 онд 8136 эх төрж, 8378 хүүхэд амьд төрсөн ба амаржсан эх өмнөх оноос 6.4%, амьд төрөлт 5.4%-иар тус тус буурсан байна.
- ✓ 2025 онд задлан шинжилгээний хувь 12.1 пунктээр буурсан ба оношийн тохирооны хувь 0.2-оор буурсан байна.
- ✓ ЭХЭМҮТ-д 2025 онд нярайн эндэгдлийн түвшин 22.0 болж өнгөрсөн оны мөн үеэс 3.7 пунктээр өссөн байна.
- ✓ ЭХЭМҮТ-д 2025 онд эхийн эндэгдлийн тохиолдол гараагүй.
- ✓ 2025 онд ЭХЭМҮТ-д эхийн ноцтой хүндрэлийн харьцаа, эхийн амь насанд заналхийлсэн хүндрэлийн харьцаа 6.3 байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 1.0 пунктээр буурсан байна.

# 3. ТӨРӨЛХИЙН ХӨГЖЛИЙН ГАЖИГ, МОНГОЛ УЛС, ЭХЭМҮТ

Монгол Улсад 2025 онд нийт 54137 хүүхэд амьд төрж, төрөлхийн хөгжлийн гажиг (ТХГ)-ийн 488 тохиолдол бүртгэгдэж улсын хэмжээнд 1000 амьд төрөлтөд 9.0 промил байгаа нь нийт амьд төрсөн хүүхдийн 0.9%-ийг эзэлж байна. Улсын хэмжээнд 2025 онд ТХГ-тай төрсөн нярайн түвшин хот, хөдөө, орон нутгийн хувьд ялгавартай байна. 2025 онд бүртгэгдсэн нярайн дунд (1000 амьд төрөлтөд) ТХГ-тай нярайн түвшин Хөвсгөл (16.4), Говь-Алтай (13.5), Дорноговь (11.6), Баян-Өлгий (11.4), Дорнод (11.2), Булган (10.9), Улаанбаатар (10.3) хотод улсын дунджаас өндөр байлаа. 2025 онд улсын хэмжээнд ТХГ-тай төрсөн (488) нярайн өвчний оношийг ӨОУА 10-аар авч үзэхэд 29.7% (145) цусны эргэлтийн тогтолцооны гажиг, 17.0% (83) яс-булчингийн тогтолцооны гажиг, 14.1% (69) сэтэрхий уруул ба тагнайн гажиг, 10.2% (50) олон эрхтний хавсарсан гажиг, 7.6% (37) хоол боловсруулах тогтолцооны бусад төрөлх гажиг илүүтэй тохиолдсон байлаа.

**Хүснэгт 11. Төрөлхийн хөгжлийн гажигтай бүртгэгдсэн нярай, ӨОУА-10, ЭХЭМҮТ, 2021-2025 он**

| Өвчний олон улсын ангилал | Өвчний код | ТХГ-тай бүртгэгдсэн нярай | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | 2021<br>n (%) | 2022<br>n (%) | 2023<br>n (%) | 2024<br>n (%) | 2025<br>n (%) |
| Мэдрэлийн тогтолцооны төрөлх гажиг | Q00-Q07 | 13<br>7.9 | 14<br>8.0 | 14<br>7.5 | 15<br>10.8 | **16<br>9.2** |
| Нүд, чих, нүүр ба хүзүүний төрөлх гажиг | Q10-Q18 | 1<br>0.6 | 1<br>0.6 | 2<br>1.1 | 4<br>2.9 | 5<br>2.9 |
| Цусны эргэлтийн тогтолцооны төрөлх гажиг | Q20-Q28 | 38<br>23.0 | 34<br>19.5 | 46<br>24.7 | 23<br>16.5 | **34<br>19.7** |
| Амьсгалын тогтолцооны төрөлх гажиг | Q30-Q34 | 3<br>1.8 | 6<br>3.4 | 4<br>2.2 | 4<br>2.9 | 7<br>4.0 |
| Сэтэрхий уруул ба тагнай | Q35-Q37 | 25<br>15.2 | 19<br>10.9 | 31<br>16.7 | 21<br>15.1 | **28<br>16.2** |
| Хоол боловсруулах тогтолцооны бусад төрөлх гажиг | Q38-Q45 | 9<br>5.5 | 25<br>14.4 | 19<br>10.2 | 22<br>15.8 | 15<br>8.7 |
| Бэлэг эрхтний төрөлх гажиг | Q50-Q56 | - | - | 2<br>1.1 | - | - |
| Шээс ялгаруурах тогтолцооны төрөлх гажиг | Q60-Q64 | 4<br>2.4 | 6<br>3.4 | 21<br>11.3 | 9<br>6.5 | 15<br>8.7 |
| Яс-булчингийн тогтолцооны төрөлх гажиг ба гаж хөгжил | Q65-Q79 | 28<br>17.0 | 30<br>17.2 | 20<br>10.8 | 17<br>12.2 | **24<br>13.9** |
| Бусад төрөлх гажиг | Q80-Q89 | 1<br>0.6 | 4<br>2.3 | - | 1<br>0.7 | 3<br>1.7 |
| Өөр бүлэгт ангилаагүй хромосомын гажиг | Q90-Q99 | 6<br>3.6 | 5<br>2.9 | 1<br>0.5 | 1<br>0.7 | 3<br>1.7 |
| Олон эрхтний хавсарсан гажиг | | 37<br>22.4 | 30<br>17.2 | 26<br>14.0 | 22<br>15.8 | **23<br>13.3** |
| **Бүгд** | | **165<br>100.0** | **174<br>100.0** | **186<br>100.0** | **139<br>100.0** | **173<br>100.0** |

2025 онд ЭХЭМҮТ-д ТХГ-тай бүртгэгдсэн (173) нярайн өвчний оношийг ӨОУА 10-аар авч үзэхэд 19.7 (34) цусны эргэлтийн тогтолцооны төрөлх гажиг, 16.2% (28) сэтэрхий уруул ба тагнайн гажиг, 13.9% (24) яс-булчингийн тогтолцооны төрөлх гажиг ба гаж хөгжил,13.3% (23) олон эрхтний хавсарсан гажиг, 9.2% (16) мэдрэлийн тогтолцооны төрөлх гажиг зонхилон тохиолджээ. Тодруулбал, 2021, 2022, 2023, 2024, 2025 онд цусны эргэлтийн тогтолцооны гажиг зонхилон тохиолдсон байна. Цаашилбал, цусны эргэлтийн тогтолцооны төрөлх гажиг 3.2, шээс ялгаруулах тогтолцооны төрөлх 2.2, яс-булчингийн тогтолцооны төрөлх гажиг ба гаж хөгжил 1.7 хувиар өссөн бол олон эрхтний хавсарсан гажиг 2.5, мэдрэлийн тогтолцооны төрөлх гажиг 1.5 хувиар тус тус буурсан байлаа.




**Зураг 20. ТХГ-ийн тэргүүлэх шалтгаан, хувиар, ЭХЭМҮТ, 2021-2025 он**

**Хүснэгт 12. Төрөлхийн хөгжлийн гажигтай төрсөн нярай, ӨОУА-10, ЭХЭМҮТ, 2021-2025 он**

| Өвчний олон улсын ангилал | Өвчний код | ТХГ-тай төрсөн нярай | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | 2021<br>n (%) | 2022<br>n (%) | 2023<br>n (%) | 2024<br>n (%) | 2025<br>n (%) |
| Мэдрэлийн тогтолцооны төрөлх гажиг | Q00-Q07 | 10<br>9.1 | 14<br>10.6 | 14<br>9.5 | 15<br>14.3 | 12<br>8.8 |
| Нүд, чих, нүүр ба хүзүүний төрөлх гажиг | Q10-Q18 | | | 2<br>1.4 | 3<br>2.9 | 4<br>2.9 |
| Цусны эргэлтийн тогтолцооны төрөлх гажиг | Q20-Q28 | 23<br>20.9 | 26<br>19.7 | 39<br>26.5 | 18<br>17.1 | 26<br>19.1 |
| Амьсгалын тогтолцооны төрөлх гажиг | Q30-Q34 | 3<br>2.7 | 3<br>2.3 | 4<br>2.7 | 4<br>3.8 | 5<br>3.7 |
| Сэтэрхий уруул ба тагнай | Q35-Q37 | 25<br>22.7 | 17<br>12.9 | 31<br>21.1 | 21<br>20.0 | 28<br>20.6 |
| Хоол боловсруулах тогтолцооны бусад төрөлх гажиг | Q38-Q45 | 4<br>3.6 | 22<br>16.7 | 8<br>5.4 | 7<br>6.7 | 8<br>5.9 |
| Бэлэг эрхтний төрөлх гажиг | Q50-Q56 | | | 2<br>1.4 | | |
| Шээс ялгаруурах тогтолцооны төрөлх гажиг | Q60-Q64 | 4<br>3.6 | 4<br>3.0 | 18<br>12.2 | 10<br>9.5 | 15<br>11.0 |
| Яс-булчингийн тогтолцооны төрөлх гажиг ба гаж хөгжил | Q65-Q79 | 22<br>20.0 | 25<br>18.9 | 17<br>11.6 | 18<br>17.1 | 24<br>17.6 |
| Бусад төрөлх гажиг | Q80-Q89 | 11<br>10.0 | 12<br>9.1 | 9<br>6.1 | 6<br>5.7 | 10<br>7.4 |
| Өөр бүлэгт ангилаагүй хромосомын гажиг | Q90-Q99 | 8<br>7.3 | 9<br>6.8 | 3<br>2.0 | 3<br>2.9 | 4<br>2.9 |
| **Бүгд** | | **110<br>100.0** | **132<br>100.0** | **147<br>100.0** | **105<br>100.0** | **136<br>100.0** |

ЭХЭМҮТ-д 2024 онд (амьд төрөлт 8856, ТХГ-тай төрсөн хүүхэд 105) 1000 амьд төрөлтөд ногдох ТХГ-тай нярайн түвшин 11.9 байсан бол 2025 онд (амьд төрөлт 8378, ТХГ-тай төрсөн хүүхэд 136) 16.2 болж 4.3 промилоор өссөн байна. Хүснэгтээс харахад 2025 онд ЭХЭМҮТ-д төрсөн ТХГ-тай нярайн эмгэгт (19.1%) цусны эргэлтийн тогтолцооны төрөлх гажиг, (20.6%) сэтэрхий уруул ба тагнай, (17.6%) яс-булчингийн тогтолцооны төрөлх гажиг ба гаж хөгжил зонхилон тохиолдсон байлаа.

# 4. ЭХЭМҮТ-ИЙН ЭХ БАРИХ ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ

## 4.1. Хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээ

2025 онд Эх барих эмэгтэйчүүдийн эмнэлэг (ЭБЭЭ) 256 төсөвт ортой ажилласан ба ЭХЭМҮТ-ийн төсөвт орны 37.6%-ийг эзэлж байна.




**Зураг 21. Төсөвт ор, ЭБЭЭ, ЭХЭМҮТ, 2025 он**




**Зураг 22. Хэвтэн эмчлүүлэгчид, ЭБЭЭ, ЭХЭМҮТ, 2021-2025 он**

ЭБЭЭ-т 2025 онд 15996 хүн хэвтэн эмчлүүлсэн, нийт хэвтэн эмчлүүлэгчдийн 46.3% хөдөө орон нутгаас ирж үйлчлүүлсэн. 2025 онд ЭБЭЭ-ийн нэг өвчтөнг эмнэлэгт хэвтүүлэн эмчилсэн **дундаж ор хоног 5**.0, нэг орыг ашигласан дундаж хоногийн тоо ба **орны фонд ашиглалт** 309.7, эмнэлгийн нэг оронд хэвтэн эмчлүүлсэн өвчтний дундаж тоо буюу **орны эргэлт** 62.5 байна. ЭХЭМҮТ-ийн Эх барих эмэгтэйчүүдийн эмнэлгийн ор хоногийн төлөвлөгөөний биелэлт 2025 онд 93.9% байна.




**Зураг 23. Орны үзүүлэлтүүд, ЭБЭЭ, ЭХЭМҮТ, 2021-2025 он**




**Зураг 24. Ор хоногийн төлөвлөгөөний биелэлтийн хувь, ЭБЭЭ, ЭХЭМҮТ, 2021-2025 он**

2024 онд тус эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчдийн 50.7% Улаанбаатар хотоос хэвтэн эмчлүүлсний 39.4% СХД, 18.2% БГД, 16.7% БЗД, 11.8% ХУД-ийн харьяалалтай байлаа.




**Зураг 25. Улаанбаатар хотоос хэвтэн эмчлүүлэгчид, ЭБЭЭ, ЭХЭМҮТ, 2025 он**

ЭХЭМҮТ-ийн ЭБЭЭ-т 2025 онд хөдөө орон нутгаас ирж хэвтэн эдгэрч гарагсдын 9.4% Төв, 7.9% Сэлэнгэ, 7.7% Архангай, 7.2% Хөвсгөл, 7.0% Дархан-Уул аймгийн харьяалалтай байв.




**Зураг 26. ЭХЭМҮТ-ийн ЭБЭЭ-т хэвтэн эдгэрч гарагсад, аймгаар (тоо, хувь), 2025 он**

2025 онд ЭБЭЭ-т 8136 эх амаржсан ба нийт амаржсан эхийн 47.3% хөдөө орон нутгаас ирж үйлчлүүлсэн байна.




**Зураг 27. Төрсөн эх, насны бүлэг, ЭБЭЭ, ЭХЭМҮТ, 2025 он**

2025 онд амаржсан эхчүүдийг нөхөн үржихүйн насны бүлгээр авч үзэхэд 26.2% 25-29 насанд төрсөн ба өсвөр насны эмэгтэйчүүдийн төрөлт 4.1%-ийг эзэлж байгаа нь 2024 оноос 0.5 пунктээр өссөн байна.




**Зураг 28. Төрөлтийн төгсгөлийн хэлбэр, ЭБЭЭ, ЭХЭМҮТ, 2025 он**

2025 онд амаржсан эхийн 31.6% (n=2568) кесар хагалгаагаар төрсөн байна.




**Зураг 29. Үр хөндөлт, ЭБЭЭ, ЭХЭМҮТ, 2025 он**

2025 онд ЭХЭМҮТ-д 1294 эмэгтэйд үр хөндөлт хийгдсэнээс 92.4% (n=1196) эрт, 7.6% (n=98) хожуу үеийн үр хөндөлт хийгдсэн байлаа.




**Зураг 30. Үр хөндөлт, насны бүлгээр, ЭБЭЭ, ЭХЭМҮТ, 2025 он**

Үр хөндүүлсэн эхчүүдийг нөхөн үржихүйн насны бүлгээр авч үзэхэд 15-аас доош насны эмэгтэйчүүд нийт үр хөндөлтийн 0.9%, 15-19 насны эмэгтэйчүүд 11.9%, 45-49 насны бүлэг 1.0%-ийг эзэлж байлаа. ЭХЭМҮТ-ийн ЭБЭЭ-т 2025 онд 7 ортой эхчүүдийн амрах байр нь ажиллаж, 56 эх хөдөө орон нутгаас ирж үйлчлүүлсэн ба ашигласан ор хоног 360 байна. 2025 онд ЭХЭМҮТ-ийн ЭБЭЭ-т нийт 8378 нярай амьд төрсөн бөгөөд нярайн төрөх үеийн жингээр нь авч үзэхэд 7473 тохиолдол буюу 89.2% нь 2500гр-аас дээш, 905 тохиолдол буюу 10.8% 2500гр-аас доош жинтэй төржээ.




**Зураг 31. Амьд төрсөн нярай, ЭБЭЭ, ЭХЭМҮТ, 2025 он**

Жирэмсэн, төрөх, төрсний дараах үеийн хүндрэл 9362 тохиолдсон байна. Төрөх үеийн эх барихын шалтгаант хүндрэлийн хувь 41.2, жирэмсэн үеийн эх барихын шалтгаант хүндрэлийн хувь 41.3, жирэмслэлт, төрөлтөөс үл хамаарах өвчний хүндрэлийн хувь 16.2, төрсний дараах үеийн эх барихын шалтгаант хүндрэлийн хувь 1.3 байв.




Зураг 32. Жирэмсэн, төрөх, төрсний дараах үеийн хүндрэл, ЭБЭЭ, ЭХЭМҮТ, 2025 он

2025 онд ЭХЭМҮТ-д нийт 11816 хэвтэн эмчлүүлэгчдэд мэс заслын эмчилгээ хийгдсэний 68.5% (n=8089) хүүхдийн эмнэлэгт, 31.5% (n=3727) эх барих эмэгтэйчүүдийн эмнэлэгт хийгдсэн. ЭБЭЭ-т хийгдсэн мэс заслын эмчилгээний 68.9%-ийг кесар хагалгаа эзэлж байна.




Зураг 33. Хагалгааны бүтэц, ЭБЭЭ, ЭХЭМҮТ, 2025 он

2025 онд ЭХЭМҮТ-ийн ЭБЭЭ-ийн амьгүй төрөлтийн түвшин 6.8 промил болж өмнөх оноос 1.9 промилоор буурсан.




Зураг 34. Амьгүй төрөлтийн түвшин, ЭБЭЭ, ЭХЭМҮТ, 2021-2025 он

ЭХЭМҮТ-д дутуу төрсөн эхийн эзлэх хувь 2024 онд 8.7 байсан бол 2025 онд 6.8 болж өнгөрсөн оны мөн үеэс 1.9 пунктээр буурчээ.

2025 онд ЭБЭЭ-т хэвтэн эмчлүүлэгчдийн өвчлөлийн бүтцийг ӨОУА-10-аар авч үзэхэд жирэмсэн, төрөлт ба төрсний дараах үе, шээс бэлгийн тогтолцооны өвчин зонхилон тохиолджээ.

**Хүснэгт 13. Өвчлөлийн бүтэц, стационарт хэвтэн эмчлүүлэгчид, ЭХЭМҮТ, ЭБЭЭ, 2021-2025 он**

| Өвчний бүлэг ӨОУА - 10 | 2021<br>n (%) | 2022<br>n (%) | 2023<br>n (%) | 2024<br>n (%) | 2025<br>n (%) |
|---|---|---|---|---|---|
| Халдварт ба шимэгчит зарим өвчин | 3<br>0.02 | 5<br>0.03 | 3<br>0.02 | 1<br>0.01 | 2<br>0.01 |
| Хавдар | 376<br>2.2 | 583<br>3.4 | 442<br>3.1 | 556<br>3.6 | 641<br>4.0 |
| Цус, цус төлжүүлэх эрхтний өвчин ба дархлааны механизм хамарсан зарим эмгэг | 2<br>0.01 | | | | |
| Дотоод шүүрэл, тэжээлийн ба бодисын солилцооны өвчнүүд | 1<br>0.01 | 1<br>0.01 | 1<br>0.01 | 1<br>0.01 | 3<br>0.02 |
| Нүд ба түүний дайврын өвчнүүд | | | | | |
| Чих ба хөхлөг сэртэнгийн өвчнүүд | | | | | |
| Зүрх судасны тогтолцооны өвчин | | | 1<br>0.01 | | |
| Хоол боловсруулах тогтолцооны өвчин | 3<br>0.02 | 3<br>0.02 | 3<br>0.02 | | |
| Мэдрэлийн тогтолцооны өвчин | | 1<br>0.01 | | | |
| Яс булчингийн тогтолцоо ба холбох эдийн өвчин | | 1<br>0.01 | | | |
| Шээс бэлгийн тогтолцооны эмгэг | 919<br>5.5 | 1449<br>8.5 | 923<br>6.4 | 932<br>6.1 | 1143<br>7.1 |
| Жирэмсэн, төрөлт ба төрсний дараах үе | 14930<br>89.1 | 14740<br>86.9 | 13088<br>90.3 | 13752<br>89.8 | 14133<br>88.3 |
| Төрөлх гажиг, гаж хөгжил ба хромосомын эмгэг | 22<br>0.1 | 11<br>0.06 | 12<br>0.08 | 9<br>0.1 | 13<br>0.08 |
| Гэмтэл, хордлого ба гадны шалтгаант бусад тодорхой эмгэг | 20<br>0.1 | 31<br>0.2 | 29<br>0.2 | 60<br>0.4 | 73<br>0.5 |
| Шалтгаан нь тодорхойгүй шинэ өвчний урьдчилсан ангилал /U00-U49/ | 472<br>2.8 | 128<br>0.8 | | | |
| **Бүгд** | **16748<br>100.0** | **16953<br>100.0** | **14502<br>100.0** | **15311<br>100.0** | **16008<br>100.0** |




**Зураг 35. Задлан шинжилгээний үзүүлэлт, ЭБЭЭ, ЭХЭМҮТ, 2021-2025 он**

2025 онд ЭБЭЭ-ийн нас баралтын ээлэх хувь 0.9, задлан шинжилгээний хувь 65.1, оношийн тохироо 98.0%-тай байна.

**Хүснэгт 14. ЭХЭМҮТ-ийн Эх барих эмэгтэйчүүдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний үзүүлэлт, 2025 он**

| | Тасгийн нэр | Төсөвт ор | Тайлангийн эхэнд байгаа өвчтөн | Тайлангийн хугацаанд: Шинээр нэмж хэвтсэн өвчтөн | Дотоод хөдөлгөөн: Өөр тасгаас ирсэн | Дотоод хөдөлгөөн: Өөр тасагт шилжсэн | Гарсан, шилжсэн: Бүгд | Гарсан, шилжсэн: Орон нутгийн | Нас барсан: Бүгд: тоо | Нас барсан: Бүгд: % | Үүнээс Хоног болоогүй: тоо | Үүнээс Хоног болоогүй: % | Перинатал эндэгдэл: тоо | Перинатал эндэгдэл: % | Үүнээс Хоног болоогүй: тоо | Үүнээс Хоног болоогүй: % | Орон нутгийн Бүгд: тоо | Орон нутгийн Бүгд: % | Орон нутгийн Хоног болоогүй: тоо | Орон нутгийн Хоног болоогүй: % | Задлан шинжилгээ хийсэн: тоо | Задлан шинжилгээ хийсэн: % | Онош тохирсон: тоо | Онош тохирсон: % | Тайлангийн эцэст байгаа өвчтөн | Хэвтэж эмчлүүлсэн хүний тоо | Чанар: Орны эргэлт | Дундаж ор хоног | Орны ээлхүүн | Ор хоногийн төлөвлөгөө | Ашигласан ор хоног | Үүнээс хөдөөний | Ор хоногийн төлөвлөгөөний биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | A | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 | 13 | 14 | 15 | 16 | 17 | 18 | 19 | 20 | 21 | 22 | 23 | 24 | 25 | 26 | 27 | 28 | 29 | 30 | 31 | 32 |
| Төрөх | Үр хөндөлт | | | 1138 | | | 1138 | 410 | | | | | | | | | | | | | | | | | | 1138 | | | | | 1138 | 410 | |
| Төрөх | Төрөх тасаг | 12 | 9 | 4467 | 3299 | 7772 | 0 | 0 | | | | | | | | | | | | | | | | | 3 | 2234 | 186.1 | 1.3 | 236 | 3960 | 2827 | 1387 | 71.4 |
| Төрөх | Төрсний дараах тасаг | 74 | 64 | 332 | 7495 | 32 | 7804 | 3676 | | | | | | | | | | | | | | | | | 55 | 4068 | 55.0 | 6.3 | 347 | 24420 | 25686 | 10773 | 105.2 |
| Төрөх | Эрсдэлтэй жирэмсэн судлалын тасаг | 64 | 46 | 5851 | 405 | 3451 | 2826 | 1236 | | | | | | | | | | | | | | | | | 25 | 4339 | 67.8 | 5.3 | 360 | 21120 | 23010 | 11631 | 108.9 |
| Төрөх | Дутуу тээлт судлалын тасаг | 25 | 30 | 853 | 402 | 154 | 1118 | 540 | | | | | | | | | | | | | | | | | 13 | 985.5 | 39.4 | 8.6 | 340 | 8250 | 8508 | 3896 | 103.1 |
| Төрөх | Эрчимт эмчилгээний тасаг | 9 | 2 | 216 | 132 | 337 | 5 | 4 | 1 | 0.3 | | | | | | | | | | | 1 | 100.0 | 1 | 100.0 | 7 | 345.5 | 38.4 | 6.4 | 245 | 2970 | 2209 | 1207 | 74.4 |
| | **Дүн** | **184** | **151** | **12857** | **11733** | **11746** | **12891** | **5866** | **1** | **0.01** | | | | | | | | | | | **1** | **100** | **1** | **100.0** | **103** | **12875** | **70.0** | **4.9** | **344.4** | **60720** | **63378** | **29304** | **104.4** |
| | Эмэгтэйчүүдийн мэс заслын тасаг | 36 | 15 | 2001 | 45 | 33 | 2006 | 1008 | | | | | | | | | | | | | | | | | 22 | 2004 | 55.7 | 5.1 | **283** | 11880 | 10186 | 5117 | 85.7 |
| | Эмэгтэйчүүдийн дотоод шүүрлийн эмгэг | 36 | | 1125 | 23 | 22 | 1111 | 529 | | | | | | | | | | | | | | | | | 15 | 1118 | 31.1 | 5.1 | **159** | 11880 | 5724 | 2446 | 48.2 |
| | **2025 оны бүтэн жил** | **256** | **166** | **15983** | **11801** | **11801** | **16008** | **7403** | **1** | **0.01** | | | | | | | | | | | **1** | **100.0** | **1** | **100.0** | **140** | **15996** | **62.5** | **5.0** | **310** | **84480** | **79288** | **36867** | **93.9** |
| | **2024 оны бүтэн жил** | **256** | **140** | **15340** | **11988** | **11988** | **15311** | **7541** | **2** | **0.01** | **1** | **50.0** | | | | | | | | | **2** | **100.0** | **1** | **50** | **167** | **15327** | **59.9** | **4.7** | **283.4** | **84480** | **72560** | **35090** | **85.9** |
| Нярай судлалын тасаг | Эрчимт эмчилгээний хэсэг | 15 | 25 | 889 | 181 | 538 | 393 | 246 | 142 | 13.2 | | | 122 | 85.9 | 37 | 30.3 | 63 | 44.4 | 18 | 28.6 | 89 | 62.7 | 87 | 97.8 | 13 | 1076 | 71.7 | 7.7 | 549 | 4950 | 8232 | 4273 | 166.3 |
| Нярай судлалын тасаг | Эрүүл нярайн хэсэг | 60 | 57 | 7473 | 64 | 186 | 7353 | 3455 | | | | | | | | | | | | | | | | | 55 | 7413 | 123.6 | 3.1 | 386 | 19800 | 23142 | 9032 | 116.9 |
| Нярай судлалын тасаг | **2025 он** | **75** | **82** | **8362** | **245** | **724** | **7746** | **3701** | **151** | **1.9** | | | **131** | **86.8** | **41** | **31.3** | **68** | **45** | **21** | **30.9** | **98** | **64.9** | **96** | **98.0** | **68** | **8130** | **108.4** | **3.9** | **418** | **24750** | **31374** | **13305** | **126.8** |
| Нярай судлалын тасаг | **2024 он** | 75 | 63 | 8813 | 219 | 615 | 8263 | 4386 | 135 | 1.6 | | | 112 | 83.0 | 45 | 40.2 | 52 | 38.5 | 15 | 28.8 | 102 | 75.6 | 96 | 94.1 | 82 | 8606 | 114.7 | 3.6 | 416 | 24750 | 31220 | 14245 | 126.1 |

## Хүснэгт 15. ЭХЭМҮТ-ийн төрөлтийн мэдээлэл, 2025 он

| Тасгууд | | Төрсөн эхийн тоо | | | | | | | Амьд төрсөн нярай | | | | | | | | | Ихэр төрөлт | | Ихэр төрсөн нярай | | | | | | | Амьгүй төрөлт | | Амьгүй төрсөн нярай | | | | | | | | Дутуу төрсөн эх | | | | Гэрийн төрөлт | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Үүнээс | | | Үүнээс | | | | | | | | | | Үүнээс | | | | | | | | | Үүнээс | | | | | | | | | | | | | |
| | | Нийт төрөлт | Орон нутгаас | | Кесарево | | Орон нутгаас | | Бүгд | 2500-с дээш жинтэй | | 1000-2499 хүртэл жинтэй | | 500-1000 хүртэл | | Орон нутгаас | | | | Орон нутгаас | | Ихэр төрсөн нярай хүүхдийн | 2500-с дээш жинтэй | | 2500 хүртэл жинтэй | | | | Орон нутгаас | | 2500-с дээш жинтэй | | 1000-2499 хүртэл жинтэй | | 500-1000 хүртэл | | Бүгд | | Орон нутгаас | | | |
| | | | тоо | % | тоо | % | тоо | % | тоо | тоо | % | тоо | % | тоо | % | тоо | % | тоо | % | тоо | % | тоо | тоо | % | тоо | % | тоо | % | тоо | % | тоо | % | тоо | % | тоо | % | тоо | % | тоо | % | тоо | % |
| Эхний хагас жил | Төрөх тасаг | 3733 | 1763 | 47.2 | 1088 | 29.1 | 452 | 41.5 | 3806 | 3668 | 96.4 | 135 | 3.5 | 3 | 0.1 | 1792 | 47.1 | 79 | 2.1 | 33 | 41.8 | 158 | 106 | 67.1 | 52 | 32.9 | 8 | 0.2 | 4 | 50.0 | 4 | 50 | 4 | 100 | | | 77 | 2.1 | 44 | 57.1 | 10 | 0.3 |
| | Дутуу тээлт судлалын тасаг | 318 | 149 | 46.9 | 163 | 51.3 | 76 | 46.6 | 368 | 52 | 14.1 | 262 | 71.2 | 54 | 14.7 | 171 | 46.5 | 62 | 19.5 | 31 | 50.0 | 126 | 14 | 11.1 | 112 | 88.9 | 12 | 3.3 | 9 | 75.0 | 1 | 8.3 | 7 | 58.3 | 4 | 33.3 | 309 | 97.2 | 145 | 46.9 | 2 | 0.6 |
| | **2025 он** | **4051** | **1912** | **47.2** | **1251** | **30.9** | **528** | **42.2** | **4174** | **3720** | **89.1** | **397** | **9.5** | **57** | **1.4** | **1963** | **47.0** | **141** | **3.5** | **64** | **45.4** | **284** | **120** | **42.3** | **164** | **57.7** | **20** | **0.5** | **13** | **65.0** | **5** | **25.0** | **11** | **55.0** | **4** | **20.0** | **386** | **9.5** | **189** | **49.0** | **12** | **0.3** |
| | **2024 он** | **4155** | **2176** | **52.4** | **1200** | **28.9** | **565** | **47.1** | **4233** | **3825** | **90.4** | **357** | **8.4** | **51** | **1.2** | **2208** | **52.2** | **117** | **2.8** | **54** | **46.2** | **238** | **108** | **45.4** | **130** | **54.6** | **43** | **1.0** | **22** | **51.2** | **7** | **16.3** | **21** | **48.8** | **15** | **34.9** | **344** | **8.3** | **159** | **46.2** | **21** | **0.5** |
| Сүүлийн хагас жил | Төрөх тасаг | 3745 | 1768 | 47.2 | 1144 | 30.5 | 495 | 43.3 | 3829 | 3717 | 97.1 | 112 | 2.9 | | | 1790 | 46.7 | 94 | 2.5 | 31 | 33.0 | 189 | 131 | 69.3 | 58 | 30.7 | 9 | 0.2 | 9 | 100.0 | 6 | 66.7 | 3 | 33.3 | | | 70 | 1.9 | 35 | 50.0 | 16 | 0.4 |
| | Дутуу тээлт судлалын тасаг | 340 | 169 | 49.7 | 173 | 50.9 | 84 | 48.6 | 375 | 36 | 9.6 | 278 | 74.1 | 61 | 16.3 | 178 | 47.5 | 59 | 17.4 | 22 | 37.3 | 120 | 7 | 5.8 | 113 | 94.2 | 28 | 7.5 | 13 | 46.4 | 2 | 7.1 | 13 | 46.4 | 13 | 46.4 | 338 | 99.4 | 169 | 55.2 | 2 | 0.6 |
| | **2025 он** | **4085** | **1937** | **47.4** | **1317** | **32.2** | **579** | **44.0** | **4204** | **3753** | **89.3** | **390** | **9.3** | **61** | **1.5** | **1968** | **46.8** | **153** | **3.7** | **53** | **34.6** | **309** | **138** | **44.7** | **171** | **55.3** | **37** | **0.9** | **22** | **59.5** | **8** | **21.6** | **16** | **43.2** | **13** | **35.1** | **408** | **10.0** | **204** | **54.3** | **18** | **0.4** |
| | **2024 он** | **4534** | **2123** | **46.8** | **1338** | **29.5** | **523** | **39.1** | **4623** | **4196** | **90.8** | **372** | **8.0** | **55** | **1.2** | **2146** | **46.4** | **122** | **2.7** | **43** | **35.2** | **246** | **130** | **52.8** | **116** | **47.2** | **35** | **0.8** | **20** | **57.1** | **11** | **31.4** | **15** | **42.9** | **9** | **25.7** | **368** | **8.1** | **152** | **41.3** | **19** | **0.4** |
| Бүтэн жил | Төрөх тасаг | 7478 | 3531 | 47.2 | 2232 | 29.8 | 947 | 42.4 | 7635 | 7385 | 96.7 | 247 | 3.2 | 3 | 0.0 | 3582 | 46.9 | 173 | 2.3 | 64 | 37.0 | 347 | 237 | 68.3 | 110 | 31.7 | 17 | 0.2 | 13 | 76.5 | 10 | 58.8 | 7 | 41.2 | | | 147 | 2.0 | 79 | 53.7 | 26 | 0.3 |
| | Дутуу тээлт судлалын тасаг | 658 | 318 | 48.3 | 336 | 51.1 | 160 | 47.6 | 743 | 88 | 11.8 | 540 | 72.7 | 115 | 15.5 | 349 | 47.0 | 121 | 18.4 | 53 | 43.8 | 246 | 21 | 8.5 | 225 | 91.5 | 40 | 5.4 | 22 | 55.0 | 3 | 7.5 | 20 | 50.0 | 17 | 42.5 | 647 | 98.3 | 314 | 51.1 | 4 | 0.6 |
| | **2025 он** | **8136** | **3849** | **47.3** | **2568** | **31.6** | **1107** | **43.1** | **8378** | **7473** | **89.2** | **787** | **9.4** | **118** | **1.4** | **3931** | **46.9** | **294** | **3.6** | **117** | **39.8** | **593** | **258** | **43.5** | **335** | **56.5** | **57** | **0.7** | **35** | **61.4** | **13** | **22.8** | **27** | **47.4** | **17** | **29.8** | **794** | **9.8** | **393** | **51.6** | **30** | **0.4** |
| | **2024 он** | **8689** | **4299** | **49.5** | **2538** | **29.2** | **1088** | **42.9** | **8856** | **8021** | **90.6** | **729** | **8.2** | **106** | **1.2** | **4354** | **49.2** | **239** | **2.8** | **97** | **40.6** | **484** | **238** | **49.2** | **246** | **50.8** | **78** | **0.9** | **42** | **53.8** | **18** | **23.1** | **36** | **46.2** | **24** | **30.8** | **712** | **8.2** | **311** | **43.7** | **40** | **0.5** |

## 4.2. Эх барих эмэгтэйчүүдийн амбулаторийн тусламж үйлчилгээ

2025 онд Нөхөн үржихүйн зөвлөх поликлиник (НҮЗП)-ээр 88032 хүн үйлчлүүлсэн ба хөдөө орон нутгаас ирж үйлчлүүлсэн үйлчлүүлэгчийн эзлэх хувь 36.3 (n=31935) байна.




**Зураг 36. Амбулаториор үйлчлүүлэгсэд, ЭБЭЭ, ЭХЭМҮТ, 2021-2025 он**




**Зураг 37. Амбулаторийн үзлэгийн төрөл, ЭБЭЭ, ЭХЭМҮТ, 2025 он**

2025 онд НҮЗП-ийн үзлэгийн 54.7% (n=48168) өвчний учир амбулаторит, 0.2% (n=165) урьдчилан сэргийлэх үзлэг, 45.1% (n=39699) жирэмсний үзлэг эзэлж байна. 2025 оны байдлаар ЭБЭЭ-ийн НҮЗП-т нийт 3060 эхийг хянасан, жирэмсний хяналтад байсан эхийн 81.4% (n=2491) төрсөн байна. 2025 онд ЭБЭЭ-ийн Сэргээн засах эмчилгээний тасгаар 10988 хүн үйлчлүүлжээ. Сэргээн засах эмчилгээ хийлгэсэн хүмүүсийн 41.5% стационари, 58.5% амбулаториор үйлчлүүлэгсэд байжээ.




**Зураг 38. Сэргээн засах эмчилгээний тасгийн үзлэг, ЭБЭЭ, ЭХЭМҮТ, 2025 он**

**Хүснэгт 16. ЭХЭМҮТ, Нөхөн үржихүйн зөвлөх поликлиникийн тусламж үйлчилгээний үзүүлэлт, 2025 он**

| Д/Д | Кабинетууд | Бүх үзлэг | Үүнээс | | | | | | Орон нутгаас ирж үзүүлсэн | Амбулаторит шинжээр эмчилсэн хүний тоо | Жирэмсний хяналт | | | | | | | | Диспансерийн хяналт | | | | | | | Эмнэлэгт хэвтүүлсэн хүн | 13А маягтаар |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Жирэмсний үзлэг | Идэвхитэй хяналтын үзлэг | Урьдчилан сэргийлэх | Өвчний учир үзлэг | Үүнээс | | | | Тайлангийн эхэнд хяналтанд байсан | Шинээр хяналтанд авсан | Хяналтаас гарсан | Үүнээс | | | | Тайлангийн эцэст хяналтанд байгаа | Тайлангийн эхэнд хяналтанд байсан | Шинээр хяналтанд авсан | Хяналтаас гарсан | Үүнээс | | | Тайлангийн эцэст хяналтанд байгаа | | |
| | | | | | | | Анх | Давтан | | | | | | Төрсөн | Шилжсэн | Аборт/Зулбаа | Нас барсан | | | | | Эдгэрсэн | Шилжсэн | Нас барсан | | | |
| 1 | Жирэмсний кабинет-1 | 7341 | 7341 | | | | | | 2045 | 202 | 147 | 789 | 801 | 791 | 1 | 9 | | 135 | | | | | | | | 884 | 738 |
| 2 | Жирэмсний кабинет-2 | 7240 | 7240 | | | | | | 3012 | | 160 | 308 | 398 | 391 | 2 | 5 | | 70 | | | | | | | | 500 | 0 |
| 3 | Жирэмсний кабинет-3 | 5017 | 5017 | | | | | | 3248 | | 161 | 654 | 710 | 706 | 2 | 2 | | 105 | | | | | | | | 288 | 507 |
| 4 | Жирэмсний кабинет-4 | 6935 | 6935 | | | | | | 2590 | 105 | 146 | 628 | 610 | 551 | 17 | 42 | | 164 | | | | | | | | 823 | 65 |
| 5 | Эмэгтэйчүүдийн мэс заслын эмгэг | 9184 | | | 1 | 9183 | 3809 | 5374 | 3313 | | | | | | | | | | | | | | | | | | |
| 6 | Дотоод шүүрэл | 6700 | | | 35 | 6665 | 4254 | 2411 | 2424 | | | | | | | | | | | | | | | | | | 3 |
| 7 | Дотор | 7850 | 2484 | | | 5366 | 4797 | 569 | 2809 | | | | | | | | | | | | | | | | | | |
| 8 | Шүд | 1921 | | 16 | 92 | 1813 | 1239 | 574 | 787 | 174 | | | | | | | | | | | | | | | | | |
| 9 | Нүд | 525 | | | | 525 | 489 | 36 | 274 | | | | | | | | | | | | | | | | | | |
| 10 | Удам зүй | 1113 | 31 | 33 | 1 | 1048 | 981 | 67 | 409 | | | | | | | | | | | | | | | | | | |
| 11 | Хөх, умайн хүзүү судлал | 5809 | | | 12 | 5797 | 3111 | 2686 | 2452 | | | | | | | | | | | | | | | | | | |
| 12 | Урогинекологи | 3007 | | | 1 | 3006 | 1762 | 1244 | 1254 | | | | | | | | | | | | | | | | | | |
| 13 | Үргүйдэл, нөхөн үржихүйн төв | 8684 | 123 | | | 8561 | 2565 | 5996 | 2504 | | | | | | | | | | | | | | | | | | |
| 14 | Хяналтын үзлэг | 10213 | 9469 | | | 744 | 450 | 294 | 2554 | | | | | | | | | | | | | | | | | | |
| | ЭМДТ | 6493 | 855 | 155 | 23 | 5460 | 2907 | 2553 | 2260 | | 15 | 52 | 55 | 52 | 3 | | | 12 | | | | | | | | 51 | 16 |
| **2025 оны бүтэн жил** | | **88032** | **39495** | **204** | **165** | **48168** | **26364** | **21804** | **31935** | **481** | **629** | **2431** | **2574** | **2491** | **25** | **58** | | **486** | | | | | | | | **2546** | **1330** |
| **2024 оны бүтэн жил** | | **101102** | **43311** | **37** | **138** | **57616** | **30677** | **26939** | **32924** | **1089** | **487** | **2740** | **2598** | **2499** | **54** | **45** | | **629** | | | | | | | | **1755** | **3450** |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| **Үйл оношзүйн хэсэг-2025 он** | **20060** | 13235 | | 1387 | 5438 | 2292 | 3146 | 4084 |
| **Үйл оношзүйн хэсэг-2024 он** | **20619** | 13658 | | 1070 | 5891 | 2187 | 3704 | 3822 |

## ДҮГНЭЛТ

1. ЭХЭМҮТ-ийн ЭБЭЭ-т 2025 онд хэвтэн эмчлүүлэгчид 4.4 хувиар, орны эргэлт 2.6, дундаж ор хоног 0.3, орны фонд ашиглалт 26.7 пунктээр тус тус өссөн, орон нутгаас ирж үйлчлүүлэгсдийн эзлэх хувь өмнөх оноос 2.9 хувиар буурсан байна.
2. ЭХЭМҮТ-ийн ЭБЭЭ-ийн ор хоногийн төлөвлөгөөний биелэлт 2025 онд 93.9 хувьтай байна.
3. 2025 онд ЭХЭМҮТ-ийн Эх барих эмэгтэйчүүдийн эмнэлэгт 8136 эх амаржсан нь өнгөрсөн оноос 6.4%-иар буурсан, кесар хагалгаагаар төрсөн эхийн эзлэх хувь 31.6 байна.
4. 2025 онд дутуу төрөлтийн эзлэх хувь өнгөрсөн оны мөн үеэс 1.2 пунктээр өссөн.
5. 2025 онд ЭБЭЭ-ийн нас баралтын эзлэх хувь 0.9, задлан шинжилгээний хувь 65.1, оношийн тохироо 98.0% байна.
6. ЭХЭМҮТ-ийн эх барих эмэгтэйчүүдийн амбулаториор 2025 онд 88032 эх, эмэгтэйчүүд үйлчлүүлсэн ба тэдгээрийн 36.3% орон нутгаас ирж үйлчлүүлжээ.
7. ЭХЭМҮТ-д 2025 онд эхийн эндэгдлийн тохиолдол гараагүй.
8. 2025 онд ЭХЭМҮТ-д эхийн ноцтой хүндрэлийн харьцаа болон эхийн амь насанд заналхийлсэн хүндрэлийн харьцаа 6.3 байна.

# 5. ЭХЭМҮТ-ИЙН ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ

## 5.1. Хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээ

Хүүхдийн эмнэлэг 2025 онд 424 төсөвт ортой ажилласан бөгөөд энэ нь ЭХЭМҮТ-ийн нийт төсөвт орны 62.4%-ийг эзэлж байна.




**Зураг 39. ХЭ-ийн төсөвт ор, ЭХЭМҮТ, 2025 он**

2025 онд ЭХЭМҮТ-ийн ХЭ-т 18508 хүүхэд хэвтэн эмчлүүлсэн, нийт хэвтэн эмчлүүлэгчдийн 31.6% (n=5750) хөдөө орон нутгаас ирж үйлчлүүлжээ.




**Зураг 40. ХЭ-т хэвтэн эмчлүүлэгчид, ЭХЭМҮТ, 2021-2025 он**




**Зураг 41. ХЭ-ийн орны үзүүлэлтүүд, ЭХЭМҮТ, 2021-2025 он**

2025 онд Хүүхдийн эмнэлэгт нэг өвчтнийг эмнэлэгт хэвтүүлэн эмчилсэн **дундаж ор хоног** 7.9, нэг орыг ашигласан дундаж хоногийн тоо ба **орны фонд ашиглалт** 353, эмнэлгийн нэг оронд хэвтэн эмчлүүлсэн өвчтний дундаж тоо буюу **орны эргэлт** 44.5, ор хоногийн төлөвлөгөөний биелэлтийн хувь 106.8 байна.




**Зураг 42. ХЭ-ийн ор хоногийн төлөвлөгөөний биелэлтийн хувь, ЭХЭМҮТ, 2021-2025 он**




**Зураг 43. ХЭ-т Улаанбаатар хотоос хэвтэн эмчлүүлэгчид, ЭХЭМҮТ, 2025 он**

2025 онд Хүүхдийн эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчдийн 68.6% Улаанбаатар хот, 31.4% хөдөө орон нутгаас ирж үйлчлүүлжээ. ХЭ-т 2025 онд Улаанбаатар хотоос ирж хэвтэн, эдгэрч гарагсдын 24.4% БЗД, 22.1% СХД-ийн харьяат иргэд, орон нутгаас ирж хэвтэн, эдгэрч гарагсдын 9.6% Төв, 7.7% Хөвсгөл, 7.1% Сэлэнгэ аймгийн харьяат иргэд эзэлж байв. Хүүхдийн эмнэлэгт хэвтэн, эдгэрч гарагсдын өвчлөлийн бүтцийг насны бүлэг, хүйсээр авч үзэхэд 1-4 хүртэлх насны бүлэг 21.3%, 5-9 насны бүлгийн хүүхдүүд нийт өвчлөлийн 23.8%-ийг эзэлж байгаагаас үзэхэд дээрх насны хүүхдүүд бусад насны бүлгийнхнээс илүүтэйгээр өвчилдөг байна. 2025 онд ХЭ-т хэвтэн эдгэрч гарсан хүүхдийн 56.8% эрэгтэй, 43.2% эмэгтэй, эрэгтэй хүүхдийн эзлэх хувь эмэгтэй хүүхдийнхээс 13.7% илүү байна.




**Зураг 44. ХЭ-ийн өвчлөлийн бүтэц, насны бүлэг, хүйсээр, ЭХЭМҮТ, 2025 он**




**Зураг 45. ЭХЭМҮТ-ийн ХЭ-т хэвтэн эдгэрч гарагсад, аймгаар (бодит тоо, хувиар), 2025 он**

**Хүснэгт 17. Өвчлөлийн бүтэц, стационарт хэвтэн эмчлүүлэгчид, ХЭ, ЭХЭМҮТ, 2021-2025 он**

| Өвчний бүлэг ӨОУА - 10 | 2021<br>n (%) | 2022<br>n (%) | 2023<br>n (%) | 2024<br>n (%) | 2025<br>n (%) |
|---|---|---|---|---|---|
| I бүлэг. Халдварт ба шимэгчит зарим өвчин | 47<br>0.3 | 71<br>0.4 | 48<br>0.3 | 73<br>0.4 | 82<br>0.4 |
| II бүлэг. Хавдар | 866<br>5.8 | 1106<br>5.8 | 1384<br>7.5 | 1302<br>7.0 | 1394<br>7.6 |
| III бүлэг. Цус, цус төлжүүлэх эрхтний өвчин ба дархлааны механизм хамарсан зарим эмгэг | 370<br>2.5 | 455<br>2.4 | 494<br>2.7 | 495<br>2.7 | 476<br>2.6 |
| IV бүлэг. Дотоод шүүрэл, тэжээлийн ба бодисын солилцооны өвчнүүд | 152<br>1.0 | 259<br>1.4 | 218<br>1.2 | 183<br>1.0 | 215<br>1.2 |
| V бүлэг. Сэтгэцийн ба зан төрхийн эмгэг | 27<br>0.2 | 32<br>0.2 | 13<br>0.1 | 20<br>0.1 | 8<br>0.0 |
| VI бүлэг. Мэдрэлийн тогтолцооны өвчнүүд | 1094<br>7.3 | 1422<br>7.4 | 1399<br>7.6 | 1387<br>7.5 | 1362<br>7.4 |
| VII бүлэг. Нүд ба түүний дайврын өвчнүүд | 972<br>6.5 | 1250<br>6.5 | 1216<br>6.6 | 1207<br>6.5 | 1184<br>6.5 |
| VIII бүлэг. Чих ба хөхлөг сэртэнгийн өвчнүүд | 559<br>3.7 | 779<br>4.1 | 755<br>4.1 | 769<br>4.1 | 631<br>3.4 |
| IX бүлэг. Зүрх судасны тогтолцооны өвчин | 120<br>0.8 | 130<br>0.7 | 219<br>1.2 | 186<br>1.0 | 264<br>1.4 |
| X бүлэг. Амьсгалын тогтолцооны өвчин | 1404<br>9.4 | 2847<br>14.9 | 3131<br>17.0 | **3168**<br>**17.0** | 3513<br>19.2 |
| XI бүлэг. Хоол боловсруулах тогтолцооны өвчин | 3195<br>21.3 | 3319<br>17.3 | 3237<br>17.5 | **3319**<br>**17.8** | 3135<br>17.1 |
| XII бүлэг. Арьс ба арьсан доорх эслэгийн өвчин | 781<br>5.2 | 1730<br>9.0 | 960<br>5.2 | 874<br>4.7 | 778<br>4.3 |
| XIII бүлэг. Яс булчингийн тогтолцоо ба холбох эдийн өвчин | 463<br>3.1 | 585<br>3.1 | 609<br>3.3 | 573<br>3.1 | 427<br>2.3 |
| XIV бүлэг. Шээс бэлгийн тогтолцооны эмгэг | 723<br>4.8 | 1002<br>5.2 | 931<br>5.0 | 1171<br>6.3 | 1066<br>5.8 |
| XVI бүлэг. Перинаталь үед үүссэн зарим эмгэг | 1177<br>7.9 | 1521<br>7.9 | 1512<br>8.2 | **1379**<br>**7.4** | 1437<br>7.9 |
| XVII бүлэг. Төрөлх гажиг, гаж хөгжил ба хромосомын эмгэг | 1321<br>8.8 | 1591<br>8.3 | 1489<br>8.1 | **1558**<br>**8.4** | 1370<br>7.5 |
| XIX бүлэг. Гэмтэл, хордлого ба гадны шалтгаант бусад тодорхой эмгэг | 605<br>4.0 | 829<br>4.3 | 855<br>4.6 | 943<br>5.1 | 0.0 |
| XXI бүлэг.Эрүүл мэндийн байдал болон эрүүл мэндийн байгууллагад хандахад нөлөөлөх хүчин зүйлс | | | | 2<br>0.01 | 956<br>5.2 |
| XXII бүлэг. Шалтгаан нь тодорхойгүй шинэ өвчний урьдчилсан ангилал /U00-U49/ | 1113<br>7.4 | 233<br>1.2 | | | 4<br>0.0 |
| **Бүгд** | **14989**<br>**100.0** | **19161**<br>**100.0** | **18470**<br>**100.0** | **18609**<br>**100.0** | **18302**<br>**100.0** |

2025 онд ХЭ-т хэвтэн эмчлүүлэгчдийн өвчлөлд хоол боловсруулах тогтолцооны, амьсгалын тогтолцооны өвчин, төрөлх гажиг, гаж хөгжил ба хромосомын эмгэг, перинаталь үед үүссэн зарим эмгэг зонхилж байна. ЭХЭМҮТ-ийн ХЭ-ийн нас баралтын эзлэх хувь 2025 онд 1.2, хоног болоогүй нас баралтын эзлэх хувь 9.2, задлан шинжилгээний хувь 59.9, оношийн тохирооны хувь 93.8 байна.

**Хүснэгт 18. Нас баралтын үзүүлэлт, ХЭ, ЭХЭМҮТ, 2021-2025 он**

| Үзүүлэлт | 2021 | 2022 | 2023 | 2024 | 2025 |
|---|---|---|---|---|---|
| Хоног болоогүй нас баралтын эзлэх хувь | 12.0 | 7.4 | 7.5 | 4.8 | 9.2 |
| Нас баралтын эзлэх хувь | 1.2 | 1.2 | 1.3 | 1.2 | 1.2 |




**Зураг 46. Задлан шинжилгээний үзүүлэлт, ХЭ, ЭХЭМҮТ, 2021-2025 он**

**Хүснэгт 19. Нас баралтын зонхилох шалтгаан, ХЭ, ЭХЭМҮТ, 2021-2025 он**

| Өвчний бүлэг ӨОУА-10 | 2021 n (%) | 2022 n (%) | 2023 n (%) | 2024 n (%) | 2025 n (%) |
|---|---|---|---|---|---|
| I бүлэг. Халдварт ба шимэгчит зарим өвчин | 9<br>5.1 | 8<br>3.5 | 7<br>2.8 | 9<br>3.9 | 5<br>2.3 |
| II бүлэг. Хавдар | 28<br>16.0 | 25<br>10.8 | 31<br>12.3 | 39<br>17.1 | **38**<br>**17.5** |
| III бүлэг. Цус, цус төлжүүлэх эрхтний өвчин ба дархлааны механизм хамарсан зарим эмгэг | 3<br>1.7 | 4<br>1.7 | 1<br>0.4 | 2<br>0.9 | 4<br>1.8 |
| IV бүлэг. Дотоод шүүрэл, тэжээлийн ба бодисын солилцооны өвчнүүд | 3<br>1.7 | | 2<br>0.8 | 3<br>1.3 | 3<br>1.4 |
| VI бүлэг. Мэдрэлийн тогтолцооны өвчнүүд | 14<br>8.0 | 21<br>9.1 | 26<br>10.3 | 19<br>8.3 | 14<br>6.5 |
| IX бүлэг. Зүрх судасны тогтолцооны өвчин | 13<br>7.4 | 6<br>2.6 | 6<br>2.4 | 4<br>1.8 | 6<br>2.8 |
| X бүлэг. Амьсгалын тогтолцооны өвчин | 6<br>3.4 | 9<br>3.9 | 10<br>4.0 | 9<br>3.9 | 7<br>3.2 |
| XI бүлэг. Хоол боловсруулах тогтолцооны өвчин | 7<br>4.0 | 7<br>3.0 | 8<br>3.2 | 15<br>6.6 | 10<br>4.6 |
| XII бүлэг. Арьс ба арьсан доорх эслэгийн өвчин | | 1<br>0.4 | | | |
| XIII бүлэг. Яс булчингийн тогтолцоо ба холбох эдийн өвчин | | 6<br>2.6 | 2<br>0.8 | 1<br>0.4 | 4<br>1.8 |
| XIV бүлэг. Шээс бэлгийн тогтолцооны эмгэг | 2<br>1.1 | 8<br>3.5 | 3<br>1.2 | 3<br>1.3 | 1<br>0.5 |
| XVI бүлэг. Перинатал үед үүссэн зарим эмгэг | 21<br>12.0 | 49<br>21.2 | 77<br>30.6 | 53<br>23.2 | **54**<br>**24.9** |
| XVII бүлэг. Төрөлх гажиг, гаж хөгжил ба хромосомын эмгэг | 61<br>34.9 | 93<br>40.3 | 77<br>30.6 | 68<br>29.8 | **62**<br>**28.6** |
| XX бүлэг. Өвчлөл ба нас баралтын гадны шалтгаан | 2<br>1.1 | 1<br>0.4 | 2<br>0.8 | 3<br>1.3 | 9<br>4.1 |
| XXII бүлэг. Шалтгаан нь тодорхойгүй шинэ өвчний урьдчилсан ангилал /U00-U49/ | 6<br>3.4 | 1<br>0.4 | | | |
| **Бүгд** | **175**<br>**100.0** | **231**<br>**100.0** | **252**<br>**100.0** | **228**<br>**100.0** | **217**<br>**100.0** |

ЭХЭМҮТ-ийн Хүүхдийн эмнэлгийн 2025 оны нас баралтын бүтцийг ӨОУА-10-аар ангилахад төрөлх гажиг, гаж хөгжил ба хромосомын эмгэг, перинатал үед үүссэн зарим эмгэг, хавдар зонхилон тохиолджээ. 2025 онд хүүхдийн эмнэлгийн нас баралтыг насны бүлгээр авч үзэхэд нэг хүртэлх насны хүүхэд олонх 56.2%, хүйсийн бүтцээр авч үзэхэд эрэгтэй хүүхэд илүүтэйгээр (53.5%) энджээ.

## 5.2. Хүүхдийн дотрын төрөлжсөн мэргэжлийн тусламж үйлчилгээ

2025 онд Хүүхдийн эмнэлгийн дотрын тасгууд 273 төсөвт ортой ажилласан бөгөөд энэ нь ЭХЭМҮТ-ийн нийт төсөвт орны 64.4%-ийг эзэлж байна.




**Зураг 47. Төсөвт ор, ХЭ, дотрын тасгууд, ЭХЭМҮТ, 2025 он**

2025 онд ХЭ-ийн дотрын тасгуудад 9003 хүүхэд хэвтэн эмчлүүлсэн, нийт хэвтэн эмчлүүлэгчдийн 32.2% хөдөө орон нутгаас ирж үйлчлүүлсэн байна.




**Зураг 48. Хэвтэн эмчлүүлэгчид, ХЭ, дотрын тасгууд, ЭХЭМҮТ, 2021-2025 он**

2025 онд ХЭ-ийн дотрын тасгуудад хэвтэн эмчлүүлээд гарагсдын 68.0% (n= 5967) Улаанбаатар хот, 32.0% (n=2806) нь хөдөө орон нутгаас ирж үйлчлүүлжээ. Дотрын тасгуудад 2025 онд Улаанбаатар хотоос ирж хэвтэн, эдгэрч гарагсдын 24.7% (n=1474) БЗД, 21.9% (n=1304) СХД, 17.5% (n=1043) БГД-ээс ирж үйлчлүүлжээ.




**Зураг 49. Хэвтэн эмчлүүлэгчид, Улаанбаатар хот, ХЭ, дотрын тасгууд, ЭХЭМҮТ, 2025 он**

ЭХЭМҮТ-ийн ХЭ-ийн дотрын тасгуудад хөдөө орон нутгаас ирж хэвтэн, эдгэрч гарсан үйлчлүүлэгсдийн 9.8% (n=276) Төв, 8.0% (n=224) Хөвсгөл, 6.8% (n=192) Сэлэнгэ, 6.6% (n=184) Өвөрхангай, аймгаас ирж үйлчлүүлжээ.




**Зураг 50. Орны үзүүлэлт, ХЭ, дотрын тасгууд, ЭХЭМҮТ, 2021-2025 он**

2025 онд Хүүхдийн эмнэлгийн дотрын тасгуудын нэг өвчтнийг эмнэлэгт хэвтүүлэн эмчилсэн **дундаж ор хоног** 10.2, нэг орыг ашигласан дундаж хоногийн тоо ба **орны фонд ашиглалт** 335, эмнэлгийн нэг оронд хэвтэн эмчлүүлсэн өвчтний дундаж тоо буюу **орны эргэлт** 33.0 байна. 2025 онд Хүүхдийн эмнэлгийн дотрын тасгуудад хэвтэн эмчлүүлэгчдэд амьсгалын тогтолцооны өвчин, мэдрэлийн тогтолцооны өвчин, перинатал үед үүссэн зарим эмгэг зонхилон тохиолджээ. Эмчлэгдэж гарсан 0-1 хүртэлх насны хүүхэд 33.2%, 1-4 насны бүлгийн хүүхэд нийт өвчлөлийн 20.8%-ийг эзэлж байгаагаас харахад дээрх насны хүүхдүүд бусад насны бүлгийнхнээс илүүтэйгээр өвчилдөг байна. Түүнчлэн, 2025 онд Хүүхдийн эмнэлгийн дотрын тасгуудад хэвтэн эмчлэгдээд гарсан хүүхдийн 54.4% эрэгтэй, 45.6% эмэгтэй байсан ба эрэгтэй хүүхдийн эзлэх хувь эмэгтэй хүүхдийнхээс 9 пунктээр илүү байна. Хүүхдийн эмнэлгийн дотрын тасгуудын нас баралтын эзлэх хувь 2025 онд 2.2, хоног болоогүй нас баралт 9.5% байна.

**Хүснэгт 20. Өвчлөлийн бүтэц, стационарт хэвтэн эмчлүүлэгчид, ЭХЭМҮТ-ийн хүүхдийн дотрын төрөлжсөн мэргэжлийн тусламж үйлчилгээ, 2021-2025 он**

| Өвчний бүлэг ӨОУА-10 | 2021<br>n (%) | 2022<br>n (%) | 2023<br>n (%) | 2024<br>n (%) | 2025<br>n (%) |
|---|---|---|---|---|---|
| I бүлэг. Халдварт ба шимэгчит зарим өвчин | 17<br>0.2 | 26<br>0.3 | 10<br>0.1 | 24<br>0.3 | 42<br>0.5 |
| II бүлэг. Хавдар | 566<br>7.5 | 636<br>7.3 | 824<br>9.8 | 708<br>8.1 | 817<br>9.3 |
| III бүлэг. Цус, цус төлжүүлэх эрхтний өвчин ба дархлааны механизм хамарсан зарим эмгэг | 369<br>4.9 | 455<br>5.2 | 493<br>5.9 | 493<br>5.7 | 471<br>5.4 |
| IV бүлэг. Дотоод шүүрэл, тэжээлийн ба бодисын солилцооны өвчнүүд | 150<br>2.0 | 257<br>3.0 | 217<br>2.6 | 171<br>2.0 | 204<br>2.3 |
| V бүлэг. Сэтгэцийн ба зан төрхийн эмгэг | 27<br>0.4 | 32<br>0.4 | 13<br>0.2 | 20<br>0.2 | 8<br>0.1 |
| VI бүлэг. Мэдрэлийн тогтолцооны өвчнүүд | 1093<br>14.5 | 1421<br>16.4 | 1397<br>16.6 | 1387<br>15.9 | **1355**<br>**15.4** |
| VII бүлэг. Нүд ба түүний дайврын өвчнүүд | 16<br>0.2 | 14<br>0.2 | 17<br>0.2 | 12<br>0.1 | 8<br>0.1 |
| VIII бүлэг. Чих ба хөхлөг сэртэнгийн өвчнүүд | 2<br>0.03 | 1<br>0.0 | 3<br>0.0 | 3<br>0.0 | 1<br>0.01 |
| IX бүлэг. Зүрх судасны тогтолцооны өвчин | 117<br>1.6 | 106<br>1.2 | 169<br>2.0 | 157<br>1.8 | 199<br>2.3 |
| X бүлэг. Амьсгалын тогтолцооны өвчин | 740<br>9.8 | 1802<br>20.8 | 1686<br>20.0 | 1744<br>20.0 | **1795**<br>**20.5** |
| XI бүлэг. Хоол боловсруулах тогтолцооны өвчин | 1011<br>13.4 | 851<br>9.8 | 687<br>8.2 | 971<br>11.2 | 1007<br>11.5 |
| XII бүлэг. Арьс ба арьсан доорх эслэгийн өвчин | 101<br>1.3 | 54<br>0.6 | 46<br>0.5 | 22<br>0.3 | 30<br>0.3 |
| XIII бүлэг. Яс булчингийн тогтолцоо ба холбох эдийн өвчин | 241<br>3.2 | 346<br>4.0 | 330<br>3.9 | 369<br>4.2 | 275<br>3.1 |
| XIV бүлэг. Шээс бэлгийн тогтолцооны эмгэг | 267<br>3.5 | 415<br>4.8 | 406<br>4.8 | 606<br>7.0 | 526<br>6.0 |
| XVI бүлэг. Перинаталь үед үүссэн зарим эмгэг | 1177<br>15.6 | 1521<br>17.5 | 1511<br>18.0 | 1379<br>15.8 | **1437**<br>**16.4** |
| XVII бүлэг. Төрөлх гажиг, гаж хөгжил ба хромосомын эмгэг | 314<br>4.2 | 283<br>3.3 | 319<br>3.8 | 291<br>3.3 | 276<br>3.1 |
| XIX бүлэг. Гэмтэл, хордлого ба гадны шалтгаант бусад тодорхой эмгэг | 205<br>2.7 | 222<br>2.6 | 285<br>3.4 | 348<br>4.0 | 322<br>3.7 |
| XXII бүлэг. Шалтгаан нь тодорхойгүй шинэ өвчний урьдчилсан ангилал /U00-U49/ | 1110<br>14.8 | 233<br>2.7 | | | |
| **Бүгд** | **7523**<br>**100.0** | **8675**<br>**100.0** | **8413**<br>**100.0** | **8705**<br>**100.0** | **8773**<br>**100.0** |

**Хүснэгт 21. Нас баралт, хүүхдийн дотрын төрөлжсөн мэргэжлийн тусламж үйлчилгээ, ЭХЭМҮТ, 2021-2025 он**

| Үзүүлэлт | 2021 | 2022 | 2023 | 2024 | 2025 |
|---|---|---|---|---|---|
| Нас баралтын эзлэх хувь | 2.2 | 2.4 | 2.8 | 2.5 | 2.2 |
| Хоног болоогүй нас баралтын эзлэх хувь | 11.8 | 7.4 | 7.4 | 4.5 | 9.5 |




**Зураг 51. Задлан шинжилгээний үзүүлэлт, ХЭ, дотрын тасгууд, ЭХЭМҮТ, 2021-2025 он**

2025 онд ХЭ-ийн дотрын тасгуудын задлан шинжилгээнд хамрагдалт 58.7% байгаа нь өнгөрсөн оноос 13.8%-иар, оношийн тохироо 94.1% болж өнгөрсөн оноос 4.0%-иар буурсан байна. ХЭ-ийн дотрын тасгуудын 2025 оны нас баралтын бүтцийг ӨОУА-10-аар ангилахад дараах 3 бүлэг тэргүүлж байна.

1. Төрөлх гажиг, гаж хөгжил ба хромосомын эмгэг
2. Перинатал үед үүссэн зарим эмгэг
3. Хавдар орж байв.

**Хүснэгт 22. Нас баралт, хүүхдийн дотрын төрөлжсөн мэргэжлийн тусламж үйлчилгээ, ӨОУА-10, 2021-2025 он**

| Өвчний бүлэг ӨОУА-10 | 2021<br>n (%) | 2022<br>n (%) | 2023<br>n (%) | 2024<br>n (%) | 2025<br>n (%) |
|---|---|---|---|---|---|
| I бүлэг. Халдварт ба шимэгчит зарим өвчин | 7<br>4.1 | 7<br>3.3 | 7<br>2.9 | 8<br>3.6 | 5<br>2.5 |
| II бүлэг. Хавдар | 27<br>15.9 | 24<br>11.2 | 31<br>12.8 | 39<br>17.6 | **36**<br>**17.9** |
| III бүлэг. Цус, цус төлжүүлэх эрхтний өвчин ба дархлааны механизм хамарсан зарим эмгэг | 3<br>1.8 | 4<br>1.9 | 1<br>0.4 | 2<br>0.9 | 4<br>2.0 |
| IV бүлэг. Дотоод шүүрэл, тэжээлийн ба бодисын солилцооны өвчнүүд | 3<br>1.8 | | 2<br>0.8 | 3<br>1.4 | 3<br>1.5 |
| VI бүлэг. Мэдрэлийн тогтолцооны өвчнүүд | 14<br>8.2 | 20<br>9.3 | 25<br>10.3 | 19<br>8.6 | 14<br>7.0 |
| IX бүлэг. Зүрх судасны тогтолцооны өвчин | 13<br>7.6 | 6<br>2.8 | 6<br>2.5 | 4<br>1.8 | 6<br>3.0 |
| X бүлэг. Амьсгалын тогтолцооны өвчин | 6<br>3.5 | 9<br>4.2 | 10<br>4.1 | 8<br>3.6 | 7<br>3.5 |
| XI бүлэг. Хоол боловсруулах тогтолцооны өвчин | 6<br>3.5 | 3<br>1.4 | 4<br>1.7 | 12<br>5.4 | 7<br>3.5 |
| XII бүлэг. Арьс ба арьсан доорх эслэгийн өвчин | | | | | |
| XIII бүлэг. Яс булчингийн тогтолцоо ба холбох эдийн өвчин | | 5<br>2.3 | 1<br>0.4 | 1<br>0.5 | 1<br>0.5 |
| XIV бүлэг. Шээс бэлгийн тогтолцооны эмгэг | 2<br>1.2 | | 3<br>1.2 | 3<br>1.4 | 1<br>0.5 |
| XVI бүлэг. Перинаталь үед үүссэн зарим эмгэг | 21<br>12.4 | 49<br>22.8 | 76<br>31.4 | 53<br>23.9 | **54**<br>**26.9** |
| XVII бүлэг. Төрөлх гажиг, гаж хөгжил ба хромосомын эмгэг | 60<br>35.3 | 86<br>40.0 | 74<br>30.6 | 67<br>30.2 | **56**<br>**27.9** |
| XX бүлэг. Өвчлөл ба нас баралтын гадны шалтгаан | 2<br>1.2 | 1<br>0.5 | 2<br>0.8 | 3<br>1.4 | 7<br>3.5 |
| XXII бүлэг. Шалтгаан нь тодорхойгүй шинэ өвчний урьдчилсан ангилал /U00-U49/ | 6<br>3.5 | 1<br>0.5 | | | |
| **Бүгд** | **170**<br>**100.0** | **215**<br>**100.0** | **242**<br>**100.0** | **222**<br>**100.0** | **201**<br>**100.0** |

## Хүснэгт 23. Хүүхдийн дотрын төрөлжсөн мэргэжлийн тусламж үйлчилгээний үзүүлэлт, ЭХЭМҮТ, 2025 он

| | Тасгийн нэр | Төсөвт ор | Тайлангийн эхэнд байгаа өвчтөн | Тайлангийн хугацаанд: Шинээр нэмж хэвтсэн өвчтөн | Дотоод хөдөлгөөн: Өөр тасгаас ирсэн | Дотоод хөдөлгөөн: Өөр тасагт очсон | Гарсан, шилжсэн: Бүгд | Гарсан, шилжсэн: 0-15 насны | Гарсан, шилжсэн: Орон нутгийн | Нас барсан: Бүгд: Тоо | Нас барсан: Бүгд: Хувь | Үүнээс Хоног болоогүй: Тоо | Үүнээс Хоног болоогүй: Хувь | Перинатал эндэгдэл: Тоо | Перинатал эндэгдэл: Хувь | Үүнээс Хоног болоогүй: Тоо | Үүнээс Хоног болоогүй: Хувь | 0-1 насны: Тоо | 0-1 насны: Хувь | Орон нутгаас: Бүгд: Тоо | Орон нутгаас: Бүгд: Хувь | Орон нутгаас: 0-15 насны: Тоо | Орон нутгаас: 0-15 насны: Хувь | Орон нутгаас: Хоног болоогүй: Тоо | Орон нутгаас: Хоног болоогүй: Хувь | Эмгэг судлалын шинжилгээ хийсэн: Тоо | Эмгэг судлалын шинжилгээ хийсэн: Хувь | Онош тохирсон: Тоо | Онош тохирсон: Хувь | Тайлангийн эцэст байгаа өвчтөн | Хэвтэж эмчлүүлсэн хүний тоо | Чанар: Орны эргэлт | Чанар: Дундаж ор хоног | Чанар: Орны ээлхүүн | Чанар: Ор хоногийн төлөвлөгөө | Чанар: Ашигласан ор хоног | Чанар: Үүнээс хөдөөний | Чанар: Ор хоногийн төлөвлөгөөний биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Яаралтай тусламжийн тасаг | 3 | | 4 | | | 1 | 1 | | 3 | 75.0 | 3 | 100.0 | | | | | 1 | 33.3 | | | | | | | 2 | 66.7 | | | | 4 | 1.3 | 1.8 | 2.3 | 990 | 7 | | 0.7 |
| 2 | Амьсгалын эрхтний эмгэг судлалын тасаг | 40 | 70 | 2031 | 279 | 202 | 2123 | 2083 | 662 | 3 | 0.1 | | | | | | | 3 | 100.0 | 2 | 66.7 | 2 | 100.0 | | | 3 | 100.0 | 3 | 100.0 | 52 | 2079 | 52.0 | 7.3 | 378 | 13200 | 15121 | 4890 | 114.6 |
| 3 | Хоол боловсруулах эрхтний эмгэг судлалын тасаг | 23 | 11 | 1013 | 82 | 82 | 1009 | 885 | 225 | 3 | 0.3 | | | | | | | 3 | 100 | 1 | 33.3 | 1 | 100.0 | | | 1 | 33.3 | 1 | 100.0 | 12 | 1013 | 44.0 | 6.2 | 275 | 7590 | 6320 | 1740 | 83.3 |
| 4 | Зүрх судас, холбогч эдийн эмгэг судлалын | 23 | 13 | 791 | 60 | 34 | 816 | 697 | 287 | 4 | 0.5 | 1 | 25.0 | | | | | 1 | 25.0 | | | | | | | 1 | 25.0 | 1 | 100.0 | 10 | 806 | 35.0 | 8.6 | 301 | 7590 | 6934 | 2595 | 91.4 |
| 5 | Цусны эмгэг, хавдар судлалын тасаг | 30 | 8 | 1027 | 52 | 26 | 1024 | 951 | 403 | 18 | 1.7 | | | | | | | | | 6 | 33.3 | 4 | 66.7 | | | 2 | 11.1 | 2 | 100.0 | 19 | 1035 | 34.5 | 8.0 | 274 | 9900 | 8231 | 3298 | 83.1 |
| | Хөнгөвчлөх хэсэг | 5 | 1 | 37 | 0 | 0 | 25 | 21 | 10 | 12 | 32.4 | 1 | 8.3 | | | | | | | 3 | 25.0 | 3 | 100.0 | | | | | | | 1 | 37 | 7.4 | 10.4 | 77 | 1650 | 385 | 133 | 23.3 |
| 6 | Бөөр, дотоод шүүрлийн эмгэг судлалын тасаг | 40 | 19 | 689 | 48 | 19 | 723 | 603 | 212 | | | | | | | | | | | | | | | | | | | | | 14 | 706 | 17.7 | 12.0 | 212 | 13200 | 8486 | 2611 | 64.3 |
| 7 | Мэдрэлийн эмгэг судлалын тасаг | 40 | 28 | 1527 | 133 | 83 | 1568 | 1422 | 383 | 6 | 0.4 | | | | | | | 2 | 33.3 | 2 | 33.3 | 2 | 100.0 | | | | | | | 31 | 1551 | 38.8 | 8.7 | 337 | 13200 | 13464 | 4295 | 102.0 |
| 8 | Хүүхдийн эрчимт эмчилгээний тасаг | 12 | 14 | 386 | 137 | 448 | 10 | 9 | 4 | 74 | 14.0 | 14 | 18.9 | | | | | 29 | 39.2 | 38 | 51.4 | 36 | 94.7 | 2 | 5.3 | 46 | 62.2 | 42 | 91.3 | 5 | 528 | 44.0 | 6.2 | 271 | 3960 | 3251 | 1451 | 82.1 |
| 9 | Нярайн эрчимт эмчилгээний тасаг | 12 | 16 | 190 | 273 | 393 | | | | 68 | 14.7 | | | 1 | 1.5 | | | 68 | 100.0 | 32 | 47.1 | 32 | 100.0 | | | 54 | 79.4 | 54 | 100.0 | 18 | 462 | 38.5 | 13.0 | 500 | 3960 | 6002 | 3707 | 151.6 |
| 10 | Нярайн эмгэг судлалын тасаг | 45 | 74 | 1337 | 271 | 128 | 1474 | 1474 | 619 | 10 | 0.7 | | | | | | | 10 | 100.0 | 9 | 90.0 | 9 | 100.0 | | | 9 | 90.0 | 8 | 88.9 | 70 | 1411 | 31.3 | 16.5 | 516 | 14850 | 23235 | 15058 | 156.5 |
| | **2025 оны бүтэн жил** | **273** | **254** | **9032** | **1335** | **1415** | **8773** | **8146** | **2805** | **201** | **2.2** | **19** | **9.5** | **1** | **0.5** | | | **117** | **58.2** | **93** | **46.3** | **89** | **95.7** | **2** | **2.2** | **118** | **58.7** | **111** | **94.1** | **232** | **9003** | **33.0** | **10.2** | **335** | **90090** | **91436** | **39778** | **101.5** |
| | **2024 оны бүтэн жил** | **273** | **245** | **8972** | **1341** | **1377** | **8705** | **8134** | **2785** | **222** | **2.5** | **10** | **4.5** | **2** | **0.9** | | | **134** | **60.4** | **103** | **46.4** | **99** | **96.1** | **2** | **1.9** | **161** | **72.5** | **158** | **98.1** | **254** | **8950** | **32.8** | **10.7** | **351** | **90090** | **95842** | **35997** | **106.4** |

## 5.3. Хүүхдийн төрөлжсөн мэс заслын тусламж үйлчилгээ

Хүүхдийн эмнэлгийн мэс заслын тасгууд 2025 онд 151 төсөвт ортой ажилласан бөгөөд энэ нь Хүүхдийн эмнэлгийн нийт төсөвт орны 35.6%-ийг эзэлдэг.




Зураг 52. Төсөвт ор, ХЭ, мэс заслын тасгууд, ЭХЭМҮТ, 2025 он




Зураг 53. Хэвтэн эмчлүүлэгчид, ХЭ, мэс заслын тасгууд, ЭХЭМҮТ, 2021-2025 он

ХЭ-ийн мэс заслын тасгуудад 2025 онд 9505 хүүхэд хэвтэн эмчлүүлсэн нь 2024 оноос 4.0% (n=394)-иар буурсан. ХЭ-ийн мэс заслын тасгуудын нэг өвчтөнг эмнэлэгт хэвтүүлэн эмчилсэн дундаж ор хоног 2025 онд 5.3, нэг орыг ашигласан дундаж хоногийн тоо ба орны фонд ашиглалт 336, эмнэлгийн нэг оронд хэвтэн эмчлүүлсэн өвчтний дундаж тоо буюу орны эргэлт 62.9 байв. ХЭ-ийн мэс заслын тасгуудад хэвтэн эмчлүүлэгчдийн 69.1% (n=6582) Улаанбаатар хот, 30.9% (n=2947) хөдөө, орон нутгаас ирж үйлчлүүлжээ.




**Зураг 54. Орны үзүүлэлт, ХЭ, мэс заслын тасгууд, ЭХЭМҮТ, 2021-2025 он**

Мэс заслын тасгуудад 2025 онд Улаанбаатар хотоос хэвтэн, эдгэрч гарагсдын 24.1% (n=1588) БЗД, 22.3% (n=1467) СХД, 17.6% (n=1157) БГД-ээс ирж үйлчлүүлсэн байна.




**Зураг 55. Улаанбаатар хотын хэвтэн эмчлүүлэгчид, ХЭ, мэс заслын тасгууд, ЭХЭМҮТ, 2025 он**

2025 онд ЭХЭМҮТ-ийн Хүүхдийн эмнэлгийн мэс заслын тасгуудад хөдөө орон нутгаас ирж хэвтэн эмчлүүлээд гарсан үйлчлүүлэгсдийг харьяаллаар авч үзэхэд 9.4% (n=276) Төв, 7.9% (n=234) Дархан-Уул, 7.5% (n=221) Хөвсгөл, 7.3% (n=216) Сэлэнгэ, 6.0% (n=176) Архангай аймгаас ирж үйлчлүүлсэн байлаа.

2025 онд ХЭ-ийн мэс заслын тасгуудад хэвтэн эмчлүүлэгчдийн өвчлөлд хоол боловсруулах тогтолцоо, амьсгалын тогтолцооны өвчин, нүд ба түүний дайврын өвчнүүд, төрөлх гажиг, гаж хөгжил ба хромосомын эмгэг зонхилон тохиолджээ. Өвчлөлийн бүтцийг эмчлэгдэж гарсан хүүхдийн насны ангилал, хүйсээр авч үзэхэд 1-4 насны бүлгийн хүүхэд нийт өвчлөлийн 21.8%, 5-9 хүртэлх насныхан 30.5%-ийг эзэлж байгаагаас харахад дээрх насны бүлгийн хүүхдүүд бусад насны бүлгийнхээс илүүтэйгээр өвчилдөг болох нь харагдлаа. 2025 онд ХЭ-ийн мэс заслын тасгуудад хэвтэн, эмчлэгдээд гарсан хүүхдийн 59.0% эрэгтэй, 41.0% эмэгтэй хүүхэд байсан ба эрэгтэй хүүхдийн эзлэх хувь эмэгтэй хүүхдийнхээс 18.0 пунктээр илүү байна. 2025 онд ЭХЭМҮТ-д 11816 хагалгаа хийгдсэн.

ЭХЭМҮТ-д хийгдсэн хагалгааны 8089 буюу 68.5% Хүүхдийн эмнэлгийн мэс заслын тасгуудад хийгджээ. 2025 онд Хүүхдийн эмнэлгийн мэс заслын тасгуудад хийгдсэн хагалгааны 34.7%-ийг (n=2808) яаралтай хагалгаа эзэлж байна.

**Хүснэгт 24. Өвчлөлийн бүтэц, хэвтэн эмчлүүлэгчид, хүүхдийн мэс заслын тусламж үйлчилгээ, ЭХЭМҮТ, 2021-2025 он**

| Өвчний бүлэг ӨОУА-10 | 2021<br>n (%) | 2022<br>n (%) | 2023<br>n (%) | 2024<br>n (%) | 2025<br>n (%) |
|---|---|---|---|---|---|
| Халдварт ба шимэгчит зарим өвчин | 22<br>0.3 | 45<br>0.4 | 38<br>0.4 | 49<br>0.5 | 40<br>0.4 |
| Хавдар | 301<br>4.0 | 470<br>4.5 | 561<br>5.6 | 596<br>6.0 | 582<br>6.1 |
| Цус, цус төлжүүлэх эрхтний өвчин ба дархлааны механизм хамарсан зарим эмгэг | 2<br>0.03 | | | | |
| Дотоод шүүрэл, тэжээлийн ба бодисын солилцооны өвчнүүд | 2<br>0.03 | 2<br>0.02 | 1<br>0.01 | 12<br>0.1 | 11<br>0.1 |
| Мэдрэлийн тогтолцооны өвчнүүд | 1<br>0.01 | 1<br>0.01 | 2<br>0.02 | | 7<br>0.1 |
| Нүд ба түүний дайврын өвчнүүд | 955<br>12.8 | 1236<br>11.8 | 1199<br>11.9 | 1195<br>12.1 | **1176**<br>**12.3** |
| Чих ба хөхлөг сэртэнгийн өвчнүүд | 558<br>7.5 | 778<br>7.4 | 752<br>7.5 | 766<br>7.7 | 630<br>6.6 |
| Зүрх судасны тогтолцооны өвчин | 3<br>0.04 | 24<br>0.2 | 50<br>0.5 | 29<br>0.3 | 65<br>0.7 |
| Амьсгалын тогтолцооны өвчин | 668<br>8.9 | 1045<br>10.0 | 1445<br>14.4 | 1424<br>14.4 | **1718**<br>**18.0** |
| Хоол боловсруулах тогтолцооны өвчин | 2185<br>29.3 | 2468<br>23.5 | 2550<br>25.4 | 2348<br>23.7 | **2128**<br>**22.3** |
| Арьс ба арьсан доорх эслэгийн өвчин | 680<br>9.1 | 1676<br>16.0 | 914<br>9.1 | 852<br>8.6 | 748<br>7.8 |
| Яс булчингийн тогтолцоо ба холбох эдийн өвчин | 222<br>3.0 | 239<br>2.3 | 279<br>2.8 | 204<br>2.1 | 152<br>1.6 |
| Шээс бэлгийн тогтолцооны эмгэг | 456<br>6.1 | 587<br>5.6 | 525<br>5.2 | 565<br>5.7 | 540<br>5.7 |
| Перинаталь үед үүссэн зарим эмгэг | 1<br>0.01 | | 1<br>0.01 | | |
| Төрөлх гажиг, гаж хөгжил ба хромосомын эмгэг | 1007<br>13.5 | 1308<br>12.5 | 1170<br>11.6 | 1267<br>12.8 | **1094**<br>**11.5** |
| Гэмтэл, хордлого ба гадны шалтгаант бусад тодорхой эмгэг | 400<br>5.4 | 607<br>5.8 | 570<br>5.7 | 595<br>6.0 | 634<br>6.7 |
| Эрүүл мэндийн байдал болон эрүүл мэндийн байгууллагад хандахад нөлөөлөх хүчин зүйл | | | | 2<br>0.02 | 4<br>0.04 |
| Шалтгаан нь тодорхойгүй шинэ өвчний урьдчилсан ангилал /U00-U49/ | 3<br>0.04 | | | | |
| **Бүгд** | **7466**<br>**100.0** | **10486**<br>**100.0** | **10057**<br>**100.0** | **9904**<br>**100.0** | **9529**<br>**100.0** |




**Зураг 56. Мэс засал, ХЭ, мэс заслын тасгууд, ЭХЭМҮТ, 2025 он**




**Зураг 57. Хагалгааны бүтэц, ХЭ, мэс заслын тасгууд, ЭХЭМҮТ, 2025 он**

ХЭ-ийн **Ерөнхий мэс заслын тасагт** 2025 онд 2358 хүүхэд эмчлэгдэж гарсан, эдгээрийн 85.7% (n=2021) мэс заслын эмчилгээ хийлгэжээ. ЕМЗТ-ийн хагалгааны 65.0% (n=1314) яаралтай, 35.0% (n=707) төлөвлөгөөт хагалгаа эзэлж байв.

**Цээжний мэс заслын тасагт** 2025 онд 399 хүн хэвтэн эмчлэгдэн гарсан, эдгээрийн 56.6% (n=226) мэс засал хийлгэсэн. ЦМЗТ-ийн хагалгааны 25.2% (n=57) яаралтай, 74.8% (n=169) төлөвлөгөөт хагалгаа байлаа.

**Бөөрний мэс заслын тасагт** 2025 онд 1220 хүн хэвтэн эмчлэгдэн гарсан, эдгээрийн 87.2% (n=1064) мэс засал хийлгэсэн. БМЗТ-ийн хагалгааны 10.2% (n=108) яаралтай, 89.8% (n=956) төлөвлөгөөт хагалгаа байлаа.

**Чих хамар хоолойн мэс заслын тасагт** 2025 онд нийт 2575 хүн хэвтэн эмчлэгдэж гарсан, эдгээрийн 78.6% (n=2025) мэс засал хийлгэсэн. ЧХХМЗТ-ийн хагалгааны 9.5% (n=192) яаралтай, 90.5% (n=1833) төлөвлөгөөт хагалгаа байв.

**Нүдний мэс заслын тасагт** 2025 онд нийт 1294 хүн хэвтэн эмчлэгдэж гарсан, эдгээрийн 81.3% (n=1052) мэс засал эмчилгээ хийлгэжээ. НМЗТ-ийн хагалгааны 17.7% (n=186) яаралтай, 82.3% (n=866) төлөвлөгөөт хагалгаа байв.

**Эрүү нүүрний мэс заслын тасагт** 2025 онд нийт 1683 хүн хэвтэн эмчлэгдсэн, эдгээрийн 91.8% (n=1545) мэс засал хийлгэсэн. ЭНМЗТ-ийн хагалгааны 56.4% (n=872) яаралтай, 43.6% (n=673) төлөвлөгөөт хагалгаа эзэлж байна.

ХЭ-ийн мэс заслын тасгуудын нас баралтын эзлэх хувь 2024 онд 0.2, задлан шинжилгээний хувь 75.0, оношийн тохирооны хувь 100.0 байна.




**Зураг 58. Задлан шинжилгээний үзүүлэлт, ХЭ, мэс заслын тасгууд, ЭХЭМҮТ, 2021-2025 он**

**Хүснэгт 25. Нас баралт, хүүхдийн мэс заслын тасгууд, ЭХЭМҮТ, 2021-2025 он**

| Өвчний бүлэг ӨОУА-10 | 2021 n (%) | 2022 n (%) | 2023 n (%) | 2024 n (%) | 2025 n (%) |
|---|---|---|---|---|---|
| Халдварт ба шимэгчит зарим өвчин | 2<br>40.0 | 1<br>6.3 | | 1<br>16.7 | |
| Хавдар | 1<br>20.0 | 1<br>6.3 | | | 2<br>12.5 |
| Мэдрэлийн тогтолцооны өвчнүүд | | 1<br>6.3 | 1<br>10.0 | | |
| Амьсгалын тогтолцооны өвчин | | | | 1<br>16.7 | |
| Хоол боловсруулах тогтолцооны өвчин | 1<br>20.0 | 4<br>25.0 | 4<br>40.0 | 3<br>50.0 | 3<br>18.8 |
| Арьс ба арьсан доорх эслэгийн өвчин | | 1<br>6.3 | | | |
| Яс булчингийн тогтолцоо ба холбох эдийн өвчин | | 1<br>6.3 | 1<br>10.0 | | 3<br>18.8 |
| Перинатал үед үүссэн зарим эмгэг | | | 1<br>10.0 | | |
| Төрөлх гажиг, гаж хөгжил ба хромосомын эмгэг | 1<br>20.0 | 7<br>43.8 | 3<br>30.0 | 1<br>16.7 | 6<br>37.5 |
| Өвчлөл ба нас баралтын гадны шалтгаан | | | | | 2<br>12.5 |
| **Бүгд** | **5<br>100.0** | **16<br>100.0** | **10<br>100.0** | **6<br>100.0** | **16<br>100.0** |

**Хүснэгт 26. Хүүхдийн төрөлжсөн мэс заслын тусламж үйлчилгээний үзүүлэлт, ЭХЭМҮТ, 2025 он**

| № | Тасгийн нэр | Төсөвт ор | Тайлангийн эхэнд байгаа өвчтөн | Тайлангийн хугацаанд: Шинээр нэмж хэвтсэн өвчтөн | Дотоод хөдөлгөөн: Өөр тасгаас ирсэн | Дотоод хөдөлгөөн: Өөр тасагт очсон | Гарсан, шилжсэн: Бүгд | Гарсан, шилжсэн: 0-15 насны | Гарсан, шилжсэн: Орон нутгийн | Нас барсан: Бүгд: тоо | Нас барсан: Бүгд: % | Үүнээс: Хоног болоогүй: тоо | Үүнээс: Хоног болоогүй: % | Перинатал эндэгдэл: тоо | Перинатал эндэгдэл: % | 0-1 насны: тоо | 0-1 насны: % | Орон нутгийн: Бүгд: тоо | Орон нутгийн: Бүгд: % | Орон нутгийн: 0-15 насны: тоо | Орон нутгийн: 0-15 насны: % | Орон нутгийн: Хоног болоогүй: тоо | Орон нутгийн: Хоног болоогүй: % | Эмгэг судлалын шинжилгээ хийсэн: тоо | Эмгэг судлалын шинжилгээ хийсэн: % | Онош тохирсон: тоо | Онош тохирсон: % | Тайлангийн эцэст байгаа өвчтөн | Хэвтэж эмчлүүлсэн хүний тоо | Чанар: Орны эргэлт | Чанар: Дундаж ор хоног | Чанар: Орны ээлхүүн | Чанар: Ор хоногийн төлөвлөгөө | Чанар: Ашигласан ор хоног | Чанар: Үүнээс орон нутгийн | Чанар: Ор хоногийн төлөвлөгөөний биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | A | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 | 13 | 14 | 15 | 16 | 17 | 18 | 19 | 20 | 21 | 22 | 23 | 24 | 25 | 26 | 27 | 28 | 29 | 30 | 31 | 32 | 33 | 34 | 35 |
| 1 | Ерөнхий мэс заслын тасаг | 41 | 19 | 2293 | 300 | 220 | 2358 | 2095 | 651 | 4 | 0.2 | 1 | 25.0 | | | | | 2 | 50.0 | 1 | 50.0 | | | 3 | 75.0 | 3 | 100.0 | 30 | 2328 | 56.8 | 5.9 | 333 | 13530 | 13634 | 4096 | 100.8 |
| 2 | Цээжний мэс заслын тасаг | 12 | 8 | 370 | 114 | 86 | 399 | 333 | 157 | 1 | 0.26 | | | | | | | 1 | 100.0 | 1 | 100.0 | | | 1 | 100.0 | 1 | 100.0 | 6 | 385 | 32.1 | 8.4 | 271 | 3960 | 3250 | 1229 | 82.1 |
| 3 | Бөөрний мэс заслын тасаг | 20 | 9 | 1227 | 15 | 16 | 1220 | 1149 | 423 | | | | | | | | | | | | | | | | | | | 15 | 1224 | 61.2 | 5.2 | 320 | 6600 | 6394 | 2394 | 96.9 |
| 4 | Чих хамар хоолойн мэс заслын тасаг | 32 | 25 | 2563 | 11 | 8 | 2575 | 2299 | 710 | | | | | | | | | | | | | | | | | | | 16 | 2569 | 80.3 | 4.5 | 361 | 10560 | 11567 | 3046 | 109.5 |
| 5 | Нүдний мэс заслын тасаг | 20 | 6 | 1295 | 0 | 3 | 1294 | 1228 | 463 | | | | | | | | | | | | | | | | | | | 4 | 1295 | 64.7 | 4.9 | 320 | 6600 | 6391 | 2450 | 96.8 |
| 6 | Эрүү нүүрний мэс заслын тасаг | 20 | 15 | 1682 | 11 | 13 | 1683 | 1565 | 541 | | | | | | | | | | | | | | | | | | | 12 | 1683 | 84.1 | 4.7 | 392 | 6600 | 7839 | 2376 | 118.8 |
| 7 | Мэс заслын эрчимт эмчилгээний тасаг | 6 | 4 | 35 | 386 | 411 | | | | 10 | 2.4 | | | | | 4 | 40.0 | 6 | 60.0 | 6 | 100.0 | | | 7 | 70.0 | 7 | 100.0 | 4 | 421 | 70.2 | 3.9 | 272 | 1980 | 1634 | 741 | 82.5 |
| 8 | Мэдээгүйжүүлэг хагалгааны нэгдсэн тасаг | | | | | | | | | 1 | | | | | | 1 | 100.0 | | | | | | | 1 | 100.0 | 1 | 100.0 | | | | | | | | | |
| | **2025 оны бүтэн жил** | **151** | **86** | **9465** | **837** | **757** | **9529** | **8669** | **2945** | **16** | **0.2** | **1** | **6.3** | | | **5** | **31.3** | **9** | **56.3** | **8** | **88.9** | | | **12** | **75.0** | **12** | **100.0** | **86** | **9505** | **62.9** | **5.3** | **336** | **49830** | **50709** | **16332** | **101.8** |
| | **2024 оны бүтэн жил** | **151** | **73** | **9887** | **720** | **684** | **9904** | **9148** | **3111** | **6** | **0.1** | **1** | **16.7** | | | **4** | **66.7** | **4** | **66.7** | **4** | **100.0** | | | **6** | **100.0** | **3** | **50.0** | **86** | **9899** | **65.6** | **5.4** | **355** | **49830** | **53634** | **17446** | **107.6** |

## 5.4. Хүүхдийн амбулаторийн тусламж үйлчилгээ

Хүүхдийн зөвлөх поликлиник (ХЗП)-ээр 2025 онд 222432 хүн үйлчлүүлсэн, нийт үйлчлүүлэгсдийн 26.9% (n=59795) хөдөө орон нутгаас ирж үйлчлүүлсэн байна.




Зураг 59. Хүүхдийн амбулаториор үйлчлүүлэгсэд, ЭХЭМҮТ, 2021-2025 он




Зураг 60. Хүүхдийн амбулаторийн үзлэгийн төрөл, ЭХЭМҮТ, 2025 он




Зураг 61. Хүүхдийн сэргээн засах эмчилгээний тасгийн үйлчилгээ, ЭХЭМҮТ, 2025 он

2025 онд ХЗП-ийн үзлэгийн 97.4% (n=216555) өвчний учир, 0.6% (n=1419) урьдчилан сэргийлэх үзлэг, 2.0%-ийг (n=4458) идэвхтэй диспансерийн хяналт эзэлж байна.

Сэргээн засах эмчилгээний тасаг нь 2025 онд 12209 хүнд үйлчилсэн, нийт эмчилгээ хийлгэсэн хүмүүсийн 70.5% (n=8606) хэвтэн эмчлүүлэгчид байжээ.




**Зураг 62. Хүүхдийн амбулаторийн кабинетуудын ачаалал, ЭХЭМҮТ, 2025 он**

ХЗП-ийн оношилгооны хэсгээр 2025 онд 122596 хүн үйлчлүүлсэн бөгөөд 31.9% (n=39049) хөдөө орон нутгаас ирж үйлчлүүлжээ. Нийт үйлчлүүлэгсдийн 28.4% (n=34762) рентген шинжилгээ, 12.7% (n=15546) ЭХО-1, 11.7% (n=14299) ЭХО-2 кабинетаар үйлчлүүлсэн. Оношилгооны хэсгийн рентген шинжилгээний кабинетаар үйлчлүүлсэн хүмүүсийн 60.4% (n=20984) амьсгалын эрхтний рентген шинжилгээ, 20.0% (n=6943)-д яс, үе мөчний рентген тойм шинжилгээ, 12.5% (4343) хэвлийн рентген шинжилгээ хийжээ.




**Зураг 63. Хүүхдийн оношилгооны кабинетуудын үзлэг, ЭХЭМҮТ, 2025 он**

2025 онд дурангийн оношилгооны кабинет 1899 хүнд дурангийн шинжилгээ хийж үйлчилсэн ба дийлэнх 91.4%-д (n=1735) ходоод, 12 хуруу гэдэс дурандах шинжилгээ хийжээ. ХЗП-ийн оношилгооны хэсгийн эхокардиографийн кабинетаар 6724 хүн үйлчлүүлж, 5338 хүнд зүрхний цахилгаан бичлэг хийжээ. 2025 оны байдлаар сонсгол судлалын кабинет 7367 хүнд үйлчилсэн байна.

Хүүхдийн чанд авиан оношилгооны ЭХО-1, ЭХО-2 кабинет нь амбулаториор үйлчлүүлэгсдэд, ЭХО-3 кабинет нь ХЭ-ийн тасгуудад хэвтэн эмчлүүлэгсдэд үйлчилгээ үзүүлдэг байна.




**Зураг 64. Хүүхдийн чанд авиан оношилгооны кабинетын үйлчилгээ, ЭХЭМҮТ, 2025 он**

ЭХЭМҮТ-ийн Нэгдсэн лабораторийн тасаг 2025 онд нийт 860276 шинжилгээ хийжээ. Нэгдсэн лабораторийн тасагт хийгдсэн шинжилгээний 67.8%-ийг (n=583637) стационарт хэвтэн эмчлүүлэгчид, 32.2%-ийг (n=276639) амбулаториор үйлчлүүлэгсэд эзэлж байна. Хийгдсэн шинжилгээг төрлөөр нь авч үзэхэд:

1. Биохими иммунологийн шинжилгээ 579777 буюу 67.4%
2. Гемотологи, клиник-химийн шинжилгээ 213412 буюу 24.8%
3. Микробиологийн шинжилгээ 33559 буюу 3.9%
4. Серологийн шинжилгээ 33082 буюу 3.8%
5. Иммуногистохими 446 буюу 0.1%-ийг

эзэлж байна.




**Зураг 65. Лабораторийн шинжилгээний төрөл, хувиар, ЭХЭМҮТ, 2025 он**

**Хүснэгт 27. Хүүхдийн зөвлөх поликлиникийн тусламж үйлчилгээний үзүүлэлт, ЭХЭМҮТ, 2025 он**

| д/д | Кабинет | | Бүх үзлэг | | Үүнээс эмэгтэй | Үүнээс | | | | | Хэвтэж эмчлүүлсэн | 13а маягтаар үзүүлсэн | Орон нутгаас ирж үзүүлсэн | Диспансерийн хяналт | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | Үүнээс | | | | | | | | Үүнээс | | | |
| | | | тоо | хувь | | Идэвхтэй хяналт | Урьдчилан сэргийлэх үзлэг | Өвчний учир амбулаторит | Анх үзлэг | Давтан | | | | Тайлангийн эхэнд хяналтанд байсан | Шинээр хяналтанд авсан | Хяналтаас гарсан | Эдгэрсэн | Шилжсэн | Нас барсан | Тайлангийн эцэст хяналтанд байгаа |
| 1 | Дотрын эмгэг судлал №1 | | 9941 | 4.5 | 4441 | | 45 | 9896 | 7594 | 2302 | 316 | | 3161 | 82 | 8 | 6 | 6 | | | 84 |
| 2 | Дотрын эмгэг судлал №2 | | | | | | | | | | | | | | | | | | | |
| 3 | Нярайн эмгэг судлалын кабинет | | 6404 | 2.9 | 2909 | 1 | 260 | 6143 | 4514 | 1629 | 208 | | 1769 | 11 | 11 | 16 | 16 | | | 6 |
| 4 | Зүрх судас, үе мөч, холбогч эдийн эмгэг судлалын кабинет | | 18951 | 8.5 | 10178 | 28 | 4 | 18919 | 10376 | 8543 | 194 | 2 | 6065 | 3225 | 242 | 150 | 79 | 66 | 5 | 3317 |
| 5 | Дотоод шүүрлийн булчирхайн эмгэг судлалын кабинет | | 8895 | 4.0 | 4883 | 1073 | 9 | 7813 | 4086 | 3727 | 156 | 104 | 2469 | 607 | 18 | 11 | 9 | 2 | | 614 |
| 6 | Мэс заслын эмгэг судлалын кабинет | | 7343 | 3.3 | 3341 | 11 | 42 | 7290 | 6104 | 1186 | 1150 | | 2231 | 23 | | | | | | 23 |
| 7 | Чих, хамар, хоолойн эмгэг судлалын кабинет | | 23482 | 10.6 | 10468 | 26 | 2 | 23454 | 19860 | 3594 | 2267 | 2 | 5975 | 17 | | | | | | 17 |
| 8 | Нүдний эмгэг судлалын кабинет | | 11075 | 5.0 | 5316 | 16 | 3 | 11056 | 10426 | 630 | 1186 | | 3207 | 45 | | | | | | 45 |
| 9 | Хараа хамгаалах кабинет | | 11998 | 5.4 | 6420 | | | 11998 | 9725 | 2273 | | | 2608 | 11 | | | | | | 11 |
| 10 | Хоол боловсруулах эрхтний эмгэг судлалын кабинет | | 13262 | 6.0 | 6703 | 259 | | 13003 | 8131 | 4872 | 136 | 2 | 3477 | 381 | 16 | 11 | 6 | | 5 | 386 |
| 11 | Бөөр, шээс ялгаруулах эрхтний эмгэг судлалын кабинет | | 13765 | 6.2 | 6661 | 1454 | 42 | 12269 | 7608 | 4661 | 206 | 1 | 3922 | 211 | 6 | 3 | 3 | | | 214 |
| 12 | Мэдрэлийн эмгэг судлалын кабинет-1 | | 12304 | 5.5 | 5507 | 360 | 0 | 11944 | 7936 | 4008 | 247 | | 3562 | 463 | 22 | | | | | 485 |
| 13 | Мэдрэлийн эмгэг судлалын кабинет-2 | | 12915 | 5.8 | 5944 | 164 | 1 | 12750 | 8138 | 4612 | 93 | | 3426 | 570 | 104 | 8 | 6 | 2 | | 666 |
| 14 | Мэдрэлийн эмгэг судлалын кабинет-3 | | 10456 | 4.7 | 4706 | 197 | | 10259 | 6904 | 3355 | 32 | | 2702 | | | | | | | |
| 15 | Харшлын эмгэг судлалын кабинет | | 5156 | 2.3 | 2678 | | 968 | 4188 | 4149 | 39 | | | 712 | 85 | | 77 | 58 | | | 8 |
| 16 | Цусны эмгэг судлалын кабинет | | 7411 | 3.3 | 3726 | 575 | | 6836 | 4957 | 1879 | 899 | 12 | 2453 | 229 | 50 | 47 | 23 | 16 | 8 | 232 |
| 17 | Эрүү нүүрний мэс заслын кабинет | | 8483 | 3.8 | 3933 | | 2 | 8481 | 7478 | 1003 | 1502 | | 2035 | 4 | | | | | | 4 |
| 18 | Эрүү нүүрний гажиг заслын кабинет-2 | | 1998 | 0.9 | 1045 | 1 | | 1997 | 1800 | 197 | | | 523 | | | | | | | |
| 19 | Шүдний эмчилгээний кабинет №1 | | 2019 | 0.9 | 961 | | 29 | 1990 | 1325 | 665 | | | 483 | | | | | | | |
| 20 | Шүдний эмчилгээний кабинет №2 | | 2989 | 1.3 | 1475 | | | 2989 | 2721 | 268 | | | 768 | | | | | | | |
| 21 | Бөөрний мэс заслын кабинет | | 10948 | 4.9 | 1187 | 246 | 4 | 10698 | 8497 | 2201 | 1102 | | 2823 | 406 | 19 | 69 | 67 | | | 356 |
| 22 | Хэл заслын кабинет | ХЗП-ийн | 3101 | 1.4 | 1031 | | | 3101 | 3010 | 91 | | | 922 | | | | | | | |
| | | ЭНМЗ-ын | | | | | | | | | | | | 150 | | | | | | 150 |
| 23 | Сонсгол заслын кабинет | | 2120 | 1.0 | 788 | 45 | | 2075 | 1089 | 986 | | | 677 | 143 | | | | | | 143 |
| 24 | Өсвөр үеийн клиник | | 6990 | 3.1 | 6918 | | 3 | 6987 | 4210 | 2777 | 14 | | 1108 | | | | | | | |
| 25 | Ревматологи | | 10420 | 4.7 | 5144 | 1 | | 10419 | 6604 | 3815 | 193 | | 2717 | 201 | 30 | 28 | 26 | 2 | | 203 |
| | **2025 оны бүтэн жил** | | **222432** | **100.0** | **106363** | **4458** | **1419** | **216555** | **157242** | **59313** | **9929** | **124** | **59795** | **6864** | **528** | **448** | **319** | **111** | **18** | **6944** |
| | **2024 оны бүтэн жил** | | **214436** | **100.0** | **100548** | **6596** | **218** | **207622** | **153086** | **54536** | **9762** | **408** | **53570** | **6625** | **521** | **282** | **192** | **72** | **18** | **6864** |
| | **Үйл оношзүйн хэсэг** | | 122596 | 100.0 | 64024 | | | 122596 | 122596 | | | | 39049 | | | | | | | |
| | **Түнхний ЭХО** | | 19663 | 100.0 | 10136 | 515 | 2720 | 16428 | 11357 | 5071 | | | 3392 | 135 | 326 | 210 | 205 | 5 | | 251 |

## ДҮГНЭЛТ

1. ЭХЭМҮТ-ийн Хүүхдийн эмнэлэг 2025 онд 424 төсөвт ортой ажилласан.
2. Хүүхдийн эмнэлэгт 18508 хүүхэд хэвтэн эмчлүүлсэн, эдгээрийн 31.6% хөдөө, орон нутгаас ирж үйлчлүүлсэн байна.
3. Хүүхдийн эмнэлэгт нэг оронд дунджаар хэвтэн эмчлүүлсэн өвчтний дундаж тоо буюу орны эргэлт 43.7, орны фонд ашиглалт 335, нэг өвчтнийг эмнэлэгт хэвтүүлэн эмчилсэн дундаж ор хоног 7.7, ор хоногийн төлөвлөгөөний биелэлтийн хувь 101.6 байна.
4. 2025 онд Хүүхдийн эмнэлгийн нас баралтын эзлэх хувь 1.2, хоног болоогүй нас баралтын эзлэх хувь 9.2, задлан шинжилгээ 59.9% байна.
5. Хүүхдийн зөвлөх поликлиникээр 2025 онд 222432 хүүхэд үйлчлүүлсэн ба эдгээрийн 26.9% хөдөө орон нутгаас ирж үйлчлүүлсэн байлаа.

# 6. ЭРЧИМТ ЭМЧИЛГЭЭНИЙ ТАСГУУДЫН ОРНЫ ҮЗҮҮЛЭЛТ, ЭХЭМҮТ, 2021-2025 ОН

Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв 39 төсөвт ор бүхий 4 (нярайн, хүүхдийн, мэс заслын, ЭБЭЭ-ийн) эрчимт эмчилгээний тасаг, 15 ор бүхий нярай судлалын тасгийн эрчимт эмчилгээний хэсэгтэй. 2025 онд ЭХЭМҮТ-ийн нярай судлалын тасгийн эрчимт эмчилгээний хэсэгт 1076 хүүхэд хэвтэн эмчлүүлж өнгөрсөн оноос 4.7% (n=48)-иар, мэс заслын эрчимт эмчилгээний тасагт 2025 онд 421 хүүхэд хэвтэн эмчлүүлж өнгөрсөн оноос 12.0% (n=45)-иар, ЭБЭЭ-ийн эрчимт эмчилгээний тасагт 2025 онд 346 эх, эмэгтэйчүүд хэвтэн эмчлүүлсэн нь 2024 оноос 7.5% (n=24)-иар тус тус өссөн байна.




**Зураг 66. Хэвтэн эмчлүүлэгчид, эрчимт эмчилгээний тасгаар, ЭХЭМҮТ, 2021-2025 он**

ЭХЭМҮТ-ийн эрчимт эмчилгээний тасгуудын ашигласан ор хоногийн үзүүлэлтийг 2021-2025 оны байдлаар зурагт тодорхой харууллаа.




**Зураг 67. Ашигласан ор хоног, эрчимт эмчилгээний тасгаар, ЭХЭМҮТ, 2021-2025 он**

2021-2025 онд ЭХЭМҮТ-ийн нярай судлалын тасгийн дундаж ор хоног болон нярайн эрчимт эмчилгээний тасгийн дундаж ор хоног өнгөрсөн оноос 0.5-аар өссөн бол хүүхдийн мэс заслын эрчимт эмчилгээний тасгийн дундаж ор хоног өнгөрсөн оноос 0.6 пунктээр буурсан байна.




**Зураг 68. Дундаж ор хоног, эрчимт эмчилгээний тасгаар, ЭХЭМҮТ, 2021-2025 он**

ЭХЭМҮТ-ийн эрчимт эмчилгээний тасгуудын орны эргэлт, ор хоногийн төлөвлөгөөний биелэлтийн хувийг тайлангийн жил (2021-2025) тус бүрээр харууллаа. ЭХЭМҮТ-ийн эрчимт эмчилгээний тасгуудын орны эргэлтийг тайлангийн жил тус бүрээр авч үзэхэд 2025 онд нярай судлалын тасгийн эрчимт эмчилгээний хэсгийн орны эргэлт 71.7 байна.




**Зураг 69. Орны эргэлт, эрчимт эмчилгээний тасгаар, ЭХЭМҮТ, 2021-2025 он**




**Зураг 70. Ор хоногийн төлөвлөгөөний биелэлтийн хувь, эрчимт эмчилгээний тасгаар, ЭХЭМҮТ, 2021-2025 он**

ЭХЭМҮТ-ийн эрчимт эмчилгээний тасгуудын ор хоногийн төлөвлөгөөний биелэлтийн хувийг он тус бүрээр дүрслэн харууллаа. ЭХЭМҮТ-ийн нярай судлалын тасгийн эрчимт эмчилгээний хэсэг, нярайн эрчимт эмчилгээний тасгийн ор хоногийн төлөвлөгөөний биелэлт хувь жил бүр 100.0%-иас илүү байгаа нь ажлын ачаалал ихтэй ажиллаж буйг илтгэж байна. Мөн өвчлөл ихсэж, хүнд өвчтний тоо нэмэгдэж байгаа өнөө үед эдгээр тасгуудад төсөвт орыг зайлшгүй нэмэх шаардлага зүй ёсоор гарч буйг илэрхийлж байна.

**Хүснэгт 28. Эрчимт эмчилгээний тасгуудын нас баралт, тоо, хувиар, ЭХЭМҮТ, 2021-2025 он**

| Тасгийн нэр | 2021 | 2022 | 2023 | 2024 | 2025 |
|---|---|---|---|---|---|
| НСТ-ийн эрчимт эмчилгээний хэсэг | 202<br>14.7 | 140<br>12.7 | 117<br>11.3 | 129<br>12.5 | 142<br>13.2 |
| Нярайн эрчимт эмчилгээний тасаг | 50<br>12.4 | 80<br>15.5 | 99<br>18.6 | 79<br>17.2 | 68<br>14.7 |
| Хүүхдийн эрчимт эмчилгээний тасаг | 66<br>13.0 | 79<br>12.8 | 77<br>11.7 | 78<br>12.7 | 74<br>14.0 |
| Мэс заслын эрчимт эмчилгээний тасаг | 4<br>1.1 | 11<br>2.4 | 8<br>1.8 | 6<br>1.6 | 10<br>2.4 |
| Эрчимт эмчилгээний тасаг (ЭБЭЭ) | 1<br>0.3 | 2<br>0.5 | 2<br>0.5 | 2<br>0.6 | 1<br>0.3 |
| ЭБЭЭ-ийн Ковидын ЭЭТ | 12<br>12.1 | | | | |
| ХЭ-ийн Ковидын ЭЭТ | 7<br>8.0 | 2<br>12.5 | | | |

Нярайн эрчимт эмчилгээний тасгийн нас баралтын эзлэх хувь 2024 онд 17.2% байсан бол 2025 онд 14.7% болж өнгөрсөн оноос 2.5%-иар, ЭБЭЭ-ийн эрчимт эмчилгээний тасгийн нас баралтын эзлэх хувь 2025 онд 0.3% болж өнгөрсөн оноос 0.3%-иар тус тус буурсан.

# 7. ЭХЭМҮТ-ИЙН ӨДРИЙН ЭМЧИЛГЭЭ, ӨДРИЙН МЭС ЗАСАЛ, ДАВТАН ХАГАЛГАА, АЛСЫН ДУУДЛАГЫН ТОВЧООН, 2025 ОН

## Өдрийн эмчилгээ

ЭХЭМҮТ-ийн ЦЭХСТ-т өдрийн эмчилгээний үйл ажиллагаа тогтмолжсон ба 2025 онд 83 хүүхэд 484 удаагийн өдрийн эмчилгээнд хамрагджээ. Өдрийн эмчилгээний өвчлөлийг нэршлээр авч үзвэл лейкоз 163 удаа, үүнээс цочмог миелобласт 46 удаа (n=9), цочмог лимфобласт 117 удаа (n=39), Лангерхансын хистиоцитоз 90 удаа (n=9), тархины хавдар 43 удаа (n=7), зөөлөн эдийн хавдар 60 удаа (n=8) дархлаа дарангуйлах эмчилгээ хийлгэжээ. НҮЗП-т 140 эмэгтэй өдрийн эмчилгээнд хамрагдсан нь бүгд өсөлтгүй жирэмсэн оноштой байлаа.

## Өдрийн мэс засал

2025 онд Хүүхдийн эмнэлэгт 3923 хүүхдэд чих, хамар хоолой, ба ерөнхий мэс заслын чиглэлээр өдрийн мэс засал эмчилгээ хийсэн.

Өдрийн мэс заслын эмчилгээний зонхилон тохиолдох шалтгаанд арьсны буглаа, хамрын гэмтэл засах, гадна чихний үрэвсэлт өвчний үеийн мэс заслууд орж байна.

**Хүснэгт 29. Мэс заслын тоо, төрөлжсөн мэс заслын тасгаар, ЭХЭМҮТ, 2025 он**

| № | Тасгийн нэр | Мэс заслын тоо |
|---|---|---|
| 1 | Ерөнхий мэс заслын тасаг | 3421 |
| 2 | Бөөрний мэс заслын тасаг | 1 |
| 3 | Чих, хамар, хоолойн мэс заслын тасаг | 370 |
| 4 | Нүдний мэс заслын тасаг | 21 |
| 5 | Эрүү, нүүрний мэс заслын тасаг | 110 |
| | **Дүн** | **3923** |

## Давтан хагалгаа

2025 онд ЭХЭМҮТ-д нийт **45** давтан хагалгаа бүртгэгдсэн. Үүнээс Эх барих эмэгтэйчүүдийн эмнэлэгт бүртгэгдсэн 24 тохиолдлын 58.3% (n=14)-ийг кесар мэс заслын дараах давтан хагалгаа эзэлж байна.

Хүүхдийн эмнэлгийн мэс заслын тасгуудад бүртгэгдсэн (n=21) давтан хагалгаанд (ЕМЗТ n=10, ЭНМЗТ n=4, БМЗТ n=1, ЦМЗТ n=4, ЧХХМЗТ n=2) хэвлийн гялтангийн үрэвсэл илүүтэй тохиолджээ.

## Дурангийн мэс засал

2025 онд ЭХЭМҮТ-д хийгдсэн дурангийн мэс заслын 502 тохиолдлыг төрөлжсөн нарийн мэргэжлийн тасаг тус бүрээр харууллаа.

**Хүснэгт 30. Дурангийн мэс засал, төрөлжсөн мэс заслын тасгаар, ЭХЭМҮТ, 2025 он**

| № | Тасгийн нэр | Дурангийн мэс засал | |
|---|---|---|---|
| | | тоо | хувь |
| 1 | Ерөнхий мэс заслын тасаг | 73 | 14.5 |
| 2 | Чих, хамар, хоолойн мэс заслын тасаг | 14 | 2.8 |
| 3 | Бөөрний мэс заслын тасаг | 99 | 19.7 |
| 4 | Нярайн эмгэг судлалын тасаг | 1 | 0.2 |
| 5 | Цээжний мэс заслын тасаг | 42 | 8.4 |
| 6 | Эмэгтэйчүүдийн эмгэг судлалын тасаг | 273 | 54.4 |
| | **Дүн** | **502** | **100.0** |

## ЭХЭМҮТ-ийн төрөлжсөн мэргэжлийн тусламжийн дуудлагын үйлчилгээ

ЭХЭМҮТ нь 2025 онд төрөлжсөн мэргэжлийн 20 чиглэлээр эмч, мэргэжилтэнүүд, эрүүл мэндийн 149 бусад эмнэлэг, /эмнэлэг давхардсан/ байгууллагад эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлсэн байна.

**Хүснэгт 31. Мэргэжил аргазүйн туслалцаа үзүүлсэн байдал, дуудлагын төрөл, ЭХЭМҮТ, 2025 он**

| № | Дуудлагын төрөл | ХЭ | ЭБЭЭ | Бүгд |
|---|---|---|---|---|
| 1 | Алсын дуудлагаар хөдөө орон нутагт очиж үйлчилсэн тоо | 13 | 12 | 25 |
| 2 | Хот доторх дуудлагаар очиж мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн тоо | 314 | 121 | 435 |
| 3 | Аймаг, дүүргийн эмч нарт утсаар болон телемедициноэр зөвлөгөө өгсөн тоо | 1414 | 213 | 1627 |
| 4 | Аймаг, дүүргийн эмч нарт онлайнаар болон ZOOM-ээр зөвлөгөө өгсөн тоо | 216 | 29 | 245 |
| | **НИЙТ** | **1957** | **375** | **2332** |

**Эх, хүүхдийн чиглэлээр мэргэжил аргазүйн туслалцаа үзүүлсэн байдал**

| № | Дуудлага (өвчлөлөөр) | 2025 | Хувь |
|---|---|---|---|
| 1 | Нярайн өвчлөл | 280 | 12.1% |
| 2 | Хүүхдийн өвчлөл | 1677 | 71.9% |
| 3 | Эх барих эмэгтэйчүүдийн өвчин эмгэг | 375 | 16.0% |
| | **НИЙТ** | **2332** | **100.0%** |
| | **Зөвлөгөө өгсөн мэргэжлийн чиглэл** | | |
| 1 | Эх барих эмэгтэйчүүдийн чиглэлээр | 375 | 16.1 |
| 2 | Хүүхдийн эрчимт эмчилгээний зөвлөгөө | 383 | 16.4 |
| 3 | Нярайн эмчийн эмчилгээний зөвлөгөө | 280 | 12.0 |
| 4 | Мэс заслын эмчилгээний зөвлөгөө | 193 | 8.3 |
| 5 | Мэдрэлийн эмгэг өвчин | 174 | 7.5 |
| 6 | Цусны хавдрын эмгэг | 157 | 6.7 |
| 7 | Зүрх судас холбогч эдийн эмгэг | 196 | 8.4 |
| 8 | Амьсгалын эрхтэний эмгэг | 78 | 3.3 |
| 9 | Цээжний хөндийн мэс засал | 140 | 6.0 |
| 10 | Бөөрний эмгэг | 70 | 3.0 |
| 11 | Хоол боловсруулах эрхтэний эмгэг, зөвлөгөө | 80 | 3.4 |
| 12 | Рентген дүрс оношилгоо (ЭХО, КТГ ) | 32 | 1.4 |
| 13 | Мэс засал эрчимт эмчилгээний зөвлөгөө | 39 | 1.7 |
| 14 | Чих хамар хоолойн мэс заслын зөвлөгөө | 22 | 0.9 |
| 15 | Дотоод шүүрлийн эмгэг | 45 | 1.9 |
| 16 | Эрүү нүүрний мэс засал | 18 | 0.8 |
| 17 | Нүдний мэс засал | 24 | 1.0 |
| 18 | Бөөрний мэс засал | 19 | 0.8 |
| 19 | Удамзүй | 2 | 0.1 |
| 20 | Мэдээгүйжүүлэх хагалгааны зөвлөгөө | 5 | 0.2 |
| | **Нийт** | **2332** | **100.0** |

## Хүүхдийн эмнэлгийн Мэдээгүйжүүлэг хагалгааны нэгдсэн тасаг

ЭХЭМҮТ-ийн Хүүхдийн эмнэлгийн Мэдээгүйжүүлэг хагалгааны нэгдсэн тасаг (МХНТ) нь тус төвд мэс заслын тусламж авахаар ирсэн 0-18 насны хүүхдүүдэд мэдээгүйжүүлэг, мэс заслын сувилахуйн тусламжийг яаралтай ба төлөвлөгөөт журмаар үзүүлдэг. 2025 онд мэс заслын тусламж авахаар ирсэн 13308 мэс засал, 594 ажилбар хийлгэсэн нийт хүүхдэд (давхардсан тоогоор) 13902 удаа хүүхдийн мэдээгүйжүүлгийн тусламжийг үзүүлжээ. Эдгээрээс 1273 тохиолдолд өндөр эрсдэлтэй мэдээгүйжүүлгийн тусламж үзүүлсэн ба 11850 тохиолдол нь мэдээгүйжүүлгийн дараах өрөөгөөр үйлчлүүлсэн байна.

## Яаралтай тусламжийн тасаг

2025 онд ЭХЭМҮТ-ийн Яаралтай тусламжийн тасгаар нийт 139444 эх, хүүхэд үйлчлүүлсний 75.4% нь Хүүхдийн эмнэлгийн ЯТТ-аар үйлчлүүлжээ.




**Зураг 71. Яаралтай тусламж үйлчилгээ, ЭХЭМҮТ, 2025 он**




**Зураг 72. Хүүхдийн эмнэлгийн Яаралтай тусламжийн тасаг, ЭХЭМҮТ, 2021-2025 он**

# 8. ӨСВӨР ҮЕИЙН КЛИНИКИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ

ЭХЭМҮТ-ийн “Өсвөр үеийн клиник” (ӨҮК) 2014 оны 11 дүгээр сарын 05-ны өдөр нээгдсэн. 2025 онд ЭХЭМҮТ-ийн Өсвөр үеийн клиникээр 8032 хүүхэд үйлчлүүлсэн ба эдгээрийн 85.4% (n=7371) эмчийн үзлэг, 5.6% (n=449) сэтгэл зүйчийн, 2.6% (n=212) нийгмийн ажилтны зөвлөгөө тусламж авсан.

**Хүснэгт 32. Өсвөр үеийн клиникээр үйлчлүүлэгсэд, ЭХЭМҮТ, 2021-2025 он**

| Он | Эмчийн үзлэг | Сэтгэл зүйчийн зөвлөгөө | Нийгмийн ажилтны зөвлөгөө тусламж | Бүгд |
|---|---|---|---|---|
| 2021<br>n (%) | 2260<br>79.3 | 510<br>17.9 | 81<br>2.8 | 2851<br>100.0 |
| 2022<br>n (%) | 3394<br>78.6 | 796<br>18.4 | 127<br>2.9 | 4317<br>100.0 |
| 2023<br>n (%) | 4340<br>78.2 | 982<br>17.7 | 227<br>4.1 | 5549<br>100.0 |
| 2024<br>n (%) | 4497<br>83.8 | 791<br>14.7 | 77<br>1.4 | 5365<br>100.0 |
| 2025<br>n (%) | 7371<br>91.8 | 449<br>5.6 | 212<br>2.6 | 8032<br>100.0 |
| **Нийт<br>n (%)** | **21862<br>83.7** | **3528<br>13.5** | **724<br>2.8** | **26114<br>100.0** |

Хүснэгтээс харахад 2025 онд ӨҮК-ээр эмнэлгийн тусламж, үйлчилгээ авсан (n=7371) хүүхдийн 39.2% (n=2887) 10-14 нас, 35.0% (n=2579) 15-19 насныхан ээлж байсан бол 21.4% (n=1581)-ийг 9-өөс доош насныхан ээлж байв. Мөн ӨҮК-ийн эмнэлгийн тусламж үйлчилгээг эмэгтэй хүүхэд илүүтэй авчээ.

**Хүснэгт 33. Эмнэлгийн тусламж үйлчилгээ, насны бүлэг, хүйсээр, Өсвөр үеийн клиник, 2021-2025 он**

| Он | Нийт үйлчлүүлэгсэд | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Насны бүлэг | | | | | | Хүйс | |
| | | 0-1 | 1-4 | 5-9 | 10-14 | 15-19 | 19 ба дээш | Эр | Эм |
| **2021 n (%)** | 2256<br>100.0 | 12<br>0.5 | 82<br>3.6 | 180<br>7.9 | 1178<br>52.2 | 802<br>35.5 | 6<br>0.3 | 24<br>1.1 | 2236<br>98.9 |
| **2022 n (%)** | 3394<br>100.0 | 27<br>0.8 | 114<br>3.4 | 287<br>8.5 | 1759<br>51.8 | 1207<br>35.6 | | 45<br>1.3 | 3349<br>98.7 |
| **2023 n (%)** | 4340<br>100.0 | 32<br>0.7 | 174<br>4.0 | 471<br>10.9 | 2132<br>49.1 | 1531<br>35.3 | | 70<br>1.6 | 4270<br>98.4 |
| **2024 n (%)** | 4497<br>100.0 | 32<br>0.7 | 231<br>5.1 | 599<br>13.3 | 2117<br>47.1 | 1517<br>33.7 | 1<br>0.02 | 53<br>1.2 | 4444<br>98.8 |
| **2025 n (%)** | 7371<br>100.0 | 73<br>1.0 | 472<br>6.4 | 1086<br>14.7 | 3059<br>41.5 | 2679<br>36.3 | 2<br>0.03 | 74<br>1.0 | 7297<br>99.0 |
| **Нийт n (%)** | **21858<br>100.0** | **176<br>0.8** | **1073<br>4.9** | **2622<br>12.0** | **10244<br>46.9** | **7734<br>35.4** | **9<br>0.04** | **266<br>1.2** | **21592<br>98.8** |

2025 онд ӨҮК-ээр үйлчлүүлж, эмнэлгийн тусламж үйлчилгээ авсан (n=7371) үйлчлүүлэгчдийн 85.9% (n=6328) нь эмэгтэй байжээ. Эдгээр (n=6328) хүүхдийн 7.4% (n=470) хэвлий ба аарцаг орчмын өвдөлт, 19.9% (n=1261) биений юм их хэмжээтэй, ойрхон ба тогтворгүй мөчлөгтэй үзэгдэх, 40.4% (n=2556) үтрээ ба оодойн үрэвсэлт өвчин зэрэг шалтгааны улмаас илүүтэй хандаж, эмнэлгийн тусламж үйлчилгээг авчээ. 2025 онд 20 хүүхэд бэлгийн замаар дамжих халдварын улмаас ӨҮК-д хандсан, эдгээрийн 30.0% (n=6) тэмбүү, 15.0% (n=4) бэлгийн үү, 15.0% (n=4) бэлгийн херпес өвчинтэй байжээ. 2025 онд ӨҮК-ээр үйлчлүүлж, эмчийн үзлэгт хамрагдсан (n=7371) хүүхдийн 129 тохиолдол нь жирэмслэлтийн улмаас эмнэлгийн тусламж үйлчилгээ авсан, эдгээрийн 12.4% (n=16) 15-аас доош, 84.4% (n=109) 15-18 насны хүүхэд ээлж байгаа нь анхаарал татаж байна.

**Хүснэгт 34. Эмнэлгийн тусламж үйлчилгээ, өвчлөлийн бүтцээр, Өсвөр үеийн клиник, 2021-2025 он**

| Онош | 2021 | 2022 | 2023 | 2024 | 2025 |
|---|---|---|---|---|---|
| Үтрээ ба оодойн бусад үрэвсэлт өвчин | 326<br>19.6 | 512<br>(19.7) | 658<br>(19.1) | **673**<br>**(20.6)** | **2556**<br>**(40.4)** |
| Хэвлий ба аарцаг орчмын өвдөлт | 383<br>23.0 | 600<br>(23.1) | 824<br>(23.9) | **770**<br>**(23.6)** | **470**<br>**(7.1)** |
| Биений юм их хэмжээтэй, ойрхон ба тогтворгүй мөчлөгтэй үзэгдэх | 388<br>23.3 | 585<br>(22.6) | 802<br>(23.3) | **880**<br>**(27.0)** | **1261**<br>**(19.9)** |
| Эм бэлэг эрхтэн ба биений юмны мөчлөгтэй холбоотой өвдөлтийн ба бусад байдал | 263<br>15.8 | 453<br>(17.5) | 567<br>(16.5) | 400<br>(12.3) | 1057<br>(16.7) |
| Биений юмгүйдэх, биений юм бага хэмжээтэй ба ховор үзэгдэх | 123<br>7.4 | 232<br>(8.9) | 303<br>(8.8) | 265<br>(8.1) | 678<br>(10.7) |
| Жирэмсэн | 44<br>2.6 | 64<br>(2.5) | 101<br>(2.9) | 98<br>(3.0) | 129<br>(2.0) |
| Хэрцгий харьцах хамшинж (үл хайхрах, бие махбодын, бэлгийн, сэтгэл санааны хүчирхийлэл) | 72<br>4.3 | 76<br>(2.9) | 92<br>(2.7) | 94<br>(2.9) | 81<br>(1.3) |
| Оодой ба үтрээний кандидоз | 58<br>3.5 | 63<br>(2.4) | 85<br>(2.5) | 73<br>(2.2) | 76<br>(1.2) |
| Бэлгийн замаар дамжих халдвар | 10<br>0.6 | 9<br>(0.3) | 10<br>(0.3) | 8<br>(0.2) | 20<br>(0.3) |
| **Бүгд** | **1667**<br>**100.0** | **2594**<br>**(100.0)** | **3442**<br>**(100.0)** | **3261**<br>**(100.0)** | **6328**<br>**(100.0)** |
| Тэмбүү | 11<br>61.1 | 5<br>50.0 | 4<br>44.4 | 3<br>30.0 | 6<br>30.0 |
| Заг хүйтэн | 2<br>11.1 | | | | 3<br>15.0 |
| Трихомониаз | | 2<br>20.0 | 1<br>11.1 | 2<br>20.0 | 3<br>15.0 |
| Бэлгийн үү | 4<br>22.2 | 3<br>30.0 | 3<br>33.3 | 4<br>40.0 | 4<br>20.0 |
| Бэлгийн херпес | 1<br>5.6 | | 1<br>11.1 | 1<br>10.0 | 4<br>20.0 |
| **Бүгд** | **18**<br>**100.0** | **10**<br>**100.0** | **9**<br>**100.0** | **10**<br>**100.0** | **20**<br>**100.0** |

**Хүснэгт 35. Өсвөр насны охидын жирэмслэлт, насны бүлэг, ЭХЭМҮТ, 2021-2025 он**

| Жирэмсэн охидын нас | 2021 | 2022 | 2023 | 2024 | 2025 |
|---|---|---|---|---|---|
| 10-14 нас | 12<br>27.3 | 19<br>29.7 | 51<br>50.5 | **10**<br>**10.2** | **16**<br>**12.4** |
| 15-18 нас хүртэл | 30<br>68.2 | 40<br>62.5 | 42<br>41.6 | **87**<br>**88.8** | **109**<br>**84.5** |
| 18 ба түүнээс дээш нас | 2<br>4.5 | 5<br>7.8 | 8<br>7.9 | 1<br>1.0 | 4<br>3.1 |
| **Нийт** | **44**<br>**100.0** | **64**<br>**100.0** | **101**<br>**100.0** | **98**<br>**100.0** | **129**<br>**100.0** |

**Хүснэгт 36. Хүүхэд, өсвөр насны хүчирхийлэлд өртсөн байдал, ЭХЭМҮТ, 2021-2025 он**

| Сонгосон үзүүлэлтүүд | 2021 | 2022 | 2023 | 2024 | 2025 |
|---|---|---|---|---|---|
| Хүүхдийн эсрэг хүчирхийлэлд өртсөн өгүүлэмжтэй эмнэлгийн тусламж үйлчилгээ авсан хүүхэд | 72<br>100.0 | 76<br>100.0 | 92<br>100.0 | 94<br>100.0 | 68<br>100.0 |
| **ҮҮНЭЭС** | | | | | |
| Бэлгийн хүчирхийлэлд өртсөн | 65<br>90.3 | 62<br>81.6 | 86<br>93.5 | 81<br>86.2 | **46**<br>**67.6** |
| Хүүхдийн эсрэг хүчирхийллийн бусад хэлбэр (бие махбодын, үл хайхрах, сэтгэл санааны), гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн | 7<br>9.7 | 14<br>18.4 | 8<br>8.7 | 13<br>13.8 | 22<br>32.4 |
| **Хүчирхийлэлд өртөн эмнэлгийн тусламж үйлчилгээ авсан өсвөр насны хүүхэд, насны бүлгээр** | | | | | |
| 10 нас хүртэл | 21<br>29.2 | 15<br>19.7 | 22<br>23.9 | 16<br>17.0 | **13**<br>**19.1** |
| 10-16 нас хүртэл | 49<br>68.1 | 51<br>67.1 | 64<br>69.6 | 72<br>76.6 | **34**<br>**50.0** |
| 16-18 нас хүртэл | 1<br>1.4 | 9<br>11.8 | 5<br>5.4 | 5<br>5.3 | 18<br>26.5 |
| 18 ба түүнээс дээш | 1<br>1.4 | 1<br>1.3 | 1<br>1.1 | 1<br>1.1 | 3<br>4.4 |
| Бэлгийн хүчирхийлэлд өртөж жирэмсэн болсон охид | 13<br>18.1 | 16<br>21.1 | 28<br>30.4 | 28<br>29.8 | 12<br>17.6 |
| Бэлгийн хүчирхийлэлд өртөж жирэмслэн, хүүхэд төрүүлсэн охид (өсвөр насны ээж) | 3<br>4.2 | 8<br>10.5 | 9<br>9.8 | | 7<br>10.3 |

2025 онд жирэмслэлтийн улмаас эмнэлгийн тусламж үйлчилгээ авсан (n=129) хүүхдийн 41.1% (n=53) жирэмсний хожуу (12 долоо хоногоос дээш) хугацаанд ӨҮК-т анх хандсан. 2025 онд жирэмслэлтийн улмаас эмнэлгийн тусламж үйлчилгээ авсан (n=129) хүүхдийн 12 тохиолдол нь бэлгийн хүчирхийлэлд өртөж, жирэмсэн болсон байна. 2025 онд ӨҮК-ээр хүчирхийлэлд өртсөн өгүүлэмжтэй (n=68) эмнэлгийн тусламж үйлчилгээ авсан хүүхдийн 67.7% (n=46) бэлгийн хүчирхийлэлд өртжээ. Нийт хүчирхийлэлд өртсөн өгүүлэмжтэй хүүхдийн 19.1%

(n=13) 10 хүртэлх насны, 50.0% (n=34) 10-16 насны хүүхэд ээлж байгаа нь анхаарал татаж байна.

**Сэтгэл зүйчийн тусламж үйлчилгээ:** Сэтгэл зүйч нь өсвөр насныханд тулгамдсан олон талт бэрхшээлтэй асуудлыг шийдвэрлэхэд нь тусалж, тэдний зан үйлийн онцлог, эрсдэлт зан үйлийг илрүүлэх, сэтгэл зүйн байдлыг оношлох, тэдэнд шаардлагатай сэтгэл зүйн үйлчилгээг тодорхойлох, сэтгэлзүйн ба сэтгэл заслын зөвлөгөө өгөх, сэтгэл зүйн боловсрол олгох үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажиллалаа. 2025 онд 449 хүүхэд, өсвөр насныхан, 329 эцэг эх, асран хамгаалагчдад нийт 1044 удаагийн сэтгэлзүйн зөвлөгөө, заслын тусламж үйлчилгээ үзүүлсэн байна.

**Эрүүл мэндийн нийгмийн ажилтны тусламж үйлчилгээ:** 2025 онд нийт 118 хүүхэд, 149 асран хамгаалагчид 212 удаагийн уулзалтаар, 4 төрлийн 6 байгууллагатай хамтран тусламж үйлчилгээ үзүүлсэн. Эрүүл мэндийн нийгмийн ажилтны тусламж үйлчилгээ авсан хүүхэд, өсвөр насныхны 75.4% (n=89) нь эмэгтэй, 24.6% (n=29) нь эрэгтэй хүүхэд байсан бол 14.9% (n=27) нь 10 хүртэлх насны, 77.1% (n=91) нь 10-19 насны үйлчлүүлэгч байлаа. Нийт үйлчлүүлэгчдийн 11.5% нь бэлгийн хүчирхийлэлд, 4.0% биемахбодын, 5.0% сэтгэл санааны, 8.4% амиа хорлох оролдлоготой, 11.5% үл хайхрах хүчирхийлэлд хавсарсан байдлаар өртсөн, 14.2% насанд хүрээгүй жирэмсэн ба үүнээс хүчирхийллийн улмаас жирэмсэн болсон 10.7%, үр хөндөлт хийлгэсэн 7.5% байв. Хүүхдийн эрхийн асуудлын талаар 16.8% цагдаагийн байгууллага, 5.6% гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн хэлтэс, 6.4% яаралтай тусламжийн 108 буюу хүүхдийн шуурхай тусламж, хамгааллын төв, 3.2% хамтарсан баг, 3.2% ӨЭМТ, 17.6% хорооны нийгмийн ажилтан, гэр бүл хүүхэд хариуцсан мэргэжилтэнүүдтэй холбон зуучилж хүүхдийн эрх ашгийн талаар хамтран ажилласан.

## ДҮГНЭЛТ

- ✓2025 онд ӨҮК-ээр үйлчлүүлэгчийн тоо 2024 оноос 27.2%-иар өссөн.
- ✓2025 онд өсвөр насны жирэмсэн үйлчлүүлэгчийн тоо өмнөх оноос өссөн, ялангуяа 15-18 насны жирэмсэн үйлчлүүлэгч 2.2%-иар өссөн нь анхаарал татаж байна. Хүүхдийн эсрэг хүчирхийлэлд өртсөн өгүүлэмжтэй эмнэлгийн тусламж үйлчилгээ авсан хүүхэд, өсвөр насныхныхан өнгөрсөн оноос 27.7% (n=26)-иар буурсан, бэлгийн хүчирхийлэлд өртсөн үйлчлүүлэгчийн тоо 35 тохиолдлоор буурсан, жирэмсэн охидын 9.3% бэлгийн хүчирхийллийн улмаас жирэмсэлсэн зэрэг нь хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийлэл тулгамдсан асуудал болсныг харуулж байна.
- ✓2025 онд ЭХЭМҮТ-ийн сэтгэлзүйч, эрүүл мэндийн нийгмийн ажилтны тусламж үйлчилгээнд хамрагдсан хүүхэд, өсвөр насныхан өмнөх онуудаас буурсан бол эрүүл мэндийн нийгмийн ажилтны тусламж үйлчилгээнд хамрагдсан хүүхэд, өсвөр насныхан өмнөх онуудаас өссөн.
- ✓Хүчирхийлэлд өртсөн хүүхэд, өсвөр насныхны 19.1% (n=13) нь 10 хүртэл насныхан, 50.0% (n=34) нь 10-16 насныхан, 26.5% (n=18) нь 16-18 настай, 4.4% (n=3) нь 18 настай байв.

# 9. ЭХЭМҮТ-ИЙН 2025 ОНЫ САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

## Эрүүл мэндийн даатгал

Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв (ЭХЭМҮТ) нь 2025 онд Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар (ЭМДЕГ)-тай "Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ худалдан авах" 2022 оны 01/002 тоот гэрээ, 2025 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн "Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ худалдан авах гэрээнд өөрчлөлт оруулах тухай" нэмэлт гэрээ УБ-01/002-0001, 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн "Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ худалдан авах гэрээнд өөрчлөлт оруулах тухай" нэмэлт гэрээ УБ-01/002-402 тоот гэрээний дагуу ЭМДҮЗ-ийн 2024 оны "Жагсаалт, төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай" 06 дугаар тогтоолыг 2025 оны 01 дүгээр сараас 2025 оны 03 дугаар сарын 05-ны өдөр хүртэл, шинэчлэгдсэн ЭМДҮЗ-ийн 2025 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 04 дүгээр тогтоолыг 2025 оны 03 дугаар сарын 05-ны өдрөөс, "Чанар, төлбөрийн хяналтын журам" батлах тухай 2022 оны 12 дугаар тогтоолыг мөрдөн ажиллаж гүйцэтгэлийн санхүүжилтийг авсан.

Дараах 11 нэр төрлөөр гүйцэтгэлийн санхүүжилтийг авч байна. Үүнд:

1. Хэвтэн эмчлүүлэх тусламж, үйлчилгээ (6 нэр төрлөөр)
2. Өдрийн мэс засал
3. Хавдрын химийн өдрийн эмчилгээ
4. Амбулаторийн тусламж үйлчилгээ (7 нэр төрлөөр)
5. Өндөр өртөгтэй оношилгоо, шинжилгээ
6. Гемодиализ
7. Алсын дуудлага
8. Телемедицин
9. Яаралтай тусламж, үйлчилгээ
10. Сэргээн засахын тусламж үйлчилгээ (2 нэр төрлөөр)
11. Төлбөрийг нь төр хариуцан амбулаториор олгох эм

**Хүснэгт 37. Батлагдсан санхүүжилт, ЭХЭМҮТ, 2021-2025 он**

| Батлагдсан санхүүжилт | 2021 он | 2022 он | 2023 он | 2024 он | 2024 он |
|---|---|---|---|---|---|
| ЭМД-ын санхүүжилт | 34,299,517.8 | 39,415,586.2 | 46,737,820.2 | 52,454,410.5 | 50,050,200.5 |
| Үндсэн ба туслах үйл ажиллагааны санхүүжилт | 803,950.6 | 1,147,595.1 | 1,147,595.1 | 1,453,057.7 | 2,200,604.0 |
| **Бүгд** | **35,103,468.4** | **40,563,181.3** | **47,885,415.3** | **53,907,468.2** | **52,250,804.5** |

Дээрх батлагдсан төсвөөс ЭМДЕГ-т 2025 онд тусламж үйлчилгээний 57,967,130.3 мянган төгрөгийн гүйцэтгэл олгохоор хянагдсан байна.




**Зураг 73. Эрүүл мэндийн даатгалын сангаас авсан санхүүжилт, ЭХЭМҮТ, 2021-2025 он**

## Эрүүл мэндийн даатгалын санхүүжилтийн бүтэц

2025 онд тус төвийн үндсэн тусламж үйлчилгээний санхүүжилтийн 76.1%-ийг хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээ, 13.5%-ийг амбулаторийн тусламж үйлчилгээ, 5.1%-ийг яаралтай тусламж, 1.3%-ийг амбулаторийн сэргээн засах тусламж үйлчилгээ, 1.2%-ийг өдрийн мэс засал, 0.9%-ийг амбулаторийн өндөр өртөгтэй оношилгоо, шинжилгээ, 0.7%-ийг амбулаториор олгох төр даах эм, 0.5%-ийг хорт хавдрын химийн өдрийн эмчилгээ, 0.5%-ийг гемодиализ, телемедицин, алсын дуудлагын тусламж үйлчилгээ эзэлж байна.




**Зураг 74. ЭМД-ын санхүүжилтийн бүтэц, хувиар, ЭХЭМҮТ, 2025 он**

## Хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ

Хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээнд эрчимт эмчилгээ, мэс засал эмчилгээ, эмийн эмчилгээ, төрлөг, хавдрын химийн эмчилгээ, эрхтэн шилжүүлэн суулгах зэрэг 6 төрлөөр санхүүжилт авлаа. 2025 онд элэг шилжүүлэн суулгах мэс засал 3 хүүхдэд, бөөр шилжүүлэн суулгах мэс засал 2 хүүхдэд хийж санхүүжилтийг ЭМДС-аас бүрэн авсан. Хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээнээс ХЭ-ийн 19 тасаг, ЭБЭЭ-ийн 6 тасаг санхүүжилт авч байна. Хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээнд “Жагсаалт, төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай” ЭМДҮЗ-ийн 2025 оны шинэчилсэн 04 дүгээр тогтоол, тусламж үйлчилгээний хяналтаар түүвэрлэн авсан түүхийг “Чанар, төлбөрийн хяналтын журам” батлах тухай 2022 оны 12 тоот тогтоолыг мөрдөж ажилласан.




**Зураг 75. Хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээний санхүүжилт, ЭХЭМҮТ, 2021-2025 он**

Хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээний санхүүжилтийн 71.1%-ийг Хүүхдийн эмнэлэг, 28.9%-ийг Эх барих эмэгтэйчүүдийн эмнэлэг бүрдүүлсэн байна.

Хүснэгт 38. Хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээний санхүүжилт, тасгаар, ЭХЭМҮТ, 2025 он

| № | Тасгууд | Хүний тоо | Мөнгөн дүн | Хувь |
|---|---|---|---|---|
| 1 | Амьсгалын эрхтний эмгэг судлалын тасаг | 2,142 | 910,158,720.0 | 2.1 |
| 2 | Бөөр, дотоод шүүрлийн эмгэг судлалын тасаг | 684 | 777,508,944.0 | 1.8 |
| 3 | Бөөрний мэс заслын тасаг | 1,136 | 1,255,617,248.0 | 2.8 |
| 4 | Ерөнхий мэс заслын тасаг | 2,275 | 2,411,809,768.0 | 5.5 |
| 5 | Зүрх судас, холбогч эдийн эмгэг судлалын тасаг | 816 | 1,545,751,440.0 | 3.5 |
| 6 | Мэдрэлийн эмгэг судлалын тасаг | 1,517 | 968,486,520.0 | 2.2 |
| 7 | Мэс заслын эрчимт эмчилгээ | 328 | 1,369,151,672.0 | 3.1 |
| 8 | Нүдний мэс заслын тасаг | 1212 | 1,017,654,625.0 | 2.3 |
| 9 | Нярай судлалын тасгийн эрчимт эмчилгээ | 767 | 4,783,202,192.0 | 10.8 |
| 10 | Нярай судлалын тасгийн эрүүл нярай | 323 | 420,871,920.0 | 1.0 |
| 11 | Нярайн эмгэг судлалын тасаг | 1,472 | 1,399,692,632.0 | 3.2 |
| 12 | Нярайн эрчимт эмчилгээ | 386 | 3,134,991,708.0 | 7.1 |
| 13 | Хоол боловсруулах эрхтний эмгэг судлалын тасаг | 968 | 800,608,760.0 | 1.8 |
| 14 | Хүүхдийн эрчимт эмчилгээ | 491 | 2,476,865,376.0 | 5.6 |
| 15 | Цусны эмгэг хавдар судлалын тасаг | 1069 | 3,111,162,960.0 | 7.1 |
| 16 | Цээжний мэс засал | 378 | 758,106,080.0 | 1.7 |
| 17 | Чих хамар хоолойн мэс заслын тасаг | 2439 | 3,077,525,840 | 7.0 |
| 18 | Эрүү нүүрний мэс заслын тасаг | 1615 | 1,159,597,160.0 | 2.6 |
| 19 | Яаралтай тусламжийн тасаг | 1 | 239,000.0 | 0.001 |
| | **ДҮН /ХЭ/** | **19,240** | **25,403,517,778.0** | **72.1** |
| 20 | Эмэгтэйчүүдийн эмгэг судлалын тасаг | 790 | 639,657,915.0 | 1.4 |
| 21 | Эмэгтэйчүүдийн дотоод шүүрлийн эмгэг судлалын тасаг | 883 | 391,479,000.0 | 0.9 |
| 22 | Эмэгтэйчүүдийн мэс заслын | 1,005 | 871,914,600.0 | 2.0 |
| 23 | Дутуу тээлт судлалын тасаг | 1,138 | 803,009,240.0 | 1.8 |
| 24 | Төрөх тасаг, төрсний дараах тасаг | 7,775 | 6,936,914,395.0 | 15.7 |
| 25 | Эрсдэлтэй жирэмсэн судлалын тасаг | 3,418 | 1,885,124,095.0 | 4.3 |
| 26 | Эрчимт эмчилгээ (ЭБЭЭ) | 268 | 1,212,633,000.0 | 2.7 |
| | **ДҮН /ЭБЭЭ/** | **15,277** | **12,740,732,245.0** | **28.9** |
| | **ЭХЭМҮТ** | **35,296** | **44,119,495,810.0** | **100.0** |

## Өдрөөр эмчлэх тусламж, үйлчилгээ

Өдрийн эмчилгээнээс (өдрийн мэс засал) 4058 даатгуулагчаас 715,767,7 мян.төгрөгийн санхүүжилт авсан нь 2024 оноос 25.6% (246,588.3 мян.төг) дутуу байна. Өдрийн мэс заслын тусламж үйлчилгээний санхүүжилтийн 75,9.0%-ийг Ерөнхий мэс заслын тасаг, 17.2%-ийг Чих хамар хоолойн мэс заслын тасаг, 3.4%-ийг Нөхөн үржихүйн зөвлөх поликлиник, 2.8%-ийг Эрүү нүүрний мэс заслын тасгууд бүрдүүлсэн.




Зураг 76. Өдрийн эмчилгээний санхүүжилт, ЭХЭМҮТ, 2021-2025 он

Хүснэгт 39. Өдрийн эмчилгээний санхүүжилт, ЭХЭМҮТ, 2025 он

| № | Тасгийн нэр | Даатгуулагчийн тоо | Мөнгөн дүн /төгрөгөөр/ | Нийт санхүүжилтэд эзлэх хувь |
|---|---|---|---|---|
| 1 | Ерөнхий мэс заслын тасаг | 3414 | 543,026,300.0 | 75.9 |
| 2 | Чих хамар хоолойн мэс заслын тасаг | 377 | 122,975,200.0 | 17.2 |
| 3 | Эрүү нүүрний мэс заслын тасаг | 115 | 20,341,200.0 | 2.8 |
| 4 | Нүдний мэс заслын тасаг | 15 | 4,739,000.0 | 0.7 |
| 5 | Бөөрний мэс заслын тасаг | 1 | 156,000.0 | 0.0 |
| | **ХҮҮХДИЙН ЭМНЭЛЭГ** | **3,922.0** | **691,237,700.0** | **96.6** |
| 6 | Нөхөн үржихүйн зөвлөх поликлиник | 136 | 24,530,000.0 | 3.4 |
| | **ЭХ БАРИХ ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ЭМНЭЛЭГ** | **136** | **24,530,000.0** | **3.4** |
| **НИЙТ** | | **4058** | **715,767,700.0** | **100.0** |

Өдрийн мэс заслын 80.0%-ийг Ерөнхий мэс заслын тасаг, 13.0%-ийг Чих хамар хоолойн мэс заслын тасаг, 6.5%-ийг Нөхөн үржихүйн зөвлөх поликлиник тусламж үйлчилгээ үзүүлсэн байна.

## Хорт хавдрын өдрийн хими эмчилгээ

ХЭ-ийн Цусны эмгэг хавдар судлалын тасаг дээрх тусламж үйлчилгээг өдрөөр үзүүлж байна. 2025 онд өмнөх оноос 2.1% (6,435.0 мян.төг)-иар илүү санхүүжилт авсан.




Зураг 77. Хорт хавдрын химийн өдрийн эмчилгээ, ЭХЭМҮТ, 2021-2025 он

## Амбулаторийн тусламж, үйлчилгээ

2025 онд амбулаторийн тусламж үйлчилгээнээс 7 нэр төрлөөр гүйцэтгэлийг авлаа. Үүнд:

1. Амбулаторийн цогц тусламж, үйлчилгээ
2. Амбулаторийн үзлэг
3. Амбулаторийн хяналт, эмчилгээ оношилгоо, шинжилгээ
4. Шүд амны хөндийн амбулаторийн тусламж, үйлчилгээ
5. Амбулаторийн мэс ажилбар
6. Жирэмсний хяналтын багц
7. Сэтгэл зүйн үзлэг, зөвлөгөө

Амбулаторийн тусламж үйлчилгээний санхүүжилтийн дийлэнхийг (70.4%) Хүүхдийн зөвлөх поликлиникийн санхүүжилт эзэлж байна.




Зураг 78. Амбулаторийн санхүүжилт, ЭХЭМҮТ, 2021 - 2025 он

Хүснэгт 40. Амбулаторийн санхүүжилт, ЭХЭМҮТ, 2024-2025 он

| Д/д | Тасгийн нэр | 2024 он | | | 2025 он | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | Хүний тоо | Мөнгөн дүн | Хувь | Хүний тоо | Мөнгөн дүн | Хувь |
| 1 | Хүүхдийн Зөвлөх поликлиник | 156,170 | 4,916,282,623 | 70.42 | 159,611 | 5,524,468,877 | 70.40 |
| 2 | Нөхөн Үржихүйн Зөвлөх поликлиник | 42,212 | 1,674,981,592 | 23.99 | 40,580 | 1,886,775,912 | 24.04 |
| 3 | Ургүйдэл нөхөн үржихүйн төв | 5,152 | 206,808,906 | 3.0 | 4,528 | 261,243,133 | 3.3 |
| 4 | Дэмжих төв | 3,936 | 158,556,498 | 2.3 | 3,244 | 158,174,985 | 2.0 |
| 5 | Удамзүйн лаборатори | 958 | 25,082,840 | 0.4 | 759 | 16,245,615 | 0.2 |
| **ДҮН** | | **208,428** | **6,981,712,459** | **100.0** | **208,722** | **7,846,908,522** | **100.0** |

Амбулаторийн тусламж үйлчилгээнээс 208,722 үйлчлүүлэгчийн 7,846,908.5 мянган төгрөгийн санхүүжилт авсан нь 2024 оноос 12.4% (865,196.1 мян.төг)-иар илүү байна. Энэ нь 2024 оны 04 сараас эхлэн мөрдөж байгаа ЭМДҮЗ-ийн 06, 2025 оны ЭМДҮЗ-ийн 04 дүгээр тогтоолуудын зохицуулалтаар амбулаториор хийгдэж байгаа өндөр өртөгтэй дүрс оношилгоо болон лабораторийн шинжилгээнүүд амбулаторийн цогц тусламж, үйлчилгээнд ордог болсонтой холбоотой.

### Өндөр өртөгтэй оношилгоо, шинжилгээ

Амбулаториор хийгдэх өндөр өртөгтэй шинжилгээг 2024 оноос ЭМДҮЗ-ийн 06 дугаар тогтоолоор шинжилгээ тус бүрээр нэхэмжлэл үүсдэг байсныг үзлэгтэй нэгтгэн амбулаторийн цогц тусламж үйлчилгээгээр нэхэмжилдэг болсон. ЭМДЕГ-аас төрөлжсөн нарийн мэргэжлийн тусламж үйлчилгээ үзүүлдэг, улсын хэмжээнд ганцхан байдаг лабораторийн оношилгоо, шинжилгээнд санхүүжилт өгөх шийдвэр 2024 оны 12 дугаар сард гарснаар Удамзүйн лабораторийн өндөр өртөгтэй шинжилгээнүүдээс 2025 онд санхүүжилт авсан. Үүнд: Жирэмсэн эхчүүдэд хийгдэх хоёрол тест, ургийн усны шинжилгээ, захын цусны кариотипын шинжилгээнд 3,987 хүний 537,268.4 төгрөгийн санхүүжилт авсан.




Зураг 79. Амбулаторийн өндөр өртөгтэй оношилгоо, шинжилгээ, ЭХЭМҮТ, 2021-2025 он

### Яаралтай тусламж

Яаралтай тусламжийн тасгаар үзүүлж тусламж, үйлчилгээ аваад буцсан (хянагдаж олгохоор тооцсон) хүний нэхэмжлэлийн тоо 2024 онд 11,727 үйлчлүүлэгчээр нэмэгдсэн ч 2023-2024 онуудад мөрдөж байсан ЭМДҮЗ-ийн 01, 08, 06 дугаар тогтоолуудын өөрчлөлтөөр санхүүжилт өмнөх оноос 35.0% (1,565,341.2 мян,төг)-иар буурсан бол 2025 онд шинэчилсэн ЭМДҮЗ-ийн 04 дүгээр тогтоолыг мөрдөж ажиллан санхүүжилт 2024 оноос 2.1% (62,260.1 мян.төг)-иар илүү санхүүжилт авсан байна.




Зураг 80. Яаралтай тусламжийн санхүүжилт, ЭХЭМҮТ, 2021-2025 он

**Хүснэгт 41. Яаралтай тусламж, ЭХЭМҮТ, 2025 он**

| Д/д | Тасгийн нэр | Хүний тоо | Мөнгөн дүн | Хувь |
|---|---|---|---|---|
| 1 | Хүүхдийн эмнэлгийн яаралтай тусламжийн тасаг | 70,800 | 2,374,091,308.0 | 80.0 |
| 2 | ЭБЭЭ-ийн яаралтай тусламжийн тасаг | 15,465 | 594,617,980.0 | 20.0 |
| **ДҮН** | | **86,265** | **2,968,709,288.0** | **100.0** |

## Бусад тусламж, үйлчилгээ

ЭМДҮЗ-ийн тогтоолын дагуу гемодиализ, амбулаторийн сэргээн засах, алсын дуудлага, телемедицинээс санхүүжилт авч байна.

**Хүснэгт 42. Гемодиализийн санхүүжилт, ЭХЭМҮТ, 2025 он**

| № | Үйлчлүүлэгчийн тоо | Сеансын тоо | Мөнгөн дүн |
|---|---|---|---|
| 1 | 32 | 1409 | 239,570,400.0 |

**Хүснэгт 43. Телемедицины санхүүжилт, ЭХЭМҮТ, 2025 он**

| № | Телемидицин | Мөнгөн дүн |
|---|---|---|
| 1 | 453 | 25,959,000.0 |

**Хүснэгт 44. Алсын дуудлагын санхүүжилт, ЭХЭМҮТ, 2025 он**

| № | Дуудлагын төрөл | | 2023 | |
|---|---|---|---|---|
| | | | Хүний тоо | Мөнгөн дүн |
| 1 | Ойрын дуудлага | 25 км хүртэл | 8 | 744,000,0 |
| 2 | Алсын дуудлага | 70-450 км | 17 | 7,956,000,0 |
| | | 450-800 км | 14 | 11,648,000,0 |
| | | 800 км-ээс дээш | 7 | 10,920,000,0 |
| **Дүн** | | | **46** | **31,268,000,0** |




**Зураг 81. Телемидицины санхүүжилт, ЭХЭМҮТ, 2021-2025 он**

## Сэргээн засах тусламж, үйлчилгээ, ЭХЭМҮТ, 2025 он

Амбулаториор үзүүлж буй сэргээн засах тусламж үйлчилгээнээс 2021 оны 10 дугаар сараас эхлэн санхүүжилт авч эхэлсэн. 2025 онд амбулаторийн сэргээн засах эмчийн үзлэг, өдрөөр хийгдэх сэргээн засах эмчилгээнээс ХЭ-ийн сэргээн засах тасаг, ЭБЭЭ-ийн сэргээн засах тасгууд санхүүжилт авсан.

**Хүснэгт 45. Сэргээн засах эмчилгээний санхүүжилт, ЭХЭМҮТ, 2025 он**

| Д/д | Тасгийн нэр | Амбулаторийн үзлэг | | Өдрийн эмчилгээ | |
|---|---|---|---|---|---|
| | | Хүний тоо | Мөнгөн дүн | Хүний тоо | Мөнгөн дүн |
| 1 | Хүүхдийн эмнэлгийн сэргээн засах тасаг | 4538 | 90,906,400,0 | 1534 | 531,586,200,0 |
| 2 | ЭБЭЭ-ийн сэргээн засах тасаг | 2466 | 48,568,000,0 | 333 | 77,603,400,0 |
| **Нийт Дүн** | | **6960** | **139,474,400,0** | **1867** | **609,189,600,0** |




**Зураг 82. Сэргээн засах тусламж, үйлчилгээний санхүүжилт, ЭХЭМҮТ, 2021-2025 он**

### Төлбөрийг нь төр хариуцан амбулаториор олгох эм

Хүүхдийн эмнэлгийн Хүүхдийн зөвлөх поликлиникийн дотоод шүүрлийн булчирхайн эмгэг судлалын кабинетын хяналтын хүүхдүүдэд эмийг олгож санхүүжилт авч байна. 2025 онд 7 нэр төрлийн эмийг олгож **415,924.5** мянган төгрөгийн санхүүжилт авсан байна.

**Хүснэгт 46. Төлбөрийг төр хариуцан амбулаториор олгох эмийн санхүүжилт, ЭХЭМҮТ, 2025 он**

| Д/д | Эмийн нэр | Тун хэмжээ | Тоо ширхэг | Санхүүжилт |
|---|---|---|---|---|
| 1 | Новорапид | 100 оун 3 мл | 4642 | 145,581,920.0 |
| 2 | Тресиба | 100 оун 3 мл | 3677 | 239,464,300.0 |
| 3 | Минирин | 7 мл | 65 | 2,860,000.0 |
| 4 | Л Тироксин | 50 мкг | 7931 | 1,534,338.0 |
| 5 | Нордитропин | 10 мг-1.5 мл | 67 | 17,688,000.0 |
| 6 | Десонап | 7 мл | 140 | 8,400,000.0 |
| 7 | Метлонг | 500 мг | 2800 | 396,000.0 |
| | **Нийт дүн** | | **19322** | **415,924,558.0** |

## Дүгнэлт

- 2025 оны шинэчилсэн ЭМДҮЗ-ийн 04 дүгээр тогтоолыг 2025 оны 03 дугаар сарын 05-ны өдрөөс эхлэн мөрдөж уг тогтоолын 700 оношийн хамааралтай бүлэг (ОХБ)-т цочмог өвчний үеийн, төлөвлөгөөт, архаг тусламж үйлчилгээг оруулсан бөгөөд төлөвлөгөөт болон архаг оношийн хамааралтай бүлгийг ЭМДЕГ-аас тогтоосон төсөвт багтаан санхүүжилтийг авсан.
- Нэхэмжлэлийн нийт хасагдлын хувь 4.7% болж 2024 оноос 2.7%-иар буурсан.
- 2025 онд сард нийт хянагдсан гүйцэтгэл 2024 оноос 9,657,563.8 мянган төгрөгөөр (19.9%)-иар өссөн.
- 2025 оны 01-12 сард 2024 оноос хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ 25.2%, амбулаторийн тусламж, үйлчилгээ 12.4%, гемодиализ 25.1%, сэргээн засахын амбулаторийн үзлэг болон өдрийн эмчилгээ 12.5%, яаралтай тусламж үйлчилгээний санхүүжилт 2.1% хувиар тус тус өссөн.
- ЭМДЕГ-ын нэхэмжлэлийн хяналт сар бүр ЭМДҮЗ-ийн 2022 оны 12 дугаар тогтоолын шалгуур үзүүлэлтээр хийгдэж хэвтэн эмчлүүлэгсдийн нэхэмжилсэн өвчний түүхийн (n=22,388) 61.3%, яаралтай тусламжийн хуудас шалгуураар шалгагдах G ангиллаас бусад нь (n=16,547) 100% түүвэрлэгдэн хянагдсан.
- Өдрийн мэс засал өнгөрсөн оны мөн үеэс 25.6%-р буурсан.
- Өндөр өртөгтэй оношилгоо шинжилгээ 18.7%-иар буурсан нь ЭМДҮЗ-ийн тогтоолын өөрчлөлтөөр амбулаториор хийгдэж буй өндөр өртөгтэй оношилгоо шинжилгээнд зөвхөн ЭБЭЭ-ийн удамзүйн лабораторийн шинжилгээнд санхүүжилт авч байгаагаас шалтгаалан буурсан.

## ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ЗАРЦУУЛАЛТ

2025 онд төсөвлөгдсөн нийт зардлын 42.0% цалинд, нийгмийн даатгалын шимтгэл 16.0%-ийг эзэлж байна. Байр ашиглалтын зардал 3.0%, хангамж, бараа материалын зардал 1.0%, норматив зардал 36.0%, эд хогшил, урсгал засварын зардал 1.0%, томилолт, зочны зардал 0.03%, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал 0.2%, бараа үйлчилгээний бусад зардал 0.5%-ийг эзэлж байна.

## Цалин хөлс, нэмэгдэл урамшуулал

Цалин хөлс, нэмэгдэл урамшуулал гүйцэтгэлээр 30.349.552.3 төлөвлөгдөж 30.349.552.3 төгрөгийн гүйлгээ хийгдсэн байна. Үүнээс, үндсэн цалин 12.883.589.2 төгрөг, нэмэгдэл 13.809.740.8 төгрөг, унаа, хоолны хөнгөлөлт 1.120.249.3 төгрөг, урамшуулалд 2.535.972.9 төгрөг зарцуулсан.




**Зураг 83. Цалин хөлс, нэмэгдэл урамшуулал, ЭХЭМҮТ, 2025 он (мян.төг)**

## Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлсөн шимтгэл

Нийгмийн даатгалын шимтгэлд 2025 онд нийт 3.415.242.9 төгрөг төвлөрүүлснээс тэтгэврийн даатгалд 2.135.780.7 төгрөг, тэтгэмжийн даатгалд 282.694.8 төгрөг, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах даатгалд 97.984.1 төгрөг, ажилгүйдлийн даатгалд 68.708.3 төгрөг, эрүүл мэндийн даатгалд 830.074.9 төгрөг төлсөн байна.




**Зураг 84. Нийгмийн даатгалын шимтгэл, ЭХЭМҮТ, 2025 он (мян.төг)**

## Байр ашиглахтай холбоотой тогтмол зардал

Нийт 2,060,593.1 төгрөг зарцуулалттай байснаас гэрэл цахилгаанд 1,090,161.9 төгрөг, түлш халаалт 392,273.2 төгрөг, цэвэр, бохир ус 578,158 төгрөг зарцуулсан.




**Зураг 85. Тогтмол зардал, ЭХЭМҮТ, 2025 он (мян.төг)**

## Хангамж бараа материалын зардал

Нийт 815,374.4 төгрөг зарцуулсанаас бичиг хэрэгт 79,999.9 төгрөг, тээвэр шатахуунд 59,190.0 төгрөг, шуудан холбоо, интернетийн төлбөрт 29,903.7 төгрөг, хог хаягдал зайлуулах, хортон мэргэгч устгах, ариутгалд 441,937.0 төгрөг, бага дүнтэй түргэн борлогдох ахуйн эд зүйлс 204,343.6 төгрөг тус тус зарцуулсан.




**Зураг 86. Хангамж бараа материалын зардал, ЭХЭМҮТ, 2025 он (мян.төг)**

## Норматив зардал

Нийт 13,662,398.4 төгрөг зарцуулснаас эм, эмнэлэгийн хэрэгсэлд 12,323,068.8 төгрөг, хоол хүнсэнд 1,034,072.8 төгрөг, нормын хувцас, зөөлөн эдлэлд 305,256.7 төгрөгийг тус тус зарцуулсан.




**Зураг 87. Норматив зардал, ЭХЭМҮТ, 2025 он (мян.төг)**

## Эд хогшил урсгал засварын зардал

Нийт 844,745.3 төгрөг зарцуулсанаас багаж техник хэрэгсэлд 501,243.4 төгрөг, Хөдөлмөр хамгааллын хэрэгсэлд 6,546.0 төгрөг, урсгал засвар 336,955.8 төгрөг тус тус зарцуулсан.




**Зураг 88. Эд хогшил урсгал засвар, ЭХЭМҮТ, 2025 он (мян.төг)**

### Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж

Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөрт 63,242.0 төгрөг, Аудит бат, зэрэглэл тогтоох 16,500.0 төгрөг, даатгалын үйлчилгээнд 110,062.6 төгрөг, мэдээлэл технологийн үйлчилгээнд 50,000.0 төгрөг, газрын төлбөр 16,136.3 төгрөг, улсын тэмдэгтийн маягт хэвлэх, бэлтгэх 27,883.4 төгрөг зарцуулсан.




**Зураг 89. Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал, ЭХЭМҮТ, 2025 он (мян.төг)**